

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2011 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР

Лианона



**Тэр бол амилалт ба
амь мөн х. 4, 12**

**Бурханы бүхнийг чадагч
Хүүгийн гэрчлэл х. 16**

**Бид төлж чадахааргүй их
өртэй учраас х. 56**

**Хүүхдийн уран зургийн
үзэсгэлэн: Сайн мэдээ миний
амьдралыг адисалдаг х. 62**



© SCALA/ART RESOURCE, НЬОУ/ЮРК

Эссе Хомо (Тэр хүнийг харагтун!) Антони Цисери

“Пилат ахлах тахилчид, захирагчид болон ард олныг дуудаад тэдэнд:

“Ард олныг бослогод өдөөн турхирагч гэж энэ хүнийг та нар над уруу авчирсан. Харагтун, энэ хүнийг би та нарын өмнө байцаагаад, Түүний эсрэг та нарын мэдүүлээд байгаа гэм бурууг ер олсонгүй. . . .

“Иймд Түүнийг би цээрлүүлээд суллая гэжээ.

“(Пилат баярын үеэр нэг хоригдлыг сулладаг уламжлалтай байв.)

“Тэтэл цугласан олон бүгдээрээ, Наад хүнээ ав. Харин бидэнд Барабасыг суллаж өг гэж хашигиралдав. . . .

Пилат Есүсийг суллахыг хүсч, тэдэнд дахин үгээ хэлэв.


“Гэвч тэд Түүнийг цовдол, цовдол хэмээн хашигирсаар байлаа.

“Пилат гурав дахь удаагаа тэдэнд Яагаад? Энэ хүн ямар бузар мууг үйлдсэн юм бэ? Үхлийн шалтгаан болох ямар ч гэм бурууг би Түүнээс олсонгүй. Тийм учраас би Түүнийг цээрлүүлээд суллая гэхэд

“харин ч тэд чангаар хашигиран Түүнийг цовдохыг шаардан, тэдний дуу хоолой дийлэв. . . .

“Тийнхүү Пилат тэдний шаардлагыг биелүүлэхээр шийджээ.

“. . . Тэрбээр Есүсийг тэдний мэдэлд тушаав”
(Лук 23:13–14, 16–18, 20–25).



ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Тэр энд байхгүй, харин амилсан.

Ерөнхийлөгч Томас С.Монсон

7 Айлчлагч багшийн захиас бичиг: Нийгмийн Халамжийн Бүлгийн зорилго

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

20 Түүнийг үргэлж санахын тулд

Ахлагч Д.Тодд Кристофферсон
Аврагчийг санахад бидэнд тусалдаг гурван зам байдаг.



ХАВТСАН ДЭЭР
Амар амгаланг Битанарт үлдээнэ
Уолтер Рейн, Сүмийн түүхийн музейн зөвшөөрлөөр нийтлэв.

28 Ребека Свейн Виллямс:
Тууштай бөгөөд гуйвшгүй

Жаниес Лин Жонсон

Тэр эмэгтэй бүр гэрийнхний хээ дотроос эсэргүүцэлтэй тулгарсан ч сайн мэдээнд итгэлтэй хэвээр үлджээ.

32 Маршаллын арлууд уруу далайгаар зөв замаар хөвдөг байсан нь

Жошуа Ж.Перки

Нарийн бөгөөд давчуу замд орох замаа олохдоо зарим үед бид бусдаас тусламж авах шаардлагатай байдаг.

ХЭСГҮҮД

8 Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс

11 Сүмд үйлчилсэн нь: “Энэ бүхэн намайг адисалдаг”
Майкл Р.Моррис

12 Бид юунд итгэдэг вэ?:
Есүс Христ бидний нүглийг цагаатгасан

14 Бид Христийн тухай ярьж байна: Наманчил, Их Эзэнд ханд, тэгвэл эдгэрнэ
Давид Л.Фришнехт

16 Сайн мэдээний сонгомол бүтээл: Гетсеманий ариусгагч хүч
Ахлагч Брус Р.МкКонки

38 Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой

74 Сүмийн мэдээ

79 Гэр бүлийн үдшийн санаанууд

80 Биднийг дахин уулзтал: Үүргэнэн титэм, Ялалтын титэм
Ларри Хиллер



42

42 Үүрдийн гэрээ

Марта Валенсия Ваквиз

Би залуу эмэгтэй байхдаа нэг өдөр ариун сүм уруу явахаар шийдэж билээ. Гэтэл тэр үед Коста Рикад ариун сүм байсангүй.

44 Эцэст нь сонссон нь

Нэрийг нууцлав

Маделинтай болзож байх үеийн турш Сүнс намайг зөвхөн өндөр жишигтэй хүмүүстэй болз гэж өдөөсөн юм.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Санаа: үзэсгэлэнт гүнж.

46 Асуулт, хариулт

“Бид сүмд явдаг, гэр бүлийн үдэш хийдэг, сайн мэдээгээр амьдрахыг хичээдэг ч, манай гэр бүлд яагаад олон асуудал байдаг юм бол? Бид юу хийж болох вэ?”

48 Үзүүлэн: Түүнийг үргэлж сана

49 Шат шатаар: Сургаал ба Гэрээ 76:22–24

50 Сэргээн босгоход оролцсоны баяр

Ашли Дайер

Газар хөдлөлтөд нурсан барилгуудын нуранги дотор би хувь хүнийхээ үнэ цэнийг мэдэрч билээ.

52 Судрын хүч

Адам К.Өүлсон

Тахитийн өсвөр насны энэ хоёр хөвгүүнд судар судлах шалтгаан л хэрэгтэй байжээ.

55 Номлолын талбараас:

Миний адислалын хөтөч

Скотт Талбот

56 Есүс Христ Зууч

Ерөнхийлөгч Боид К.Пакер

Зээлдэгч, зээлдүүлэгч хоёрын тухай сургаалт зүйрлэл нь шударга ёс, нигүүлсэл, Цагаатгалыг ойлгоход бидэнд тусалдаг.

50



70

59 Нияагийн сонголт

Марсел Ниюнжи

Дэлгүүрийн эзэн түүнд мөнгө хариулахдаа илүү өгснийг мэдээд сонголт хийх хэрэгтэй болсон гэнэ.

60 Улаан Өндөгний баярын долоо хоног

Бид Улаан Өндөгний баярыг ганицхан өдөр тэмдэглэдэг ч, энэ нь Аврагчийн амьдрал дахь үйл явдлуудын бүтэн долоо хоногтой тэнцдэг.

62 Дэлхий дахины Хүүхдийн уран зургийн үзэсгэлэн

Загасчид, ариун сүмүүд, номлогчид болон бусад зүйлс.

65 Тусгай гэрч: Би дэлхийн муу зүйлсээс хэрхэн ангижирч чадах вэ?

Ахлагч Ричард Г.Скотт

66 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Есүс Христ бол миний Аврагч бөгөөд Гэтэлгэгч

Ана Мариа Кобурн, Кристина Франко нар

68 Гэртээ аз жаргалтай байдаг

Чад Э.Фарез
Камбож ах, эгч хоёр аз жаргалынхаа талаар өгүүлж байна.

70 Бага насны хүүхдүүдэд зориулав



**2011 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР
ЛИАХОНА 09684 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын албан ёсны сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Байд К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Пол Б.Пайпер

Зөвлөхүүд: Станли Ж.Эллис, Кристоффел Голден Бага.,
Ёшико Кикучи

Гүйцэтгэх захирал: Давид Л.Фричнехт

Редакцийн захирал: Винсент А. Вон

Зургийн дарга: Аллан Р.Лоиборг

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх туслах редактор: Женифер Л.Грийнвүүд,
Адам К.Өүлсон

Туслах редактор: Раян Карр

Редакторын туслах: Сюзан Баррет

редакцийн ажилтнууд: Давид А.Эдвардс, Маттью
Д.Флиттон, Лаврина Портер Гаунт, Ларри Хиллер, Карри
Кастен, Женифер Мэдди, Меллиса Меррил, Майкл
Р.Моррис, Салли Ж.Одекерк, Жошуа Ж.Перки, Чад
И.Фарес, Жан Пинбург, Ричард М.Ромни, Жанет Томас,
Паул ВанДенберг, Жюли Варделл

Ахлах нарийн бичгийн дарга: Ж.Скот Нудсон

Гүйцэтгэх Зургийн захирал: Ж.Скот Нудсен

Зургийн захирал: Скот Ван Кампен

Уран бүтээлийн менежер: Жейн Анн Петерс

Дизайны болон уран бүтээлийн ажилтнууд: Кали
Р.Арроэ, Коллетт Небекер Аун, Ховард Ж.Браун, Жюли
Бёрдетт, Томас С.Чайлд, Региналд Ж.Кристенсен, Ким
Фенстермейкер, Катлийн Ховард, Эрик П.Жонсен, Денис
Керби, Скотт М.Мооё, Жинни Ж.Нилсон
Хэвлэлийн эх бэлтгэгч: Жефф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен

Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон
үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн төв болон
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

**Гар бичмэл болон асуултаа Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:**
liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Liahona нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд,
испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш,
маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш,
португали, румын, самоа, себуано, солонгос, тагалог, тай,
тахити, тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц,
хорват, хятад, чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг.
(Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2011 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Liahona дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

April 2011 Vol. 12 No. 2. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December)
by The Church of Jesus Christ of Latter-day Saints,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA
subscription price is \$5.00 per year; Canada, \$6.00 plus
applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City,
Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new
address *must* be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address
below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card
orders (Visa, MasterCard, American Express) may be taken by
phone. (Canada Poste Information: Publication Agreement
#40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake Distribution
Center, Church Magazines, PO Box 26368, Salt Lake City, UT
84126-0368.

Дэлгэрэнгүй мэдээллийг онлайнаас үзэж болно Liahona.lds.org

НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ





Маршаллын арлууд дахь **хөрвөл-
тийн түүхүүдийг уншина уу** (хуудас
32) мөн www.liahona.lds.org хаягаар
тэдний тухай олон гэрэл зураг үзэж
болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



Тахитийн өсвөр насны хоёр хөвгүүн
төгс эзэмших судар дээр анхаарал
төвлөрүүлэхээр шийдсэнээрээ
амьдралаа өөрчилж чаджээ (х. 52).
www.seminary.lds.org хаягаас **дэлгэ-
рэнгүй мэдээллийг үз.**

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ



Хуудас 62-оос олон улсын

уран зургийн үзэсгэлэнд оролцсон **23 зургийг**
үзнэ үү мөн бусдыг нь www.liahona.lds.org
хаягаар орж үзэж болно.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Liahona болон Сүмийн бусад материалуудыг олон хэлээр
www.languages.lds.org –оос олж үзэж болно.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа болно.

Авралын төлөвлөгөө,
41

Авьяас, 62

Ажил эрхлэлт, 9

Амилуулалт, Амилалт,

4, 16, 49, 60

Ариун Сүнс, 44

Ариун ёслол, 20, 48

Бошиглогчид, 10

**Бурханлиг шинж
чанар,** 70, 72

бэрхшээл, 46

Гэр бүл, 46

Гэрээнүүд, 42

Есүс Христ, 4, 12, 14,
16, 20, 48, 49, 56, 60,
66, 80

Ёс суртахуун, 42, 44

Жишгүүд, 44

Залбирал, 40

Зөв шударга байдал,

65

Идэвхжүүлэлт, 32

Итгэл, 32

Наманчлал, 12, 14,

32, 39

Нигүүлсэл, 56

Нийгмийн

Халамжийн Бүлэг, 7

Номлолын ажил, 28,

55

Семинар, 52

Судар судлах, 52, 68

Сүмийн түүх, 8

Сүмийн удирдагчид, 9

Уран зураг, урлаг, 62

Үйлчлэл, 11, 41, 50

Үлгэр дуурайл, 32

Хайр, 41

Хувь хүний үнэ цэнэ,

50

хөрвөлт, хөрвүүлэг,

28, 32, 38

Цагаатгал, 12, 14, 16,

39, 66

Шинэ Гэрээ, 60

Шударга ёс, 59

Шударга ёс, шударга

байдал, 56

Эдгээлт, 80

Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Тэр энд байхгүй, харин амилсан.

Нуурын эрэгт, Аврагчийн Галил дахь үйлчлэлийн гол төв байсан Капернаум эдүгээ баалсан болжээ. Тэр энд синагогт номлож, тэнгисийн эрэг дээр зааж, хүмүүсийг гэр оронд нь эдгээж байлаа.

Есүс үйлчлэлийнхээ эхэнд: “Эзэн Бурханы Сүнс миний дээр байна. Учир нь Эзэн намайг зовогсдоод сайн мэдээг дэлгэрүүлэхийн тулд томилсон юм. Тэр намайг шаналсан зүрхтэй хүмүүсийг эдгээн олзлогдогсдоод эрх чөлөөг тунхаглаж, хүдээстэй хүмүүсийг чөлөөлөхийн тулд илгээсэн юм” (Исаиа 61:1; мөн Лук 4:18-ыг үз) хэмээн Исаиагаас эш татсан нь Бурханы хөвгүүд, охидыг аврах тэнгэрлэг төлөвлөгөөг албан ёсоор тодорхой зарласан хэрэг байлаа.

Гэвч Галил дахь Есүсийн номлол зөвхөн эхлэл байсан юм. Хүний

Хүүг Голгота хэмээх толгод дээрх аймшигтай хувь тохиол нь хүлээж байсан билээ.

Сүүлчийн үдшийн зоогийн дараа Есүс Гетсеманий Цэцэрлэгт баривчлагдаж, дагалдагчид нь орхин, Түүнийг нулимж, шүүх хурлаар байцаасны дараа, хүнд загалмайгаа үүрэн Калварийг чиглэн хөлөө зөөж ядан сажилж явлаа. Тэрээр ялгуусан байдлаасаа урвалт, тамлалт, эцэст нь загалмай дээрх үхэл уруу гулсан буусан.

“Ариун хот” гэдэг дууны үгсэд:

*Уйтгартай дүнсгэр Калвари
толгой дээр . . .*

*Уршигт загалмай муу ёрлон
боссон*

*Хүйтэн жихүүн тэр өглөө
Хүй юмс бүгд өөрчлөгдлөө.¹*

Тэнгэрлэг Эцэг бидний төлөө Хүүгээ өгсөн юм. Ууган Ах минь

бидний төлөө алтан Амиа өгсөн юм.

Эцсийн мөчид Эзэн эргэж болох байв. Гэвч Тэр тэгсэнгүй. Тэр бүхнийг, хүн төрөлхтнийг, газар дэлхийг, үүн дээр орших амьтай бүхнийг аврахын төлөө бүхнээс доогуур бууж ирсэн юм.

Магдалын Мариа, нөгөө Мариа хоёр Их Эзэнийхээ цогцсыг янзлахаар уйлан хайлж, булш уруу хүрч ирэхэд: “Та нар юунд үхэгсдийн дунд амьд Нэгнийг хайна вэ?”

“Тэр энд байхгүй, харин Тэр амилсан” (Лук 24:5–6) хэмээн тэнгэр элчийн хэлсэн үгсээс илүү чухал үгс миний хувьд Христийн ертөнцөд үгүй билээ.

Энэ дэлхий дээр нэгэн цагт амьдарч байгаад нас барсан, одоо амьдарч байгаа ч нэгэн өдөр хорвоог орхих, эдүгээ хараахан төрөөгүй ч нэгэн өдөр төрж, дараа нь нас барах бүх хүн дээрх мэдэгдлээр аврагдах болно.

Үхлийг ялсан Христийн ялалтын ачаар бид бүхэн амилуулагдах болно. Энэ бол бодгалийн гэтэлгэл мөн. Паул бичихдээ:

“ . . . Тэнгэрлэг биес ба газрын биес гэж байдаг. Харин тэнгэрлэг биесийн алдар өөр, газрын биесийн алдар өөр юм.

“Нарны алдар өөр, сарны алдар өөр, одны алдар өөр байдаг. Од одноосоо алдраараа ялгардаг.

“Үхэгсдийн амилаалт нь мөн тийм байна” (1 Коринт 15:40–42).



ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Сайн багш нар заадаг хүмүүсийнхээ эв нэгдлийг урамшуулан дэмждэг. Хүмүүс бодол санаагаа хуваалцаж, бие биеийнхээ үгийг хүндэтгэлтэйгээр сонссон үед суралцах таатай орчныг мэдэрдэг төдийгүй улам эв нэгдэлтэй болдог (*Teaching, No Greater Call* [1999], 63-ыг үз). Та өөрөө болон

заадаг хүмүүс тань Есүс Христийн Цагаатгал ба Түүний Амилалтын тухай гэрчлэлээ хүндэтгэлтэйгээр хэлсэн үед тэдний эв нэгдэл батжих болно. Энэхүү эв нэгдэл нь “мөнхийн гэр бүл” болох тухай Ерөнхийлөгч Монсонгийн зөвлөгөөг дагахад нь гэр бүлүүдэд туслах болно.

Энэ бол бидний эрэлхийлдэг селестиел аддар суу билээ. Энэ бол бид Бурханы дэргэд амьдрахыг хүсдэг гэсэн үг юм. Энэ нь бид гэр бүлийн гишүүдтэйгээ үүрд мөнх хамт байхыг хүсдэг гэсэн үг юм.

Бидний хүн нэг бүрийг төгсгөлгүй үхлээс чөлөөлсөн Түүнийг бибээр үнэний багш хэмээн гэрчилж байна. Гэвч Тэрбээр зүгээр нэг багштай эн зэрэгцэхгүй Нэгэн. Тэр бол төгс төгөлдөр амьдралын үлгэр жишээ мөн. Гэвч Тэр зүгээр нэг үлгэр жишээнээс хавьгүй дээгүүр Нэгэн. Тэр бол агуу эмч. Гэвч зүгээр нэг эмчээс хавьгүй илүү Нэгэн. Тэр бол шууд утгаараа дэлхийн Аврагч, Бурханы Хүү, Энхийн хунтайж, Израилын Ариун Нэгэн, бүр “Бибээр эхнийх мөн эцсийнх болой; Бибээр амьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрбээр бөлгөө; бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ” (С ба Г 110:4) хэмээн тунхагласан, амилсан Их Эзэн мөн.

‘Би Гэтэлгэгч амьдыг мэднэ’ гэсэн энэ өгүүлбэр надад хэчнээн сайхан баяр баяслыг бэлэглэдэг билээ!”²

Үүнийг би гэрчилж байна. ■

ЭШЛЭЛ


1. Фредерик Э.Ветерли, “The Holy City” (1892).
2. “Би Гэтэлгэгч амьдыг мэднэ” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу* х. 38.





ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Тэр бидэнд гэртээ эргэж очих замыг заасан



“Хэрэв бид тэнгэрт зохиогдсон төлөвлөгөөгөөр амьдрах юм бол, биднийг аз жаргалтай болгох тэрхүү төлөвлөгөөний дагуу хэрхэн амьдрахыг бидэнд үзүүлэхээр Аврагч дэлхийд хүрч ирсэн. Түүний үлгэр жишээ Тэнгэрлэг Эцэгтээ, гэртээ эргэж очих замыг бидэнд заасан. Дэлхий дээр амьдарч байсан өөр нэг ч хүн хэзээ ч ийм ‘хичээнгүй мөн гуйвшгүй’ (Мозая 5:15) байгаагүй юм. Тэр хэзээ ч гуйвж байсангүй. Тэрээр Эцэгийн хүслийг биелүүлэхэд анхаарлаа төвлөрүүлж, Бурханлиг үүрэг зорилгодоо үнэнч хэвээр үлдсэн билээ . . .

“Та нар бол мөнх бус байдлын өмнөх амьдралд танилцуулагдсан тэрхүү гайхамшигтай төлөвлөгөөний хэсэг мөн. Тэр төлөвлөгөөг хүлээн авсан учраас та нар дэлхийд ирэх боломжтой болсон билээ. Та нарын энд байгаа цаг хугацаа, газар орон тохиолдлын зүйл биш. Хэрэв итгэлтэй, дуулгавартай байх юм бол та нарын ‘үлэмжийн итгэл хийгээд сайн үйлс’ (Алма 13:3) тань одоо хийж болох зүйлийн тань үндэс суурь нь болно. . . . та нарт хийх агуу ажил байна. Та бүхэн бурханлиг үүрэг зорилгоо биелүүлж, аз жаргалын төлөвлөгөөний дагуу амьдрахын тулд гуйвшгүй, тууштай хичээнгүй байх ёстой.”

Элайн Далтон, Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч, “At All Times, in All Things, and in All Places, *Лиахона*, 2008 оны 5-р сар, 116.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Бид мөнхийн гэр бүл байж чадна

Бид Аврагчийн Цагаатгалын хүчээр дамжуулан Бүхлийн дараа гэр бүлтэйгээ дахин хамт байж чадна гэдгийг Ерөнхийлөгч Монсон заадаг билээ. Доорх зааврыг баримталснаар гэр бүлийг хамтад нь авчир.

Заавар: Зүүн тал дахь гэр бүлийн гишүүд үхлээр бие биеэсээ болон Аврагчаас тусгаарлагджээ. Энэ хуудсыг хувилах буюу www.lds.org-аас хэвлэж ав. Эсвэл Аврагч хэрхэн биднийг хамтад нь цуглуулдгийг дүрсэлсэн зургийг өөрөө зур. Хуудасны доод тал дахь одод харанхуй хэсгийг халхалж бие биетэйгээ зэрэгцэж байхаар цэгтэй зураасын дагуу хуудсыг нугал.





Нийгмийн Халамжийн Бүлгийн зорилго

Энэ материалыг залбиран судалж, гэрт нь очиж заадаг эгч нарт аль болох ойлгомжтойгоор харилцан ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд чинь идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Манай ерөнхийлөгчийн зөвлөл анх дуудагдахад Нийгмийн Халамжийн Бүлгийн түүхийн тухай зарим лавлах материалуудыг бидэнд өгч билээ. Бид эдгээр материалыг залбирч судлахдаа Нийгмийн Халамжийн бүлгийн зорилго болон бидний үйлчлэлийн үед Их Эзэн биднээс юу хүсэн хүлээдгийг мэдэхийг хүссэн юм. Бид уг түүхийг анхааралтай судалснаар, Их Эзэний үндэслэн байгуулсан Нийгмийн Халамжийн Бүлгийн зорилго нь Түүний охидыг мөнх амьдралын адислалуудад бэлтгэхэд нь зохион байгуулах, заах, сүнслэгээр нөлөөлөх явдал мөн.

Их Эзэн, Нийгмийн Халамжийн Бүлгийн энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд эгч бүрд болон энэ байгууллагад дараах зүйлсийг хийх итгэмжлэл хүлээлгэсэн билээ:

1. Итгэл болон хувийн зөв шударга байдлаа өсгөн нэмэгдүүлэх.
2. Гэр орон, гэр бүлүүдийг бэхжүүлэх.
3. Их Эзэн болон Түүний хүүхдүүдэд үйлчилснээр бусдад туслах.

Бид хувийн илчлэлтийг эрэлхийлэн, хүлээн авч, түүний дагуу үйлдсэнээр энэ ажлыг Их Эзэний арга замаар хийж чадна. Бид хувийн илчлэлтгүйгээр амжилт олж чадахгүй. Хэрэв бид хувийн илчлэлтэд анхаарал төвлөрүүлбэл бүдрэхгүй. Ариун Сүнс “[бидний] хийвэл зохих тэр бүх зүйлийг” (2 Нифай 32:5) бидэнд үзүүлэх болно хэмээн бошиглогч Нифай зааварласан юм. Бид өөрсдөдөө Сүнсний дуу хоолойг нам гүм орчинд маш анхааралтай сонсох нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Эгч нар аа, бид Бурханы хаант улсыг байгуулах болон Их Эзэний ирэлтэнд бэлтгэхэд туслах нэн чухал үүрэгтэй билээ. Үнэн хэрэгтэй Их Эзэний ажлыг Түүний охидын туслацаагүйгээр амжилттай хийж чадахгүй юм. Тийм учраас Их Эзэн биднээс хувь нэмрээ нэмэгдүүлэхийг хүсэн хүлээдэг. Тэрээр Нийгмийн Халамжийн Бүлгийг урьд нь хэзээ ч байгаагүйгээр үүргээ амжилттай биелүүлэхийг хүсэн хүлээдэг.

Жюли Б.Бек, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч.

Судруудаас

Дэд Хууль 6:5–7; Лук 10:30–37;
Иаков 1:27; 2 Нифай 25:26; Мозая 3:12–13

Итгэл, хувийн зөв шударга зан төлөвийн үлгэр жишээ болсон эмэгтэйн тухай 28-р хуудсаас уншина уу.

Би юу хийж чадах вэ?

1. Эгч нартаа итгэл, хувийн зөв шударга байдлаа нэмэгдүүлж, гэр бүлээ бэхжүүлэхэд нь туслахын тулд би сүнсний ямар удирдамж хүлээн авсан бэ? Би яаж болох вэ?

2. Би итгэл, зөв шударга байх тууштай санаа бодлоо бэхжүүлэхэд энэ захиасыг хэрхэн ашиглах вэ?

Нэмэлт мэдээллийг www.reliefsocietylds.org-аас үзнэ үү.

Эшлэл

1. Иосеф Смит, *History of the Church*, 5:25.
2. *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 185
3. М.Рассел Баллард, “Women of Righteousness,” *Лиакхона*, 2002 оны 12-р сар, 39.

Бидний түүхээс

Бошиглогч Иосеф Смит 1842 оны 6-р сарын 9-нд Нийгмийн Халамжийн Бүлгийн хурал дээр, эгч нарын нийгэмлэг “зөвхөн ядуучуудад туслах төдийгүй, бодгалиудыг аврах” ёстойг заасан юм.¹ Энэхүү сүнслэг болон материаллаг зорилго нь Нийгмийн Халамжийн Бүлгийг бүх түүхийнх нь туршид тодорхойлж ирсэн. 1906 онд Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит (1838–1918): “[Нийгмийн Халамжийн Бүлэг] зөвхөн ядуучууд, өвчтэй болон тусламж хэрэгтэй хүмүүсийн эн тэргүүний хэрэгцээг шийдвэрлэх төдийгүй, түүний үүргийн нэг хэсэг, бүр томоохон хэсэг нь Сионы эхчүүд болон охидын сүнсний сайн сайхан байдал ба авралд анхаарал тавих явдал мөн. Эдгээр үүргийн алинд нь ч хайхрамжгүй хандаж болохгүй, зовлон зүдгүүр, гай гамшиг, харанхуйн хүч, дэлхийд тэдэнд заналхийлэгч аливаа хилэнцээс бүхнийг хамгаалах ёстой” гэж заажээ.² 2001 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард, “Их Эзэнтэй хийсэн гэрээнүүд, энэ Сүмийн эгч бүр хүмүүсийг аврах, дэлхийн эмэгтэйчүүдийг удирдах, Сионы гэр бүлүүдийг бэхжүүлэх, Бурханы хаант улсыг байгуулахад туслах, заавал биелүүлэх бурханлиг үүрэгтэй юм” хэмээн давтан хэлжээ.³



Өчүүхэн бөгөөд энгийн зүйлс

“Агуу болох тэрхүү зүйл жижиг зүйлүүдээс гарч ирдэг” (С ба Г 64:33).

СҮМИЙН ТҮҮХ ДЭЛХИЙ ДАХИНАА



Маршаллын арлууд

Сүмийн гишүүд Дэлхийн II Дайны үеэр Маршаллын арлуудад очсон ч 1977 оны 2-р сарыг хүртэл тэнд номлолын ажил албан ёсоор эхлээгүй ажээ. Тэр жил Хавайн Хонолулу Номлолын Ахлагч Виллям Уордел, Ахлагч Стивен Купер нар энэ бүсэд ажиллахаар томилогджээ. Маршаллын арлуудад ажиллахаар шилжсэн Сүмийн гишүүн Эдред Феюкесийн тусалцаатайгаар тэд сүмийн барилгад Сүмийн үйлчлэл зүүлэх ажлыг зохион байгуулсан гэнэ.

Номлогчид эхний жил 27 хөрвөгчид баптисм хүртээв. Маршаллын арлууд гурван жилийн дараа Микронезийн Гуам номлолын хэсэг болов. 1984 онд Махуро

Маршаллын арлуудад Дүүрэг зохион байгуулагдав. Сүмийн гишүүнчлэл цаашид өссөөр 1991 онд Квахалейн шүрэн арал дээр хоёр дахь дүүргийг байгуулжээ. 2006 онд Маршаллын арлуудын Махуро Номлол байгуулагдав. Дараагийн гурван жилд идэвхжүүлэх ажлын үр дүнд идэвхтэй гишүүд, хөрвөгчдийн баптисмын тоо үлэмж өсч, орон нутгийн удирдлага хүчтэй болжээ. Үүний үр дүнд 2009 оны 6-р сарын 14-нд Махуро Гадас зохион байгуулагдав.

Маршаллын арлууд дахь гишүүдийн итгэл, хөрвөлтийн тухай түүхүүдийг хуудас 32-оос уншина уу.

Чуулганаас суралцахуй

Манай хүүхдүүд өсч том болоод өөрсдийн гэр бүлийг зохиосон ч бошиглогчдын үгсээс хамтран суралцах сайн аргыг олж мэдээд байна. Ерөнхий чуулган бүрийн дараагийн сард би www.conference.lds.org-аас хэлсэн үгсийг судалж, удирдамж чиглэл, тайтгарал өгсөн эшлэлүүдийг сонгож авдаг. Ингээд дараагийн зургаан сарын туршид өдөр бүр нэг эшлэл цуглуулдаг. (Жишээ нь: тавдугаар сарын 1-нээс аравдугаар сарын 31-нийг дуустал өдөр бүр судлах нэг эшлэлийг би 4-р сард олдог.) Тэгээд эдгээр эшлэлүүдийг хувилж, хүүхэд бүрдээ өгнө.

Эдгээр эшлэлүүд чуулганы үгсийг судлах тэдний хувийн судалгаан дээр нэмэлт материал, гэр бүлийн гишүүдийн ярианы сэдэв болдог. Ерөнхий чуулганы дараагийн саруудад бошиглогчдын зөвлөгөөг нэгтгэн дүгнэх нь хэдийгээр бид бие биеэсээ олон километрийн зайд амьдардаг ч, гайхалтай туршлага болж байна.

Кристин Типпеттс, Юта, АНУ

МАРШАЛЛЫН АРЛУУД ДАХЬ СҮМ

МАРШАЛЛЫН АРЛУУД ДАХЬ СҮМ	
Гишүүнчлэл	4,486
Номлол	1
Гадас	1
Дүүрэг	1
Тойрог/салбар	11

Бага Ж.Рюбен Кларк ховорхон авьяастай хүн



Жошуа Рюбен Кларк 1871 оны 9-р сарын 1-нд Ютагийн Грантсвиллд төржээ. Тэрээр албан ёсны багахан боловсролтой байснаас гадна ахлах сургуульд орох боломжгүй байснаас ээж нь түүнд зааж хүмүүжүүлжээ. Тэр сурч мэдэх дуртай байсан гэнэ. Тэр эхлээд Ютагийн Их Сургуульд дөрвөн жил суралцаж төгсөөд, Нью-Йорк хот дахь Колумбын Их Сургуульд хуулиар эрдмийн зэрэг хамгаалахаар суралцсан аж.

Кларк ах Люсин Аннетта Сейвижтэй 1898 онд Солт Лейкийн Ариун сүмд гэрлэж, тэд дөрвөн хүүхдийн эцэг эх болжээ.

Хуулийн эрдмийн зэрэгтэй, сод ухаантай Бага Ж.Рюбен Кларк

хуулийн болон иргэний албан тушаалуудад гялалзсан амжилттайгаар дэвшиж, 1930 онд түүнийг Мексикт суух АНУ-ын элчин сайдаар томилжээ. Гэвч Кларк ах 1933 оны 4-р сарын 6-нд Тэргүүн Зөвлөл дэх Ерөнхийлөгч Хебер Ж.Грантын Хоёрдугаар зөвлөхөөр дэмжигдэн батлагдсанаар тэрхүү албан тушаалаа өгсөн юм. Тэр үед тэрээр дээд прист байсан ч Ерөнхий эрх мэдэлтэн байсангүй. Тэр дараа нь 1934 оны 10-р сард Ерөнхийлөгч Грантын Нэгдүгээр зөвлөхөөр дэмжигдэн батлагдахдаа Төлөөлөгчөөр томилогдсон

Ерөнхийлөгч Кларк (зүүн талд) номлолын ерөнхийлөгч Леймонт Торонтогийн хамт.



Тэргүүн Зөвлөл 1945 онд (зүүн талаас): Бага Ж.Рюбен Кларк, Хебер Ж.Грант, Давид О.МкКей.

байна. Ерөнхийлөгч Кларк Ерөнхийлөгч Жорж Альберт Смит, Давид О.МкКей нарын зөвлөхөөр үргэлжлүүлэн үйлчилсэн юм.

Сүмд оруулсан түүний хувь нэмрийн дотор Давид О.МкКейг Сүмийн Ерөнхийлөгч болоход түүний харуулсан даруу байдлын жишээ онцгой ялгардаг. Ерөнхийлөгч Кларкийг Хоёрдугаар Зөвлөхөөрөө дуудсан ажээ. Ерөнхийлөгч Кларк өмнөх Тэргүүн Зөвлөлдэд Нэгдүгээр зөвлөхөөр үйлчилж байсан учраас албан тушаал бага зэрэг буурч байгаа юм шиг байсан ч, Ерөнхийлөгч Кларк: “Их Эзэний үйлчлэлд хаана гэдэг нь биш харин хэрхэн гэдэг нь чухал юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд хүн зохих ёсоор дуудагдсан дуудлагаа л авдаг болохоос дуудлагыг өөрөө хүсэх юм уу түүнээс татгалздаг ёс байхгүй” хэмээн тайлбарлажээ.¹

Ерөнхийлөгч Кларк 1961 оны 10-р сарын 6-нд нас баржээ.

ЭШЛЭЛ

1. Бага Ж.Рюбен Кларк, Conference Report, 1951 оны 4-р сар, 154.

ХҮГ-ИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТӨВИЙН СУРГАЛТ

ХҮГ Ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх төвүүд нь ажил хайж байгаа, сургуульд орох буюу бизнес эхлэхийг хүссэн хүмүүст туслахын тулд сургалт

явуулдаг. Сургалт нь хүмүүст ажил эрхлэлтийн зорилгоо тодорхойлох, амжилт олох чадвартаа итгэх итгэлийг хөгжүүлэхэд тусалдаг. Сургалтыг заавар зөвлөгөө өгөх, харилцан ажиллах, урам дэм өгөхийн хамт хөгжилтэй байлгахыг зорьдог. Сургалтаар сурч мэдсэн зүйлээ хэрэглэдэг хүмүүс сургалтанд хамрагдажгүйгээр ажил эрснээс хурдан хугацаанд ажил олдог

болох нь олонтаа тохиолдож байна.

Ажил мэргэжлийн зорилго тавих, уг зорилгодоо хүрэх нөөц боломжуудыг олох, товч анкет намтраа бичих, шинэ ажилдаа хэрхэн амжилт гаргах зэрэг сэдвүүдээр сургалт явуулдаг.

Сургалт явагддаг газрыг мэдэхийн тулд бишоп, салбарын ерөнхийлөгчөөсөө асуух буюу www.ldsjobs.org-г орж, “Find a Center” дээр дар.

“ЗАЛУУ НАСНЫХАА ӨДРҮҮ- ДЭД ӨӨРИЙН БҮТЭЭГЧЭЭ САНАГТУН” (НОМЛОГЧИЙН ҮГС 12:1)

Судрууд бошиглогчид болон төлөөлөгчдийн үйлчлэлийг он дарааллаар өгүүлсэн байдаг. Тэдгээр удирдагчдын ихэнх нь залуу наснаасаа Бурханыг мэддэг байлаа. Ирээдүйн удирдагчдын заримынх нь туршлагыг дүрсэлсэн судрын таван шастирыг доор өгөв.



- “Их Эзэний ирэлтэнд” хүмүүсийг бэлтгэхээр дуудагдсан Иохан Баптист “энэхүү хүчинд түүнийг Бурханы тэнгэр элч томилоход тэр төрөөд найман өдөр болж байв” (С ба Г 84:27–28).



- Иосиа найман настайдаа хаан болж, 31 жил хаанчлахдаа иудейчүүдийг сайн мэдээнд хөрвөгдөхөд тусалжээ (Хаадын Дэд 22-ыг үз).

- Аммарон Мормоныг цэдгүүдийн (Нифайн ялтсууд) дараагийн эзэмшигчээр сонгож авахад тэр 10 орчим настай байв. Мормон 16 орчим настайдаа Нифайчуудын их цэргийг удирдаж байв. (Мормон 1:2–4; 2:1–2-ийг үз.)



- Давид, Голиатыг устгах үед “идэр настан” (залуу эр), Хиламаны армийн дайчидтай үе чацуутан байсан бололтой (1 Самуел 17:49–56; Алма 53:22-ыг үз).



- Иосеф Египетэд худалдагдахдаа 17-той байлаа. Тэнд “Эзэн Иосефтой хамт байлаа” (Эхлэл 37:2, 27–28; 39:2-ыг үз).



“Энэ бүхэн намайг адисалдаг”

Майкл Р.Моррис

Сүмийн сэтгүүлүүд

Бямба гараг бүрд Элвира Гуаглиарелло эгч өмнөд Чубут муж дахь Аргентины Нуево Булангийн эрэг дээр байдаг Пуэрто Мадрин дахь гэрийнхээ гал тогоонд зав чөлөөгүй ажилладаг.

Тэр эхлээд гурил, усыг дараа нь бусад орцуудыг нарийн хэмжиж эхэлнэ. Тэр хэчнээн бага ажиллалаа ч гэсэн ажил үйлс нь үг хэлнээс нь ямагт илүү байдаг гэв. Эцсийн эцэст тэр эмэгтэй Их Эзэний зараалд байдаг хүн.

Гуаглиарелло эгч хоолны орцуудаа тохируулж, холих зуураа, “Би сайн юм хийж байгаагаа мэддэг учраас санаа зовох зүйл байдаггүй” гэлээ. Тэр ажил хийж байхдаа Аврагчийн тухай бодож, үйлчлэл нь Түүнийг санахад Сүмийн бусад гишүүдэд тусалдаг гэж бодохоос баяртай байдаг ажээ.

“82 настай Гуаглиарелло эгчид айлчлагч багшаар үйлчлэх нь таалагддаг бөгөөд тойрогтоо хөгжим удирдахад тусалж, ариун ёслолд хэрэглэх талх барьдаг гэнэ. Тэр энэ дуудлагат ажлаа бараг 10 жил идэвх зүтгэл гарган хийж байгаа

аж. Тэр өөрийнхөө идэх нэг талхыг долоо хоногийн эхээр барьдаг, харин хагас сайн өдөр бүр Сүмд зориулан талх барьдаг” гэж ярилаа. “Би талх барих ёстой, бас Сүмдээ явах ёстой. Бүдрэхийг хүсэхгүй байна” гэж би өөртөө хэлдэг.

Эрүүл мэнд нь хэвийн байвал тэр Аргентины Буэнос Айресын Ариун сүм уруу хойд зүгт жил бүр 20 цаг автобусаар аялдаг гэнэ.

“Гуаглиарелло эгч чадах чинээгээрээ үйлчлэхдээ үргэлж баяртай байдаг” гэж түүний бишоп Жесус Сантос Гумиел хэлэв. “Түүнд итгэл найдвар хүлээлгэж болно гэдгийг тойргийн гишүүд мэддэг. Тэр хэдийгээр нас өндөр болсон ч хагас сайн өдөр бүр талх барих бас бүтэн сайн өдөр бүр сүмдээ явахыг хэзээ ч мартдаггүй хүн. Тэр бол үнэхээр сайн үлгэр дууриал үзүүлдэг хүн.”

Гуаглиарелло эгч 1962 онд Өмнөд Буэнос Айресын Мар дел Платад бүрэн цагийн номлогчдын амьдардаг байсан байранд ажиллаж байхдаа тэдэнтэй уулзжээ. Тэр 15



Элвира Гуаглиарелло

жилийн дараа номлогчдыг хаалга тогшиход тэднийг таньсан гэдэг. Тэр Пуэрто Мадринд шилжиж ирснийхээ дараа ярилцлага авч, баптисм хүртсэнээр Сүмд үйлчлэх амьдрал нь эхэлсэн ажээ.

Тэр ганцаараа амьдардаг ч огт ганцаарддаггүй гэнэ. Түүнд өөрийнх нь судрууд байдаг бас тойрог нь түүний гэр бүл нь болдог бөгөөд залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэйгээ байнга харилцдаг ажээ. Түүнээс гадна бусдад үйлчилснээс ирдэг Их Эзэний амласан Сүнстэй нөхөрлөх нь түүнд таалагддаг гэнэ.¹

“Энэ бүхэн намайг адисалдаг. “Сүм биднийг ажилтай байлгадаг. Энэ нь намайг аз жаргалтай болгодог. Би Тэнгэр дэх Эцэгтэй үйлчилснээр ямагт баяр баяслыг олдог” гэж Гуаглиарелло эгч инээмсэглэн хэлэв. ■

ЭШЛЭЛ

1. Хенри Б.Айринг, “In the Strength of the Lord,” *Лиакхона*, 2004 оны 5-р сар, 19; мөн Иохан 14:16–18; Сургаал ба Гэрээ 88:3-ыг үз.



ӨТӨЛ НАСНААС ӨНДӨР АШИГ ТУСЫГ ОЛОХ НЬ

Ганцаардлыг даван туулж, үүнийг ашиг тустай мэдрэмж болгож хувиргах түлхүүр бол тусламж хэрэгтэй хүмүүст туслах арга замыг эрж хайх явдал мөн. Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994) дараах арга замуудаар үйлчлэх асуудлыг авч үзэхийг Сүмийн ахмад гишүүдэд зөвлөмж болгосон байдаг.

1. Ариун сүмд ажиллаж, олон удаа энд ордог байх.
2. Гэр бүлийн түүх цуглуулах буюу бичих.
3. Номлолын үйлчлэлд оролцох.
4. Гэр бүлээ бэхжүүлэх.
5. Сүмийн дуудлага хүлээн авч биелүүлэх.
6. Христийнхтэй адил үйлчлэл үзүүлэх.
7. Бие бялдраа чийрэгжүүлж, эрүүл, идэвхтэй байх.

Эзра Тафт Бенсонгийн “To the Elderly in the Church,” өгүүлээс *Ensign*, 1989 оны 11-р сар, 4–6.

ЕСҮС ХРИСТ

БИДНИЙ НҮГЛИЙГ ЦАГААТГАСАН

Бид дэлхий дээр байгаагийн нэг шалтгаан бол Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаж сурах явдал мөн. Төгс амьдралтай байсан Есүс Христийг эс тооцвол, дэлхий дээр аль ч үед амьдарч байсан бүх хүмүүс нүгэл үйлддэг. (Ром 3:23; 1 Иохан 1:8-г үз). Бид Бурханы зарлигуудыг санаатайгаар зөрчвөл нүгэл үйлдэж байгаа нь тэр. Бүх нүгэл өөртөө тохирсон шийтгэлтэй байдаг. Бид нүгэл үйлдсэн бол үүнийхээ төлөө шийтгэл хүлээхийг шударга ёс шаарддаг (Алма 42:16–22-ыг үз).

Аливаа нүглийн зайлшгүй үр дагавар нь Бурханаас тусгаарлагдах явдал юм (1 Нифай 10:21-ийг үз). Ийнхүү тусгаарлагдах нь бид

өөрсдөө залруулж чадахааргүй тийм ноцтой юм.

Энэхүү тусгаарлалтыг даван туулахын тулд Тэнгэрлэг Эцэг Өөрийн Төрсөн Ганц Хүү Есүс Христ дээр бидний нүглийн ачааг үүрүүлэх замаар хангасан. Ингэснээр бид сүнслэг байдлын хувьд цэвэр байж, Түүнтэй дахин нэгдэх боломжтой болсон билээ. Энэ бол нигүүлслийн төлөвлөгөө юм.

“Учрыг болгоогтун, хэрэв тэд

наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ” (С ба Г 19:16–17) гэж Аврагч заасан.

Есүс Өөрийн Цагаатгалын хэсэг болгон бидний нүглийн төлөө Гетсеманий Цэцэрлэг болон Калварийн загалмай дээр зовсон юм. Бид нүглээ наманчилснаар Түүний Цагаатгалын хүчийг амьдралдаа авчирч чадна.

“Бурханы Төрсөн Ганц Хүү, энэ дэлхий дээр амьдарч байсан нүгэлгүй цорын ганц хүн Есүс Христ бол хүн төрөлхтний төлөө цагаатгал хийх чадвартай цорын ганц хүн байлаа” (Судруудын Удирдамж, “Цагаатгал”).



**Цагаатгал нь дараах
адислалуудаар хангадаг:**

1. Дэлхий дээр төрсөн хүн бүрд ирэх амилуулалт (Алма 11:42–45-ыг үз).



Бидний нүглийг өөрийн хүслээр цагаатгасан Есүс Христ ийн айлдсан билээ:

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарт амралтыг өгье.

“Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

“Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн” (Матай 11:29-30). ■

Нэмэлт мэдээллийг *Сайн мэдээний зарчмууд* (2009), 59–66; *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 14–20-иос үз.

“Болгоогтун, дэлхийнхэнд гэтэлгэл авчрахаар, дэлхийнхнийг нүглээс нь аврахаар би дэлхийд ирсэн бөлгөө.

“Тиймийн тул, наманчилж мөн бяцхан хүүхдийн адил надад ирэх хэнийг боловч, би түүнийг хүлээн авах болно, учир нь Бурханы хаант улс бол ийм хүмүүсийнх юм. Болгоогтун, ийм хүмүүсийн төлөө би амиа өгч, мөн үүнийгээ буцаан авсан юм; тиймийн тул наманчил, мөн дэлхийн хязгаарууд та нар надад ир, мөн аврагдагтун” (3 Нифай 9:21–22).

2. Хариуцлагын нас буюу найман нас хүрэхээс өмнө нас барсан бүх хүүхэд Бурханы дэргэд мөнх амьдарна (Мозая 3:16; 15:24–25; Моронай 8:8–12-ыг үз).



3. Есүс бидний өвдөлт, өвчин эмгэгийг Өөр дээрээ авсан учраас хүнд сорилтын үед амар амгаланг олох чадвар (Иохан 14:27; Алма 7:11–12-ыг үз).



4. Энэ амьдралд тохиолдсон шударга бус явдлын төлөө зөв шударга хүмүүст ирэх нөхөн төлбөр (Миний сайн мэдээг номло [2004], 52-ыг үз).

Наманчил, Их Эзэнд ханд, ТЭГВЭЛ ЭДГЭРНЭ



НАМАНЧЛАЛ ААС ИРДЭГ АДИСЛАЛУУД

“Нүгэл бол бурханлиг хуулийг санаатайгаар зөрчих явдал мөн. Есүс Христийн Цагаатгал бол нүглийн лайг залруулж, даван туулахад нь хүүхдүүддээ соёрхсон Бурханы бэлэг юм. . . .

Есүс Христийн Цагаатгалын бэлэг биднийг бүх цаг үед, бүх газарт наманчлалын болон уучлалын адислалуудаар хангаж байдаг.

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, “Point of Safe Return,” Лиахона, 2007 оны 5-р сар, 99, 101.

“Болгоогтун, нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, Их Эзэн бибээр тэдгээрийг цаашид санах нь үгүй” (С ба Г 58:42).

Давид Л.Фришнехт

Сургалтын хөтөлбөрийн хэлтэс

Миний таньдаг итгэлтэй, нэгэн эмэгтэй машины ослоор хүнд бэртсэнийг би саяхан мэдлээ. Ослоор түүний хэдэн хавирга хугарч, нуруу нь бэртжээ. Сэргээн дасгах эмчилгээний хэсэг болгож, нуруу, хүзүүнд нь бэхэлсэн аппаратыг авахыг хориглодог ажээ. Бэхэлгээний аппарат тун эвгүй харагдаж байсан ч, зайлшгүй шаардлагатай байлаа. Нуруу, хүзүү нь эдгэрч хэвийн болох нөхцөлийг энэ аппарат хангах учиртай аж.

Наманчлал энэ аппараттай адил юм. Бид нүгэл үйлдсэнээр өөрсдийн бодгалийг гэмтээдэг бөгөөд эдгэрч дахин хэвийн байдалдаа ороход бурханлиг эмчилгээ хэрэгтэй болдог. Наманчлал нь Цагаатгалын хүчээр дамжуулан биднийг эдгээх боломжийг Аврагчид олгодог тэрхүү нөхцөлийг бүрдүүлдэг билээ (3 Нифай 9:13-ыг үз). Наманчлалын зарим хэсэг нь бэртсэн нурууны аппарат шиг эвгүй байдаг ч, бид заавал наманчлах хэрэгтэй.

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф заасан нь, “Жинхэнэ наманчлал нь зөв зүйлийг хийхийг бидэнд буцааж авчирдаг. Бид жинхэнэ ёсоор наманчлахын тулд нүглээ хүлээж, гэмшин эсвээс

бурханлиг байдлаар харуусч, нүглээ Бурханы өмнө хүлээж гэмших ёстой. Хэрэв бидний нүгэл ноцтой бол эрх мэдэл олгогдсон санваартны удирдагчид бид нүглээ хүлээн гэмших ёстой. Бид Бурханаас уучлал гуйж, буруу үйлдлийнхээ улмаас учруулсан аливаа хор хохирлыг залруулахын төлөө чадах бүхнээ хийх хэрэгтэй. Наманчлал бол зүрх сэтгэлийн өөрчлөлт бөгөөд бид буруу юм хийхээ больж, зөв зүйлс хийж эхэлдэг. Энэ нь Бурханд, өөртөө болон амьдралд бүхэлд нь хандах шинэ хандлагыг бий болгодог.”¹

Бид наманчлалын үйл явцыг амжилттай дуусгасан үед эдгэрэлтийн үр дүн гарч сэтгэл санааны хүнд дарамт арилж, аз жаргалтай болдог. Дороти Ж.Р.Вайт:

“Дотоод сэтгэлээ ариусгасны гадаад илрэл нь нулимс байдгийг сана” хэмээн бичжээ.²

Их Эзэн биднийг эдгээхийг хүсдэг учраас наманчлах хэрэгтэйг бидэнд шаргуу тэвчээр, хайр энэрэл, сэнхрүүлээр заадаг. Тэр бидний нүглийн төлөөх шийтгэлийг бие болон сүнсээрээ Өөр дээрээ хүлээн зовж шаналсан юм. Иймээс бид наманчлах ёстой. Их Эзэн ийн тайлбарлажээ:



Үрэлгэн хүү даруухнаар эцэгтээ эргэн ирж, Аав аа, би тэнгэрийн эсрэг, таны өмнө нүгэл үйлджээ. Би цаашид таны хүү гэгдэх нь зохисгүй” (Лук 15:21) гэсэн билээ. Аав нь түүнийг гэртээ баяртайгаар хүлээн авсан шүү дээ. Биднийг наманчилсан үед Тэнгэрлэг Эцэг маань мөн л ийм байдлаар баярлан угтаж авах болно.

“Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ”

“Гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адилаар тэд зовох ёстой”

“Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн тэрхүү зовлон нь мөн намайг тэрхүү гашуун аяганаас уухгүй, мөн айснаас эргэн буцахад

хүргэж болохоор байсан билээ.

Гэсэн хэдий ч, алдар суу нь Эцэгт байх болтугай, мөн бибээр хүртэж мөн хүмүүний үрсийн төлөө өөрийн бэлтгэлүүдийг дуусгасан билээ.

“Иймийн тул би чамд наманчлахыг дахин зарлиглаж байна” (С ба Г 19:16–20).

Бүгдээрээ наманчилж, Их Эзэнд хандацгаая, тэгвэл эдгэрэх болно. ■

ЭШЛЭЛ

1. Диетер Ф.Угдорф, “Point of Safe Return,” *Лиакхона*, 2007 оны 5-р сар, 100.
2. Дороти Ж.Р.Вайт, “Repentance,” *Ensign*, 1996 оны 7-р сар, 27.

Наманчлал, уучлалаас ямар адислалууд ирдэг вэ?

- Бид уучлагдсаныг Ариун Сүнс нотлох болно.
- Бидний нүглийн төлөөх гэм буруугийн ачаа дарамтыг Бурхан зайлуулах болно.
- Бид Ариун Сүнсний нөлөөг агуу ихээр мэдэрч баярлах болно.

Энэ сэдвээрх нэмэлт мэдээллийг Езекиел 33:15–16; Алма 12:33–34; 36:13, 17–20; тэрчлэн Бойд К.Пакер, “The Brilliant Morning of Forgiveness,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 18–21-ээс үзнэ үү.

НАМАНЧЛАЛ ЯАГААД БИДНИЙГ ЭДГЭЭДЭГ ВЭ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл Л.Андерсен ерөнхий чуулган дээр хэлсэн үгэндээ “Би таныг эдгээж болохын тулд . . . наманчлагтун” хэмээн хэлж дээрх асуултанд хариулахад тусалжээ (*Лиакхона*, 2009 оны 11-р сар, 40–43). Наманчлал болон Цагаатгалыг ойлгоход бошиглогч Алма бас бидэнд тусалсан юм (Алма 42-ыг үз).

1. Наманчлал Христийн Цагаатгалд нэвтэрч, эдгэрэх боломжийг бидэнд олгодог. Гетсемани болон Голгота дахь Христийн зовлон бид бүхний нүглийг цагаатгасан юм. Тэр бидний нүглийг уучилж чадах бөгөөд үүнийг үлэмж ихээр хүсдэг.
2. Бид нүгэл үйлдсэнээр Бурханаас нүүр буруулдаг. Энэ нь бидний сэтгэл зүрхийг шархлуулдаг.
3. Бид наманчилснаар Бурхан уруу “эргэж очдог.” Энэ нь сэтгэлийн шаналгаа арилж, тайвшрахад бидэнд тусалдаг. Уучлал нь бас “бидний зүрх сэтгэлээс гэмийг зайлуулан авдаг” (Алма 24:10) бөгөөд “ухамсрын амар амгаланг” (Мозая 4:3) авчирснаар биднийг эдгээдэг билээ.

Наманчлалын ачаар өөртөө ирсэн адислалуудын тухай гэрчлэлээ хэн нэгэнтэй хуваалцахыг бод.

ГЕТСЕМАНИЙ ариустгагч хүүч



**Ахлагч Брус
Р.МкКонки
(1915–1985)**

Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын

Брус Р.МкКонки 1915 оны 6-р сарын 29-нд АНУ-ын Мичиганд төржээ. Тэрээр 1946 оны 10-р сарын 6-нд Далын Нэгдүгээр Зөвлөлд дэмжүүлэн батлагдаж, 1972 оны 10-р сарын 12-нд Төлөөлөгчөөр томилогдсон байна. Тэр 1985 оны 4-р сарын 19-нд Ютагийн Солт Лейк хотод нас баржээ. Энэ үгийг 1985 оны 4-р сарын 6-нд ерөнхий чуулган дээр хэлсэн ажээ.

Миний тунхаглах хамгийн чухал сургаал бол, бас миний хэлж чадах хамгийн хүчирхэг гэрчлэл бол Их Эзэн Есүс Христийн цагаатгагч золиослол мөн гэж би боддог, бас Сүнс ч үүнтэй санал нийлдэг.

Түүний Цагаатгал бол Бүтээлтээс эхлэн хэзээ ч үл төгсөх үүрд мөнхийн бүх эрин үеийн туршид хэзээ ч тохиож байгаагүй, хэзээ ч үл тохиох хүмүүний ойлголтоос хэтэрсэн, хамгийн гарамгай үйл явдал мөн.

Энэ бол зөвхөн Бурхан л үйлдэж чадах нинжин сэтгэл хийгээд ач ивээлийн дээд оргил болсон үйлдэл юм. Эцэгийн мөнхийн авралын төлөвлөгөөний бүх нөхцөл Цагаатгалаар дамжин үйлчилдэг билээ.

Цагаатгалаар дамжин үхэшгүй байдал ба мөнх амьдрал хүмүүнд ирэх болно. Цагаатгалаар дамжин бүх хүн үхэл, там, чөтгөр, төгсгөлгүй тарчлалаас аврагдах болно.

Мөн Цагаатгалаар дамжин Бурханы алдар суут сайн мэдээнд итгэж, үүнийг

дуулгавартай дагадаг бүх хүн, үнэнч итгэлтэй бөгөөд дэлхийг ялдаг бүх хүн, Христ болон Түүний үгийн төлөө мөн Түүний хүмүүс болсны улмаас шүүмжлүүлж, доромжлуулан, зовдог бүх хүн өөрсдийгөө Бүтээгчтэй адил болж, хаан сэнтийд нь Түүнтэй хамт сууж, үүрд мөнхийн алдар сууд Түүнтэй хамт хаанчлах болно.

Би эдгээр гайхамшигт зүйлсийн тухай ярихдаа өөрийнхөө үгийг хэрэглэлээ. Харин эдгээр үгс судрынх, бусад төлөөлөгчид, бошиглогчдын хэлсэн үгс шүү дээ гэж та нар бодож байгаа байх.

Тийм ээ, эдгээр үгсийг анх бусад хүмүүс тунхагласан нь үнэн ч харин одоо минийх юм, учир нь Бурханы Ариун Сүнс эдгээр үгс үнэн гэдгийг надад гэрчилсэн юм. Мөн Их Эзэн эдгээр үгсийг надад анх удаа илчилсэн нь бас үнэн юм. Үүгээр би Түүний дуу хоолойг сонсож, Түүний үгийг мэддэг.

Гетсеманий Цэцэрлэгт

Хоёр мянган жилийн тэртээ Иерусалимын хэрэмний гадна Гетсемани гэдэг нэртэй нэгэн сайхан цэцэрлэг байсан ажээ. Есүс болон Түүний дотны найз нар бяслаган бодож, залбирахын тулд тэр цэцэрлэгт ирж заншсан байв.

Тэнд Есүс хаант улсын сургаалуудыг дагалдагчдаа заадаг байв. Бид бүхний Эцэг болох Түүнтэй тэд бүгд ойр дотно харилцаатай байж, үйлчлэлд нь оролцон, өгсөн



үүргийг нь биелүүлж, Түүнд үйлчилдэг байжээ.

Адам, Ева хоёрын амьдарч байсан Еден шиг, Иехова Өөрийн хуулиудыг оргил дээрээс нь өгсөн Синай лугаа адил, Бурханы Хүү амиа олон түмний төлөө золиос болгон өгсөн Калваритай адилхан энэхүү ариун газарт Үүрдийн Эцэгийн нүгэлгүй Хүү, хэрэв тэд наманчилбал, бүх хүмүүний нүглийг Өөр дээрээ үүрсэн юм.

Христ Гетсеманий Цэцэрлэгт юу хийсний бүрэн утга учрыг бид мэдэхгүй, ярьж чадахгүй, мөнх бус хүмүүний ухаан ойлгож чадахгүй юм.

Түүний сүв бүрээс үлэмж их цус шүүрэн, Эцэг нь Түүнд

оноосон гашуун аяганы шаарыг шавхан уусан билээ.

Тэр бие, сүнс аль алинаар, үхлийг үзэхгүйгээр ямар ч хүн тэсэн гарах боломжгүй тийм байдлаар зовон шаналсныг бид мэднэ.

Түүний зовлон шударга ёсны шаардлагыг хангаж, бидний ойлгох аргагүй арга замаар наманчлагч хүмүүсийг өвдөлт болон нүглийн шийтгэлээс аварч, Түүний ариун нэрэнд итгэдэг хүмүүст нигүүлслийг боломжтой болгосныг бид мэднэ.

Өвдөлт, сэтгэл санааны тарчлалын хэмжээлшгүй ачаа дарамт Түүнийг дагжин чичирч, тэрхүү гашуун аяганаас

уухгүй байж болохгүй юм болов уу гэж бодохдоо Тэр элгээрээ газарт унасныг бид мэднэ.

Алдар суугийн хаант улсаас тэнгэр элч Түүнийг зовлонд нь хүчирхэгжүүлэхээр ирснийг бид мэднэ. Мөн энэ нь мөнх бус хүмүүн байхын тулд хамгийн түрүүнд унасан хүчирхэг Михаил байсан болов уу гэж бид боддог.

Энэхүү хэмжээлшгүй тарчлал, энэхүү юутай ч зүйрлэшгүй зовлон ойролцоогоор гурав, дөрвөн цаг үргэлжилснийг бодоод үз л дээ.

Түүнийг баривчилж, шүүж, ташуурдсан нь

Үүний дараа Түүний бие сульдан хүч тамир нь шавхгдаж, Иудас болон бусад бие махбодтой чөтгөрүүдтэй тулгарснаас зарим нь тэргүүн тахилчид байлаа. Тэгээд ноцтой гэмт хэрэгтнүүд болох Аароны суудалд суусан иудейчүүд, Цезарийн хүчийг атгаж байсан ромчууд Түүнийг шүүхийн тулд зард гарсан гэмт хэрэгтэн лүгээ адил хүзүүгээр нь оосорлон хөтөлж ирсэн юм.

Тэд Түүнийг Анна, Каиаф, Пилат, Херод уруу, эцэст нь дахиад Пилат уруу аваачив. Түүнд ял тулгаж, хараан зүхэж, нулимж байлаа. Тэдний заваан шүлс Түүний нүүрэн дээгүүр хор лугаа адил урсаж, өвдөлтөд буларсан биеийг нь улам сульдуулж байлаа.

Тэд уурлан хилэгнэж Түүний нуруу уруу дахин дахин цохьж байв. Үүргэнэн титмийн өргөс дух уруу нь хатгаснаас нүүрнээс цус гоожиж байлаа.

*Христ
Гетсеманий
Цэцэрлэгт
юу хийсний
бүрэн утга
учрыг мөнх
бус хүмүү-
ний ухаан
ойлгож ча-
дахгүй юм.*

Бүр түүгээр ч барахгүй шовх үзүүртэй яс, иртэй төмөр үзүүрт нь уясан, олон цацагтай суран ташуураар Түүнийг дахин дахин, нийтдээ 39 удаа ташуурджээ.

Олон хүн зөвхөн ташуурдалтаар нас бардаг байж, харин Тэрээр Калварийн загалмай дээр хүндэтгэлгүйгээр үхэх учиртай байснаас ташуурдалтын тарчлалыг давж гарсан юм.

Тэрээр хүнд загалмай, өвдөлт болон шаналал нь улам ихэссэний улмаас шургаж унах хүртлээ загалмайгаа үүрч явжээ.

Загалмай дээр

Эцэстээ Иерусалимын хэрэмний гадна орших Калвари толгой дээр дагалдагчид нь яаж ч чадахгүй харж, үхэлд ойрхон очсон өвдөлт, шаналгааг өөрсдийн биеэр мэдэрч зогсох үед Ромын цэргүүд Түүнийг загалмай дээр хэвтүүлэв.

Тэд том алхаар төмөр хадаасуудыг Түүний хөл, гар бугуй уруу хадлаа. Тэр үнэхээр бидний нүглийн төлөө хатгагдан, бидний гэмийн төлөө бяцарсан юм.

Тэгээд бүх хүн харж, харааж зүхэн, доог тохуу болгохын тулд загалмайг ноцтой, тэд өглөөний 9:00 цагаас үд хүртэл гурван цагийн турш тийнхүү хорсолтойгоор үйлджээ.

Тэгтэл тэнгэр харанхуйлав. Газрыг гурван цагийн турш харанхуй бүрхсэн нь нифайчуудад бас тохиосон ажээ. Хорвоогийн Бурхан хүртэл зовсон учраас хүчтэй шуурга дэгдлээ.

Тэрээр үд дундаас 15:00 цаг хүртэл дахиад гурван цаг загалмай дээр дүүжлээстэй байх үед Гетсеманий тэрхүү хэмжээлшгүй тарчлал, зүрх шимшрэм өвдөлт дахин давтагдсан юм.

Тэгээд эцэст нь цагаатгагч зовлон тарчлал дээд хэмжээндээ хүрч, ялаал ирэхэд, Бурханы Хүү бүх зүйлээр Эцэгийнхээ хүслийг биелүүлээд, “Энэ нь төгслөө” (Иохан 19:30) гэсэн билээ. Тэрээр өөрийнхөө хүслээр амьсгалаа хураав.

Сүнсний дэлхийд

Нигүүлсэнгүй үхлийн амар амгалан хийгээд тайтгарал нь Түүнийг мөнх бус байдлын өвдөлт, уй гашуугаас чөлөөлж Тэрээр Бурханы диваажинд одсон билээ.

Тэрбээр Мессиагийн үгийн дагуу Өөрийгөө нүглийн төлөөх золиослол болгон өргөж, үр удмаа үзэхэд бэлтгэгдсэн юм.

Өнгөрсөн эрин зуунуудын бүх ариун бошиглогчид болон итгэлтэй Гэгээнтнүүдээс бүрдсэн хүмүүс, Түүний нэрийг өөрсдөдөө авсан бүх хүн, түүнчлэн сүнсээрээ Түүнээс төрж, Түүний хөвгүүд, охид болсон бүх хүн буюу бид, сүнсний дэлхийд цугласан бүх хүн Түүний нүүрийг харж, дуу хоолойг нь сонсох болно.

Иудейчүүдийн тооллоор гурван өдөр, 38 буюу 40 цагийн дараа бидний адислагдсан Их Эзэнийг Ариматын бунханд ирэхэд цогцост нь хагас дутуу гаврын тос түрхэж, Никодем, Ариматын Иосеф хоёр Түүнийг бунханд тавьжээ.

Түүний Амилалт

Дараа нь Тэрээр бидний ойлгох аргагүй замаар ялзралыг үзээгүй цогцсоо босгож, Өөрийг нь амилсан Эцэгтэйгээ адилхан болгосон алдар суут үхэшгүй байдалд амилан босч ирсэн билээ.

Тэгээд Тэр тэнгэр, газар дахь бүх хүчийг хүлээн авч, мөнхөд өргөмжлөгдөн, Магдалын Мариа болон бусад олон хүнд үзэгдэж, тэнгэрт Бүхнийг Чадагч Бурхан Эцэгийн баруун гар талд заларч, мөнхийн алдар суугаараа үүрд хаанчлахаар дээш одсон юм.

Гурав дахь өдрөө үхлээс амилан босч ирсэн нь Цагаатгалын оргил үе болов. Мөн л бид ойлгох аргагүй байдлаар бүх хүн булшнаас амилан босч ирэхийн тулд Түүний Амилалтын үр нөлөө тэдэнд ирэх болно.

Адам үхлийг авчирсан бол Христ амийг авчирсан юм. Адам мөнх бус байдлын эцэг бол, Христ үхэшгүй байдлын эцэг мөн.

Мөнх бус болон үхэшгүй байдлын аль алингүйгээр хүмүүн авраалаа биелүүлж, дээд тэнгэрт мөнхийн алдар суундаа үүрд оршин байгаа бурхад болон тэнгэр элчүүд дээр дээшлэн очиж чадахгүй.

Цагаатгалын тухай мэдлэг

Эдүгээ Христийн Цагаатгал сайн мэдээний үндсэн тулгуур сургаал бөгөөд энэ нь бидэнд илчлэгдсэн бүх үнэнүүдээс хамгийн бага ойлгогддог нь юм.

Биднээс олон хүн өнгөц мэдлэгтэй байж, амьдралын хүнд сорилтууд, аюул осол дунд Их Эзэн болон Түүний нинжин сэтгэлд итгэл найдвар тавьдаг.

Харин бид Енох, Елиа нар шиг итгэлтэй байвал тэдний итгэдэг байсан зүйлд итгэж, тэдний мэддэг байсан юмсыг мэдэж, тэдний амьдарч байсан шиг амьдрах болно.



Цагаатгалын тухай үнэн зөв, баттай мэдлэгтэй болохын төлөө надтай нэгдэхэд би та бүхнийг урьж байна.

Бид хүмүүний философи, мэргэдийн цэцэн ухааныг хойш тавьж, биднийг бүх үнэн уруу удирдахаар бидэнд өгөгдсөн Сүнснийг анхааралтай сонсох ёстой.

Бид судруудыг Их Эзэний оюун ухаан, хүсэл, дуу хоолой, авралд хүргэх Бурханы хүч хэмээн үзэж, хичээнгүйлэн судлах ёстой.

Бид судруудыг уншиж, тунгаан бодож, залбирвал Едений Цэцэрлэг, Гетсеманий Цэцэрлэг, Есүс Магдалын Мариа дээр хүрч ирсэн Хоосон Булшны Цэцэрлэг гэсэн Бурханы гурван цэцэрлэгийн дүр зураг бидний санаанд орж ирэх болно.

Бүтээлт, Уналт ба Цагаатгал

Үхэл, нөхөн үржихүй, сорилтын туршлага гэж байхгүйгээр, диваажингийн байдлаар бүтээгдсэн бүх

юмсыг бид Еденд хардаг.

Эдүгээ хүмүүнд мэдэгдээгүй ийм бүтээлт нь гагцхүү Уналтыг хангах арга зам байсныг бид мэдэх болно.

Ингээд бид үхэшгүй байдал болон диваажингийн алдар суугаасаа дэлхий дээрх анхны мөнх бус хүмүүн болохоор бууж ирсэн анхны эрэгтэй, эмэгтэй хүн Адам, Ева хоёрыг харна.

Нөхөн үржихүй болон үхлийг өөртөө багтаадаг мөнх бус байдал дэлхийд ирсэн билээ. Нүгэл хилэнцийн улмаас сорилтын байдал байх болно.

Дараа нь Уналтын улмаас бидэнд ирсэн биеийн болон сүнсний үхлээс хүмүүнийг Аварсан Бурханы Хүүт бид Гетсеманид харах болно.

Ингээд бид эцэст нь хоосон булшны өмнө бидний Их Эзэн Христ үхлийн хүлээсийг тас татаж, булшийг үүрд ялсныг мэдэх билээ.

Тийнхүү Бүтээлт бол Уналтын эцэг юм; Уналтаар мөнх бус байдал болон үхэл ирсэн

бол Христээр үхэшгүй байдал ба мөнх амьдрал ирсэн юм.

Хэрэв үхэл түүгээр ирсэн Адамын Уналт байгаагүй бол, түүгээр амьдрал ирсэн Христийн Цагаатгал байж чадахгүй байв.

Түүний Цагаатгагч цус

Эдүгээ Бурханы цусаар гүйцэлдсэн энэхүү төгс Цагаатгалын тухайд, энэ нь Гетсемани болон Голгота болж өнгөрснийг би гэрчилж байна, Есүс Христийн тухайд, Тэр бол амьд Бурханы Хүү бөгөөд дэлхийн нүглийн төлөө цовдлогдсоныг би гэрчилж байна. Тэр бол бидний Их Эзэн, бидний Бурхан, бас бидний Хаан. Үүнийг би өөр ямар ч хүнээс хамааралгүйгээр өөрөө мэднэ.

Би Түүний гэрчүүдийн нэг мөн ирээдүйн нэг өдөр Түүний гар, хөлөн дэх шархны сорвийг гэмтэрч үзэн Хөлийг нь нулимсаараа норгох болно.

Гэвч би Түүнийг Бурханы Бүхнийг Чадагч Хүү хэмээн мөн аврал өөр ямар ч замаар биш зөвхөн Түүний цагаатгагч цусаар дамжин ирнэ хэмээн одоогийнхоо мэддэгээс ямар ч илүү зүйлийг тэр үед мэдэхгүй.

Бидний Эцэг Бурхан гэрэлд алхдаг шиг бид бүгдэд гэрэлд алхах боломжийг Бурхан соёрхсон бөгөөд Түүний амлалтын дагуу Түүний Хүү Есүс Христийн цус биднийг бүх нүглээс цэвэршүүлэх болно. ■

Дэд гарчгуудыг нэмж, том үсэг, цэг тэмдэг, зөв бичгийн дүрмийг стандартын дагуу болгов.

**Түүний
Амилалтын
үр нөлөө
бүх хүмүүнд
нөлөөлж тэд
бүгд булш-
наас босч
ирэх болно.**



Ахлагч Д.Тодд
Кристофферсон
Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын



ТҮҮНИЙГ ҮРГЭЛЖ САНАХЫН ТУЛД

*Бид Аврагчийг үргэлж санаснаараа,
“өөрсдийнхөө чадах бүхнийг зоригтой
хийж, Түүний хүч болон биднийг
хайрлах хайр нь биднээр дамжин илрэх
болно” гэдэгт итгэлтэй байж болно.*

Их Эзэн Есүс Христийн үндэслэсэн Ариун ёслолын залбирлын гол зорилгуудын нэг нь бид “Түүнийг үргэлж санах” (С ба Г 20:77, 79) явдал гэдгийг баталдаг. Аврагчийг санах гэдэгт Түүний зовлон болон үхлийн бэлгэ тэмдэг болсон талх, усаар төлөөлүүлэн Түүний Цагаатгалыг санах нь ордог нь тодорхой юм. Бидний төлөө Тэр юу хийснийг бид хэзээ ч мартаж өсгүй. Учир нь Түүний Цагаатгал болон Амилалтгүйгээр амьдрал утга учиргүй юм. Гэвч Түүний Цагаатгал болон Амилалтын ачаар




бидний амьдрал мөнхийн бурханлиг боломжуудтай юм.

“Түүнийг үргэлж санах” гэдэг нь юу гэсэн утгатай болохыг би гурван зүйлээр тодруулан тайлбарлахыг хүсч байна. Энэ нь нэгдү-

гээрт, Түүний хүслийг мэдэж, дагах; хоёрдугаарт, бид бодол санаа, үг хэл, үйлдэл бүрийнхээ төлөө Христийн өмнө үүрэг хариуцлага хүлээдгээ хүлээн зөвшөөрч ойлгох, гуравдугаарт, бид итгэлээр болон өөрсдөдөө хэрэгтэй тусламжийн төлөө Аврагчид үргэлж итгэл найдвар тавьж, айдасгүйгээр амьдрах явдал мөн.

Та бид бүгдээрээ
Христийг амьд-
ралынхаа төвд
тавьснаар,
Тэрээр Эцэгтэй
нэг байдгийн
адилаар бид
Түүнтэй нэг
болж чадна.
Бид хийдэг бүх
зүйлээ эргэн
харж, цэгнэн,
Аврагчийг амьд-
ралынхаа гол
төвд тавьж,
хамгийн чухал
зүйлсийг эн тэр-
гүүнд анхаардаг
болж, амьд-
ралаа шинээр
төлөвшүүлэхээс
эхэлж болно.



1. Тэрээр Эцэгийн хүслийг биелүүлэхийг хүсч байсан шиг Христийн хүслийг мэдэж, дагахыг эрэлхийл.

Ариун ёслолын талхны адислал нь бид Хүүгийн нэрийг өөрсдөдөө авч, “түүнийг үргэлж санан, [бидэнд] өгсөн түүний зарлигуудыг дагах” (С ба Г 20:77) хүсэлтэй байхад биднийг хөтөлдөг. Мөн “Түүний зарлигуудыг сахихын тулд Түүнийг үргэлж санах” явдал болгон энэ гэрээг ойлгох нь чухал юм. Энэ бол Тэрээр Эцэгийг хэрхэн үргэлж санадаг байсны жишээ мөн. “Би өөрийн санаагаар юуг ч үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд Миний шүүлт шударга. Учир нь би өөрийнхөө

хүслийг бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” (Иохан 5:30) гэж Тэр хэлсэн билээ.

Есүс бие, сүнс аль алинаар нь Өөрийгөө Эцэгийн хүсэлд захируулан Эцэгтэй төгс эв нэгдэлтэй байлаа. Есүс Эцэгтэй хандан, “Би үргэлж Түүнд тааламжтай зүйлсийг үйлддэг” (Иохан 8:29) гэсэн юм. Есүс Эцэгийн хүслийн улмаас бүр үхэлд үг дуугүй захирагдан, “Хүүгийн таалал Эцэгийн таалалд багтсан” (Мозая 15:7) билээ. Есүс Эцэгт бүх анхаарлаа төвлөрүүлдэг байсан нь Түүний үйлчлэл тийм тод томруун, хүчтэй байсны үндсэн шалтгаануудын нэг юм.

Та бид бүгдээрээ мөн ийм байдлаар

Христийг амьдралынхаа гол төвд тавьснаар, Тэрээр Эцэгтэй нэг байдгийн адилаар бид Түүнтэй нэг болж чадна (Иохан 17:20–23-ыг үз). Бид хийдэг бүх зүйлээ эргэн харж, цэгнэн, Аврагчийг амьдралынхаа гол төвд тавьж, хамгийн чухал зүйлсийг эн тэргүүнд анхаардаг болж, амьдралаа шинээр төлөвшүүлэхээс эхэлж болно. Түүнийг үргэлж санах боломжийг олгодог юмсыг—байнга залбирах болон судраас судлах, төлөөлөгчдийн сургаалуудыг нухацтай судлах, ариун ёслолоос зохистойгоор хүртэх, ням гаргийн шүтэн бишрэх үйл ажиллагаануудад оролцох, жинхэнэ шавь байх талаар Сүнс болон туршлага юу зааж буйг тэмдэглэн авч санаж байхыг эн тэргүүнд тавих ёстой.

Бусад юмс, ялангуяа амьдралын чинь тодорхой үед өөрт чинь шаардлагатай ямар нэг зүйл санаанд чинь орж ирж болно. Бид амьдралаа Христ дээр төвлөрүүлэхийн тулд дээрх асуудлуудад зохих цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулбал боловсрол, гэр бүлийн үүрэг хариуцлага зэрэг үнэ цэнэтэй бусад зүйлсэд хүч чармайлт гаргаж чадна. Ийм байдлаар бидний амьдрал нэн чухал зүйлсээр биш, харин дан ганц сайн зүйлсээр дүүрч, бага ач холбогдолтой зүйлс хоёрдугаарт тавигдах буюу бидний амьдралаас бүрмөсөн алга болно.

Есүс Христ Өөрийн хүслийг Эцэгийн хүсэлд захируулсан шиг бид амьдралаа Есүс Христийн амьдралтай эгнүүлэх нь амархан биелэгдэх зүйл биш. Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) бидэнд тохиолддог сорилт бэрхшээлийн тухай ийн өгүүлжээ:

“Тэрээр энэ хүмүүсийг удаан хугацаанд удирдаж, тэдэнд зааж, тэдний төлөө сайн зүйлсийг хийсний дараа ч Бурханд итгэх итгэл дутмаг байгааг та бүхэн ажигладаг уу? Та нар үүнийг өөрсөд дээрээ ажигласан уу? ‘Бригам [ах аа] та үүнийг өөр дээрээ ажигласан уу?’ гэж та нар асууж болно. Тийм ээ, найддаг хүндээ итгэл алдрах нь надад ямар нэг хэмжээгээр байдаг. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл надад хүч байхгүй байна. Үүний улмаас би унасан хэрэг. . . .

“ . . . Зарим үед миний дотор ямар нэг зүйл босч ирэх шиг болдог. Энэ нь миний

ашиг сонирхол, тэнгэр дэх Эцэгийн минь ашиг сонирхол хоёрын хооронд мэдэгдэхүйц зааг тогтоодог нь миний ашиг сонирхлыг, тэнгэр дэх Эцэгийн минь сонирхолтой нэгдмэл биш болгодог.”

“Бид унасан байдлаа аль болох ихээр мэдэрч, үүнийгээ ойлгодог байх ёстой. Бидний үйлчилдэг Бурханы зорилго бол бидний ашиг сонирхол мөн гэдгийг мөн энэ амьдралд ч, үүрд мөнхөд ч ийм байна гэдгийг бид мэддэг, ойлгодог, бас үүнд итгэдэг байх хэрэгтэй.”¹

Энэ нь амаргүй ч бид Их Эзэнд итгэх итгэлээр байнга урагш тэмүүлж чадна. Цаг хугацаа өнгөрөх тусам Аврагчийг үргэлж санаж, дагах бидний хүсэл, чадвар өсөн нэмэгдэх болно гэдгийг би нотолж чадна. Бид энэ зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө тэвчээртэй ажиллаж, өөрсдөдөө хэрэгтэй байгаа ялган таних чадвар, бурханлиг тусламжийн төлөө үргэлж залбирдаг байх ёстой. “Та нар үргэлж залбирах ёстойг мөн шантрах ёсгүйг би та нарт хэлье; та нарын үйл бодгальд чинь золтой байж болохын тулд тэр та нарын үйлийг та нарт ариулахын тулд юун түрүүнд та нар Христийн нэрээр Эцэгт залбирахаас өөр нэгээхэн ч зүйлийг Их Эзэнд үйлдэх ёсгүй” (2 Нифай 32:9) хэмээн Нифай зөвлөжээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс бид хоёр гадаадын нэг орны гэр бүлтэй видео ярилцлага хийх даалгавар авсан үедээ залбирлын энгийн жишээг харсан юм. Би студид орохынхоо өмнөхөн гэр бүлийн хосын талаар цуглуулсан мэдээллээ дахин нэг нягталж үзээд өөрийгөө ярилцлагад бэлтгэгдсэн байна гэж бодож билээ. Товлосон цагаас хэдхэн минутын өмнө Ахлагч Өүкс толгойгоо бөхийлгөн ганцаараа сууж байхыг харлаа. Тэр хормын дараа толгойгоо өндийлгөн, “Энэ ярилцлагад бэлтгэх залбирлаа би дөнгөж сая дуусгалаа. Бидэнд ялган таних бэлэг хэрэгтэй шүү дээ” гэв. Тэрээр хамгийн чухал бэлтгэл, бидний амжилтын төлөө, Их Эзэний алдар суугийн төлөөх залбиралд хайхрамжгүй хандсангүй.

Бид амьдралаас юуг ч “зайлууллаа” юуг ч нууж хаалаа гэсэн, цаг нь болоход цэвэр ариун хийгээд төгс шударга Бурхан, Есүс Христийн өмнө аваачигдах болно.



2. Бодол санаа, үг хэл, үйлдлийнхээ төлөө Христийн өмнө хариуцлага хүлээхэд бэлтгэ.

Их Эзэн үндэстнүүдийг шүүхээр зогсох шүүлтийн агуу өдөр ирнэ гэдгийг (3 Нифай 27:16-г үз) мөн Тэр бол Христ гэдгийг өвдөг бүхэн сөхөрч, хэл бүхэн хүлээн зөвшөөрөх болно (Ром 14:11; Мозая 27:31; С ба Г 76:110-ыг үз) гэдгийг судруудад тодорхой өгүүлсэн байдаг. Тэрхүү шүүлтийн мөн чанар, хамрах хүрээг Алма Мормоны Номонд:

“Учир нь бидний үгс биднийг буруутгах болно, тийм ээ бүх үйлс маань биднийг буруутгах болно; мөн энэ аймшигт нөхцөлд бид Өөрсдийн Бурхан өөд харж үл зүрхлэх болно, мөн түүний оршихуйгаас биднийг нуухын тулд, өөрсөд дээрээ нуран унахыг хад уулсад бид тушааж чаддагсан бол сэтгэл маань ихэд баяртай байхсан биз ээ.

“Гэвч ийм байх аргагүй юм; бид урагшлан мөн түүний өмнө түүний алдар суугийн дор мөн түүний хүчний дор мөн түүний

чадал, сүр жавхлангийн хийгээд эзэгнэлийн дор зогсон түүний бүхий л шүүлтүүд шударга, тэрээр бүхий л үйлстээ шударга, мөн тэрээр хүмүүний үрсэд нигүүлсэнгүй, мөн тэрээр түүний нэрэнд итгэн мөн наманчлалд нийцэх үр жимсийг авчрах хүн бүрийг аврах бүх хүчийг эзэмддэг болохыг үүрдийн ичгүүртээ хүлээн зөвшөөрөх ёстой” (Алма 12:14–15).

Аврагч Өөрийн сайн мэдээг үндэслэх үед энэхүү шүүлт түүнд гол суурийг эзэлсэн юм. Тэр ийн хэлжээ:

“Болгоогтун би өөрийн сайн мэдээг та нарт өгсөн, мөн энэ бол та нарт миний өгсөн тэр сайн мэдээ. Эцэг минь намайг илгээсний учир би Эцэгийнхээ тааллыг гүйцэлдүүлэхээр дэлхийд ирсэн билээ.

“Мөн би загалмай дээр өргөгдөж болохын тулд би загалмай дээр өргөгдсөний дараа би бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тулд, би хүмүүнээр өргөгдсөний адилаар хүмүүн миний өмнө зогсож, тэд

өөрсдийн үйлүүдээр сайн эсвэл хилэнцэт байх эсэхээрээ шүүгдэхээр Эцэгээр өргөгдөхийн тулд Эцэг минь намайг илгээсэн бөлгөө—

“Мөн энэ шалтгааны учир би өргөгдөв; тиймийн тул тэд өөрсдийн үйлүүдийн дагуу шүүгдэж болохын тулд Эцэгийн хүчний дагуу би бүх хүмүүнийг өөртөө татах болно” (3 Нифай 27:13–15).

“Загалмай дээр өргөгдөх” гэдэг нь мэдээжийн хэрэг, Есүс Христийн Цагаатгалыг бэлгэдлээр дүрсэлж байгаа бөгөөд үүгээр Тэр бидэн дээр ирэх шударга ёсны шаардлагыг хангах болно. Өөрөөр хэлбэл, Гетсемани болон Голгота дээрх эдэлсэн зовлон ба үхлээрээ Тэр бидний нүглийн төлөө биднээс шаардагдах шударга ёсны бүх төлөөсийг төлсөн юм. Тиймээс Тэр шударга ёсны төлөө зогсдог бөгөөд шударга ёсны амьд жишээ мөн. Бурхан хайр байдаг шиг, Бурхан бол шударга ёс юм. Бидний өр төлөөсийг эдүгээ Есүс Христ өөр дээрээ авсан билээ. Тиймээс Тэр биднийг шүүх эрхтэй юм.

Тэрхүү шүүлт бидний ажил үйлс дээр үндэслэгдэх болно хэмээн Тэрээр хэлдэг. Ялангуяа Түүний сайн мэдээний “баярт мэдээ” нь Тэрээр бидний наманчлалаар нөхцөлдсөн уучлалын бэлгийг санал болгодогт оршино. Тиймээс хэрэв бидний ажил үйлст наманчлал багтсан бол Тэр бидний нүгэл хилэнц, алдаа дутагдлыг уучилна. Хэрэв бид уучлалын бэлгийг эсэргүүцэж, наманчлахаас татгалзвал Түүний төлөөлдөг шударга ёсны шийтгэл бидэн дээр ирэх болно. “Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ” (С ба Г 19:16–17) гэж Тэр хэлсэн юм.

Тиймээс, Түүнийг үргэлж санана гэдэг нь Түүнээс нууж болдог юм юу ч байдаггүйг бид үргэлж санаж байх явдал мөн. Бидний амьдралын ямар ч тал, үйлдэл, үг хэл, тэр ч байтугай бодол санаа Эцэг, Хүү хоёрт мэдэгдэхгүйгээр өнгөрнө гэж байхгүй. Шалгалтын үеэр залилан хийсэн, дэлгүүр ухсан, үл биелэгдэх тачаангуй хүслэн эсвэл худал хэлэх нь анзаарагдалгүй буюу ажиглагдалгүй өнгөрдөггүй, мартагддаггүй мөн нууж болдоггүй. Бид амьдралаас юуг ч “зайлуулаа”, юуг ч нууж хаалаа гэсэн, цаг нь болоход цэвэр ариун хийгээд төгс шударга Бурхан, Есүс Христийн өмнө аваачигдах болно.

Энэхүү үнэн бодит байдал намайг янз бүрийн үед наманчлах буюу нүглээс зайлхийхэд тусалсан юм. Нэг удаа манайх байшингаа зарах үеэр баримт бичиг бүрдүүлэхэд алдаа гарч, би худалдан авагчаас илүү их мөнгө авах хууль ёсны эрхтэй юм шиг байдал орж билээ. Нэгэнт л надад ийм эрх байгаа учраас тэр

мөнгийг авахыг хүсч байна уу гэж миний үл хөдлөх хөрөнгийн төлөөлөгч асуув. Шударга ёсны төлөөлөл болсон Их Эзэнтэй тулгарна гэдгийг бодоод, би худалдан авагчийн алдааг ашиглан түүнийг завших хууль ёсны эрхтэй болсон юм байна гэдгийг тайлбарлах гэж оролдов. Ялангуяа тэр үед би нигүүлсэнгүй сэтгэл гаргах хэрэгтэй байснаас, худалдан авагчаас илүү мөнгө гаргуулж авах ёстой гэдэгт итгэхгүй байлаа. Илүү мөнгө авах нь шударга бус хэрэг учраас ийм байдлаар цаашид амьдарч болохгүйгээ мэдэж, гэрээг анхны байдлаар нь ойлгохоор болгож залруулах хэрэгтэй гэж би үл хөдлөх хөрөнгийн төлөөлөгчдөө хэллээ. Тэрхүү наймааны талаар надад наманчлах юм юу ч байхгүй гэдгийг мэдэх нь миний хувьд ямар ч мөнгөнөөс илүү үнэ цэнэтэй байлаа.

Би залуу байхдаа болгоомжгүйгээс дүү нарынхаа нэгийг бага зэрэг бэртээсэн юм. Тэр үед би тэр тэнэг хэргээ хүлээсэнгүй, тэгээд ч уг хэрэг явдал дахь миний оролцоог өөр “хэн ч” мэдээгүй өнгөрсөн. Олон жилийн дараа би Түүний өмнө илүү хүлээн авагдахуйц байхын төлөө миний амьдралд залруулах хэрэгтэй ямар нэг зүйл байгаа эсэхийг Бурхан надад илчилж өгнө үү хэмээн залбирах үед нөгөөх явдал санаанд минь орж билээ. Би энэ тухай мартчихаад байтал энэ бол миний гэмшвэл зохих, шийдвэрлэгдээгүй гэм нүгэл мөн хэмээн Сүнс шивнэсэн юм. Би дүүгээ дуудаж, уучлал гуйхад дүү маань тэр даруй өгөөмөр сэтгэл гарган намайг уучилж билээ. Хэрэв би уг хэрэг явдал болсон даруй уучлал гуйсан бол миний ичих сэтгэл, харуусал бага байхсан.

Олон жилийн тэртээ миний хийсэн тэр хэргийг Их Эзэн мартаагүй нь миний хувьд сонирхолтой бас утга учиртай байлаа. Нүгэл аяндаа шийдвэрлэгддэггүй эсвэл зүгээр алга болчихдоггүй юм. Нүгэл хилэнц үүрд мөнхөд далдлагдан мартагддаггүй юм. Нүгэл хилэнцийг шийдвэрлэх ёстой. Аврагчийн цагаатгагч нигүүлслийн улмаас нүгэл хилэнцийг шударга ёсны шаардлагуудыг ханган, илүү баяр баясалтайгаар шийдвэрлэж болдог нь гайхамшигтай зүйл юм.

Юуг ч анзааралгүй орхихгүй шүүлтэд дуулгавартай байдлын үйлдэл, нинжин сэтгэл, сайн үйлс аль нь ч хэчнээн ч өчүүхэн бай, хэзээ ч мартагдахгүй, тэдгээрээс ирдэг адислал хэзээ ч татан авагдахгүйг санах нь бидэнд урам зориг хайрладаг билээ.

3. Бүү ай, тусламжийн төлөө Аврагчид найд.

Сэргээлтийн анхны өдрүүдэд Мормоны Номыг орчуулахаар ажиллаж байсан бөгөөд удалгүй санваарыг

Сорилт бэрхшээл, урам хугаралт, уй гашуу бидэнд янз бүрийн замаар ирэх болно, гэвч бидний бурханлиг Өмгөөлөгчийн улмаас бүх зүйл бидний сайн сайхны төлөө эцэст хамтдаа ажиллах болно гэдгийг бид мэднэ.



хүлээн авах байсан Иосеф Смит, Оливер Каудери хоёрт Есүс зөвлөгөө өгч, тэднийг тайтгаруулсан билээ. Тэр үед Иосеф 23-тай, Оливер 22-той байлаа. Хавчлага болон бусад саад бэрхшээл байнгын биш юмаа гэхэд олон удаа тохиолддог байлаа. Ийм нөхцөл байдалд 1829 оны дөрөвдүгээр сард Их Эзэн дараах үгсийг тэдэнд хэлсэн билээ:

“Бүү ай, бяцхан сүрэг; сайныг үйлдэгтүн; дэлхий хийгээд там та нарын эсрэг нэгдэг, учир нь хэрэв та нар миний хадан дээр баригдсан байх аваас тэд дийлэх нь үгүй.

Болгоогтун, би та нарыг эмлэх нь үгүй; өөрсдийнхөө замаар явж, мөн нүглийг дахин бүү үйлд; та нарт миний зарлигласан ажлыг буурь суурьтайгаар гүйцэтгэгтүн.

Санаа бодол болгондоо над уруу харагтун; бүү эргэлз, бүү ай.

Миний хажуу талыг цоо хатгасан шархыг мөн түүнчлэн миний гар мөн хөлөн дэх хадаасны ормуудыг болгоогтун, миний зарлигуудыг сахигтун. Амен” (С ба Г 6:34–37).

Бодол бүрдээ Аврагч уруу харах гэдэг нь мэдээжийн хэрэг “үргэлж түүнийг сана” гэдгийг өөрөөр хэлж байгаа юм. Бид ингэсэн тохиолдолд эргэлзэх буюу айх хэрэггүй. Аврагч Өөрийн Цагаатгалаар дамжуулан тэнгэр, газар дахь бүх хүчийг өгснийг Иосеф, Оливер хоёрт сануулснаа бидэнд бас сануулдаг (Матай 28:18-ыг үз) бөгөөд биднийг хамгаалах болон бидний хэрэгцээнд үйлчлэх чадвар, хүсэл аль аль нь Түүнд байдаг. Бид зөвхөн итгэлтэй байх хэрэгтэй мөн Түүнд бүрэн итгэж болно.

Иосеф, Оливер хоёрт ирсэн тайтгаруулах илчлэлтийн өмнө Аврагчид найдвар тавьж, хүмүүний санаа бодол, дарамт шахалт,

сүрдүүлэг заналхийллээс айхгүй байхыг захисан зүрх шимширч, сэтгэл өвтгөм туршлагыг Бошиглогч биеэрээ туулсан билээ.

1828 оны зургадугаар сард Иосеф Мормоны Номын эхний 116 хуудас гар бичмэлийг гэр бүлийн гишүүддээ үзүүлэхээр Пеннсилваний Хармонигаас Нью-Йоркийн Пальмира уруу авч явахыг Мартин Харрист зөвшөөрчээ. Мартин амласан хугацаандаа эргэж ирсэнгүйд санаа зовсон Иосеф морин тэрэг хөлсөлж Нью-Йоркийн Манчестер хотод байсан эцэг эхийнхээ гэр уруу яаран гарчээ. Бошиглогч ирсэн даруйдаа Мартиныг ирүүлэхээр хүн явуулав. Мартин ирсэн ч, гар бичмэл нь алга болсон эсвэл хаана байгааг нь мэдэхгүй байна гэв.

“Ай халаг! Бурхан минь, Бурхан минь. . . . Бүх зүйл ингээд өнгөрдөг байж. Одоо би яана аа? Би нүгэл үйлдлээ. Би Түүнээс буруу юм гуйснаараа Бурханыг хилэгнүүлээ. . . . Бүхний Дээдийн тэнгэр элч намайг яаж тохуурхах бол оо” гэж дуу алдсаныг ээж Люси Мак Смит нь тэмдэглэсэн байдаг.

Маргааш нь Бошиглогч Хармонид эргэж ирэв. Тэнд ирээд тэрээр, “Би Их Эзэний мутраас нигүүлслийг олж, . . . түүний хүслийн эсрэг үйлдсэн бүхнийхээ төлөө уучлагдахын төлөө чин сэтгэлийн хүчтэй залбирал хэлж, Түүний өмнө өөрийгөө даруусгав.”²

Бурханаас биш, хүнээс айсных нь төлөө Их Эзэн Иосефыг зэмлэсний дараа түүнд ийн хэлжээ:

“Чи бол Иосеф, мөн чи Их Эзэний ажлыг хийхээр сонгогдсон байсан болой, харин гэм буруугийн улмаас хэрэв чи сонор сэрэмжгүй байх аваас, чи унах болно.

“Гэвч санагтун, Бурхан нигүүлсэнгүй юм; тиймийн тул миний чамд өгсөн зарлигийн эсрэг хийсэн зүйлээ наманчлагтун, мөн чи сонгогдсон хэвээр байгаа, мөн тэр ажилд дахин дуудагдсан бөлгөө” (С ба Г 3:9–10).

“Их Эзэн Урим ба Туммимыг ялтсуудын хамт Иосефоос түр хугацаагаар авсан ч, тэдгээрийг удалгүй түүнд буцааж өгсөн билээ. “Тэнгэр элч Урим ба Туммимыг надад буцааж өгөхдөө баяр хөөр болон, Бурхан миний итгэлтэй, даруу байдалд баярлаж, наманчлан, хичээнгүйлэн залбирсанд намайг хайрласан шүү” хэмээн хэлж билээ. Ингэснээрээ би үүргээ сайн биелүүлж . . . орчуулгын ажлаа дахин эхлэх боломжтой болсон юм” хэмээн Бошиглогч дурссан байдаг. Иосеф Их Эзэнээр уучлагдсаныхаа төлөө сэтгэл сэргэн баясаж, Түүний хүслийг биелүүлэх шинэчлэгдсэн шийдвэр төгс байдлаар хүч сэлбэн, өмнөө тулгарсан агуу ажлыг хийхээр явлаа.”³

Бурханд итгэл найдвар тавьж, хүмүүний хийж чадах

зүйлээс айхгүй байх Бошиглогчийн шийдвэр төгс байдал энэ туршлагын дараа улам бат бөх болсон ажээ. Тэр явдлаас хойш түүний амьдрал Христийн хүч болон нигүүлсэлд итгэл найдвар тавьснаар Түүнийг санана гэдэг нь чухам юу болохын гайхамшигт үлгэр жишээ болсон билээ. Иосеф энэ ойлголтыг Миссурийн Либертид маш хүнд хэцүү нөхцөлд хоригдож байхдаа дараах үгсээр илэрхийлсэн юм:

“Шуурганы үед маш том хөлөг онгоц нэн жижигхэн залууртай явснаар салхи хийгээд давалгаатай зохицолдон нэн их ашигтай байдгийг ах дүүс минь та нар мэднэ.

“Тиймийн тул эрхэм хайрт ах дүүс минь, өөрсдийн хүчинд байгаа бүх зүйлийг зоригтой хийцгээе; мөн тэгээд бид бат итгэлтэйгээр бат зогсож, Бурханы авралыг харна, мөн учир нь түүний гар илчлэгдэх болно” (С ба Г 123:16–17).

Товчоор хэлбэл, “түүнийг үргэлж санана” гэдэг нь бид айж амьдрах ёсгүй гэсэн үг юм. Сорилт бэрхшээл, урам хугаралт, уй гашуу бид бүгдэд янз бүрийн замаар ирэх болно, гэвч бидний бурханлиг Өмгөөлөгчийн улмаас бүх зүйл бидний сайн сайхны төлөө эцэст хамтдаа ажиллах болно гэдгийг бид мэднэ (С ба Г 90:24; 98:3-ыг үз). “Юм бүхэн нааштай үр дүнд хүрэх болно” хэмээн Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) итгэлийг ийнхүү энгийнээр илэрхийлсэн юм.⁴ Бид Аврагчийг үргэлж санаснаараа, “өөрсдийнхөө чадах бүхнийг зоригтой хийж, Түүний хүч болон биднийг хайрлах хайр нь биднээр дамжин илрэх болно гэдэгт итгэлтэй байж болно.

“[Бид] түүний сүнснийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд” (С ба Г 20:77) Түүнийг үргэлж санацгаая. Би Есүс Христийн Цагаатгалын хүчийг гэрчилж байна. Амилсан Их Эзэн амьд гэдэг нь үнэн бодитойг гэрчилж байна. Бид бүгдийг хайрладаг Эцэг, Хүү хоёрын хязгааргүй хайрыг миний бие гэрчилж, тэрхүү хайрын бүхий л илрэлийг бид байнга санаж амьдрахын төлөө залбирч байна. ■

Айдахо дахь Бригам Янгийн Их Сургууль дээр 2009 оны нэгдүгээр сарын 27-нд хэлсэн үгнээс. Энэ үгийг англи хэлээр сонсохыг хүсвэл web.byui.edu/devotionalsandspeeches/default.aspx-хаяагаар ор.

ЭШЛЭЛ

1. Brigham Young, “Discourse,” *Deseret News*, 1856 оны 9-р сарын 10, 212.
2. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 69, 71-ийг үз.
3. *Teachings: Joseph Smith*, 71.
4. Жеффри Р.Холланд, “President Gordon B. Hinckley: Stalwart and Brave He Stands,” *Луахона*, June 1995 оны 6-р сар, тусгай дугаар, 6.

Ребека Свейн Виллямс: ТУУШТАЙ БӨГӨӨД ГУЙВШГҮЙ

ЗУРАГ ЧИМЭГТЭЙЛЭГ РИЧАРД ХАЛП

Гэрийнхэн нь Сүмд дайсагнан ханддаг байсан ч анхны энэ хөрвөгч Их Эзэний ажилд итгэлтэй, чин үнэнч хэвээр үлдсэн юм.

Жаниес Лин Жонсон

1834 оны 6-р сард эцэг нь өвлөх эрхийг нь хассан, нэгэн залуу эх Сэргээлийн тухай итгэл үнэмшлээ хуваалцсан зоримог бөгөөд сэтгэл догдлом захидал бичжээ. Ребека Свейн аавынхаа бодол санааг өөрчилж чадах магадлал бага гэдгийг мэдэж байсан ч, ирээдүйн үр дагавруудыг нь үл хайхран бат бөх итгэлтэй хэвээр үлдсэн ажээ. Мормоны Ном болон Сүм нь Бошиглогч Иосеф Смитийн тунхагласан шиг үнэн гэдгийг, мөн “Ариун Тэнгэр элч тэнгэрээс бууж ирэн, ялтсуудыг [авчирч], тэдний нүдний өмнө [тавьсныг] харсныг Гурван Гэрч олон хүн оролцсон хурал дээр тунхагласныг” тэрээр сонссон гэдгээ эцэг Айзиктаа хэлжээ.¹

Ребекагийн гэрчлэл зөвхөн хүчтэйгээрээ төдийгүй бас гуйвшгүй хийгээд шантаршгүй хүсэл зоригийг илэрхийлснээрээ сэтгэл догдлом юм. Аав нь түүнийг эсэргүүцэж, нөхөр Фредерик Ж.Виллямс нь нэг хэсэг Сүмд сэтгэл дундуур байсан ч Ребека итгэлээрээ хэзээ ч гуйвж

байсангүй. Гуйвшгүй итгэлтэй, шантаршгүй зоригтой Ребека, өнөөдөр амьдралын хүнд сорилт бэрхшээлүүдтэй тулгарсан үед, тэр ч байтугай бидний ойр дотны хүмүүс бидний итгэл бишрэлийг эсэргүүцэж, үл ойшоосон үед бид хэрхэн бат бөх, гуйвшгүй байх талаар бидэнд үлгэр жишээ болж байна.

Сүмд хөрвөсөн нь

1798 онд АНУ-ын Пеннсилванид төрсөн Ребека Свейн 10 хүүхдийн отгон нь байжээ.² Түүнийг ес орчим настай байхад гэр бүл нь Нэгдсэн Улс, Канад хоёрын хилийн ойролцоох Найгарад шилжин ирэв. Тэд Найгара цайзад ойрхон байсан болохоор 1812 оны Дайны үед цайзыг довтолж байсан буун дуу тэдэнд сонсогддог байжээ. Тэгэхэд бяцхан охин Ребека айхыг мэддэггүй зоригтойгоо харуулсан аж. Нэг удаа ганцаараа ойд явж байгаад зам дээр баавгайтай халз тулгарчээ. Тэр барьж явсан нарны шүхрээ баавгайн нүүрний өмнө хэдэн удаа дэлгэж, хумихад баавгай зугтсан гэдэг.³

Ребека 17-той байхдаа Детройтод амьдардаг эгчтэйгээ уулзахаар Онтарио нуурыг гатлан аялав. Тэр уг аяллын үеэр хар нүдтэй, өндөр нуруутай, усан онгоцны жолооч Фредерик Гранжер Виллямстай танилцсан аж. Тэдний байнгын уулзалт хайр болон хувирч тэр хоёр 1815 оны сүүлчээр гэрлэв. Виллямсынхан 1828 оны орчим Кертландад бүрмөсөн суурьшихын өмнө АНУ-ын Баруун Огайогийн их дархан цаазтай газрын ойролцоо шилжин иржээ. Нөхөр нь анагаах ухааны мэргэжилтэй болохоор шийдэж, ур чадвараараа нэлээд нэрд гарахад Ребека ажил төрөлд нь тусалж сурчээ. Тэд дөрвөн хүүхэдтэй болов.

1830 оны намар Кертландад анхны Мормон номлогчид ирэв. Ребека тэднийг анхааралтай сонсож, номлогчдын бүх хурал цуглаануудад оролцоходоо хүүхдүүдээ дагуулж ирдэг байв. Боломж олдох бүрийд Фредерикийн эмнэлгийн ажилд оролцдог байв. Тэр хоёр сайн мэдээг хамт судалж, ярилцан, суралцдаг байсан ч Фредерик төдий л тууштай байсангүй. Харин Ребека сайн мэдээ үнэн гэдэгт бат итгэсэн байлаа.



Гэр бүлийн намтар бичигч нэгэн хожим нь Ребекаг Едений Цэцэрлэгт Еватай адилхан хүн байсныг дүрслэн: тэр бол “сайн мэдээнд бүрэн дүүрэн нөхөрлөхөд хөл тавих “зайлшгүй шаардлагатайг хамгийн түрүүнд харсан хүн” байлаа хэмээн бичжээ.⁴ Тэр 1830 оны 10-р сард баптисм хүртэв.

Фредерик мөн л тодорхой биш хэвээр байв. Тэр заримдаа Сүмийг орхихыг хүсдэг байсан ч эцэст нь, тэрхүү ариун судрын шинэ ном: Мормоны Номонд сэтгэл татагдахгүй байж чадсангүй. Сүнс түүнтэй ажилласнаар тэрээр сайн мэдээ үнэнийг мэдэж, баптисм хүртэн, Ребекагийн үлгэр дууриалыг дагажээ.

Онцгой үйлчлэл

Сүм Фредерик, Ребека хоёрын амьдралд гол суурийг эзэлснээр гэр бүлд нь үзүүлэх нөлөө нь тэр даруй харагдсан байна. Фредерик баптисм хүртэж, гишүүн болсон даруйдаа ахлагчаар томилогдов. Ердөө маргааш нь тэр Оливер Каудеритай хамт хэдэн долоо хоног номлолд үйлчлэх даалгаврыг урамтайгаар хүлээн авчээ. Тэд гурван долоо хоног номлол хийх ёстой байсан ч тэр нь Миссури уруу хийсэн 10 сарын аялал болсон гэдэг. Тэрээр удаан хутацаанд гэрээсээ хол явсан нь Ребекагийн хувьд анхных нь байлаа. Цаашид ийм явдал олон удаа тохиожээ. Фредерик номлолын ажилд идэвхтэй оролцдог байсан болон Тэргүүн Зөвлөлд дуудагдаж ажлаар байнга гадагшаа явдаг байлаа. Ребека анхны Мормон эмэгтэйчүүдийн адил олон сараар гэр орноо авч яван, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлдэг байв.

Ребека хэчнээн их ажилтай байсан ч итгэлтэй хэвээр байж, хүсэл эрмэлзэлтэйгээр үйлчилдэг байлаа. Смитийнхэн Кертландад анх шилжиж ирэхдээ Бошиглогч Иосеф Смит гэр бүлийнхээ хамт Виллямынд

хэсэг хугацаагаар амьдарч байжээ. Ребека Бошиглогч болон түүний гэр бүлд хүнд үед нь анхаарал тавин тусалж, тэдэнд үнэнчээ харуулсан юм. Нэг удаа танхайрагч бүлэг Иосефыг хайж ирэн тэдний гэрийг бүслэхэд, Ребека Иосефт өөрийнхөө бүчтэй малгай, хувцсыг өмсгөн дүрийг нь хувиргаж нуужээ. Иосеф байшингаас гарч бужигнасан олны дундуур эсэн мэнд гарч явсан гэдэг.

1832 оны 3-р сард танхайрагч бүлэг Огайогийн Хайрам дахь Жон Жонсоны ферм уруу дайран орж ирж, Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт бүдүүлгээр халдахад Ребека Бошиглогчид дахин үнэлж баршгүй тусалсан байна. Танхайрагч бүлэг Сиднейг ухаан алдтал зодсоны дараа Иосефын ам уруу хор цутгахыг оролдож, Бошиглогчийн биед давирхай асгаж, өд наасан ажээ. Эмма Смит нөхрөө хараад давирхайг нь цус гэж бодон ухаан алдсан гэдэг.⁵ Ребека, Фредерик хоёр шөнөжингөө Иосефын шалбарсан биеэс давирхайг салгаж, Смитийн хүүхдүүдэд анхаарал, халамж тавьсан ажээ. Тэдний ачаар Иосеф маргааш өглөө нь номлох хүч чадлыг олсон байлаа.

Сайн мэдээг итгэл үнэмшилтэйгээр хуваалцсан нь

Ребекагийн өдрийн бодол, шөнийн зүүд болсон нэг найдвар нь өөрийнх нь гэр бүл, ялангуяа аав нь сэргээгдсэн сайн мэдээг болон итгэлийн агуу адислалуудыг хүлээн аваасай гэсэн хүсэл байлаа. Тэрээр Лихайн адил Бурханы хайрыг мэдрч, түүнийг ойр дотны хүмүүстэйгээ хуваалцахыг хүсдэг байлаа (1 Нифай 8:12-ыг үз). Ребека хөрвөлтийн болон гэрчлэлийнхээ тухай, Сүмийн гишүүн болсноор өөрт нь ирсэн агуу баяр баясгалангийн тухай сэтгэл догдлом захидалыг гэрийнхэндээ бичжээ.

Гэвч Ребекагийн хөрвөлт аавыг

нь хилэгнүүлсэн аж. Аав нь хэдхэн үгтэй хариундаа түүнийг Сүмээс гарахыг шаардсан байв. Гэвч энэ нь Ребекад огтхон ч нөлөөлсөнгүй. Гэр бүлийн нэгэн түүхчийн бичсэнээр, “Мормоны сургаал үнэн гэдэгт итгэх түүний итгэл үнэмшил, гэрчлэл урьд өмнөхөөсөө улам бат бөх боллоо” хэмээн тэрээр хариулсан ажээ.⁶ Харамсалтай нь энэ захидал түүний хүсэн хүлээсэн үр дүнд хүргээгүй аж. Аав нь, хэрэв түүнийг Сүмийг орхихгүй бол охиноо гэж үзэхээ больж, түүнээс бүх харилцаагаа таслах болно гэж сүрдүүлжээ.

Гэвч Ребека бууж өгсөнгүй, сайн мэдээг хуваалцах хүч чармайлтаа үргэлжлүүлсээр байв. 1934 онд тэр аавдаа өөр нэг захидал бичсэн нь өдий хүртэл хадгалагдаж үлдсэн бөгөөд тэр захидалдаа гүн итгэл бишрэлээ болон аав нь Мормончуудын юуг нь ч хүлээн зөвшөөрөхөөс татгалздагт нь сэтгэл эмзэглэдгээ илэрхийлсэн аж.

Аав нь Сүмийг, ялангуяа Мормоны Номыг болон Гурван Гэрчийн гэрчлэлийг дайран давшилсан сонины өгүүлүүдийг уншсан байжээ. Иймээс Ребекаг итгэл бишрэлээ орхи хэмээн ятгахыг тэр хичээдэг байжээ.

“Мормоны Номын талаар таны бодол санаа ийм ихээр мушгин гуйвуулагдсаныг сонсоод миний сэтгэл эмзэглэлээ” хэмээн тэр бичжээ. Ребека Мормоны Номын судраас болон Иосеф Смитийн шинэ илчлэлтүүдээс эш татан Мормоны номын тухай гэрчлэлээ хуваалцсан аж. Мөн энэ номыг гэрчлэх гурван гэрчийг сонгон авах болно гэдгийг уг номонд бошиглогсныг тэр бас тайлбарлажээ. Тэрээр үүний нотолгоо болгон, “гурван гэрчийн амаар” энэ ном үнэн нь “нотлогдох болно” (Ифер 5:4) хэмээн хэлсэн эртний бошиглогч Иферээс эш татсан аж.⁷

Тэгээд Ребека Гурван Гэрч— Давид Витмер, Мартин Харрис,

Оливер Каудери нарыг өөрийн нүдээр харсныг, мөн тэд тэнгэр элчийг болон алтан ялтсуудыг харснаа гэрчлэхийг нь сонссоноо дүрсэлжээ. Тэр тэдний гэрчлэл болон зан төлөвийг хамгаалаад дараа нь уг ажлыг анхааралтай судалж үзэхийг ааваасаа шаргуу хүссэн аж. Иймээс тэрээр, “хэрэв ээж та хоёр энэ ажлын талаарх бидний байр суурь, нөхцөл байдлыг мэдэхийг хүсч байгаа бол, үүнд итгэхийг би та хоёроос хичээнгүйлэн гуйж байна” гэж аавдаа бичжээ.⁸

Ребека Мормоны Номын төгсгөлдэх Моронайн амлалтыг давтан, “тэрээр [тэдний] оюун ухааныг үнэний замаар гэгээрүүлж өгөхийг” Бурханаас асуухыг гэр бүлээсээ гуйсан байна. Тэгээд тэрээр эцэг эхдээ туслахын тулд “Сайн мэдээг Есүст байгаа чигээр нь заах чадвартай” нэг номлогчийг тэдэн уруу явуулахаар төлөвлөсөн аж.⁹ Эцэстээ аав нь энэ талаар ямар ч хариу ирүүлсэнгүй.

Тэр ч байтугай онцгой ойр дотно байдаг ах Жондоо бичсэн Ребекагийн захидлуудыг задалж үзэлгүйгээр буцаадаг байв. Тийнхүү буцаасан захидлуудын нэгнийх нь ар талд, “Аав намайг чиний захидлуудыг унших буюу хариу бичихийг хориглосон юм. Баяртай. Бурхан чамайг үргэлж адислаг. Жон ах чинь” гэж бичсэн байжээ.¹⁰

Гэвч Ребекагийн номлолын хүч чармайлт эгч Сара Свейн Кларкийн хувьд амжилт олжээ. Сара 1832 онд Мичиганд Сүмд нэгдсэн аж. Сарагийн охид бас сүмд элсэж, насан туршдаа итгэлтэй байжээ.

Эцсийг хүртэл итгэлтэй байсан нь

Аавынхаа сонголтын улмаас Ребекагийн зүрх шархиран өвдөг байсан ч тэр аавдаа хайртай



хэвээр үлдсэн юм. “Би эцгийнхээ мах цусны тасархай учраас зүрх сэтгэлдээ уйлан гашууддаг. . . Их Эзэн таныг эцсийн өдөр Ариун Сүнсээрээ тайтгаруулахыг төлөө тэдгээр өдрүүд таны хамгийн сайхан өдрүүд байхын төлөө би залбирдаг. . . Оюун ухаан тань энэ ажлыг хүлээн зөвшөөрөх болно гэдэгт би найдна. Их Эзэн биднийг харж байгаа гэдгийг мэддэгтээ бат итгэлтэй байгтун.”¹¹

Ребека зөвхөн эцгийнхээ итгэлгүй байдалтай тэмцэх төдийгүй нөхрийнхөө итгэл тууштай биш байснаас үүдэлтэй асуудлуудыг даван туулах хэрэгтэй байлаа. 1837, 1838 оны турш тэр үед Тэргүүн Зөвлөлийн гишүүн асан, нөхөр Фредерик нь Сүмийн удирдагчидтай удаа дараа санал зөрөлдөж байв. Тэр ч байтугай тэр нэг үе Сүмийг орхиж, улмаар гишүүнчлэлээс хасагджээ. Гэвч Фредерик удалгүй өөрийгөө даруусган, Сүмд дахин нэгдсэн бөгөөд нас барахдаа бүрэн идэвхтэй байлаа. Тэр үе дэх Ребекагийн бодол санааны талаар бидэнд ямар нэг баримт байдаггүй. Гэвч тэр Гэгээнтнүүдэд тууштай үнэнч итгэлтэй хэвээр үлдсэндээ харамсаагүй юм.

Фредерикийн санал зөрөлдөөний талаарх

цуу үг Нью-Йоркод байсан Ребекагийн аав Айзикт хүрэхэд тэрээр Ребека бас шүтлэг бишрэлээ орхих болов уу гэж бодсон аж. Гэвч Ребека итгэлдээ үнэнч хэвээр үлдэнэ гэдгийг харуулсан захидлыг аавдаа явуулжээ. Айзик охиныхоо хариут уншаад, толгойгоо удаан сэгсэрч, “наманчилсан ганц ч үг байдаггүй шүү” гэсэн гэдэг.¹²

Ребека Иосеф Смитийг болон сэргээгдсэн Сүмийг тууштай хамгаалдаг байлаа. Ребека эцгийнхээ үгийг дагалгүйгээр Сүмийг сонгосны улмаас олон золиослолтой тулгарсан ч түүнийг үргэлж хүндэтгэдэг байв. Аавынхаа заасан зүйлийг тэр өндөр үнэлж, хайр, талархлаа түүнд илэрхийлдэг байлаа. Тэрээр 1834 онд бичсэн захидлаа “хайрт ааваасаа хүлээн авдаг байсан зааврыг . . . үүрд санаж явах” болно гэсэн үгсээс өөр юу ч бичээгүй төгсгөжээ.¹³

1839 онд Ребекагийн аав нас барав. Яг гурван жилийн дараа тэр эр нөхрөө алдав. Ребека сэтгэл эмзэглүүлэм хүнд сорилтуудыг даван туулж, итгэл, зоригоор эцсийг хүртэл тэвчсэн юм. Гэгээнтнүүд Ютаг зорин өрнөд уруу хүнд аян хийсэн үед тэрээр хүү Эзрагийнхаа гэр бүлтэй хамт өөрийнхөө морин тэргийг жолоодож явсан

ажээ. Хожим нь тэрээр Милл Грийк дэх фермийг хариуцан ажиллуулж байв. Солт Лейкийн Табернека баригдаж дуусч, Гэгээнтнүүдээс юу чадахаа хандивлахыг хүсэхэд тэр иж бүрдэл мөнгөн халбагануудаа ариун ёслолын ширээнд зориулан тосгуур хийхэд ашигла гэж өгчээ. 1860 онд Ерөнхийлөгч Бригам Янг түүний гэр бүлийг Ютагийн алслагдсан Кач Валлид суурьшуулахаар дуудахад бие нь их муу байсан ч, тэр морин тэргээ дахин жолоодон дуртайгаар шилжин суурьшжээ.

Ребека 1861 оны 9-р сарын 25-нд Ютагийн Смитфилдэд нас барав. Тэрээр итгэлдээ, үнэний мэдлэгтээ, биеэр үзэж туулсан бүхэндээ чин үнэнч байлаа. Тэрээр “хичээнгүй мөн гуйвшгүй” (Мозая 5:15) хэвээр үлдсэн юм. ■

Зөв бичгийн дүрэм, цэг тэмдгийг шинэчилсэн.

ЭШЛЭЛ

1. Ребека Свейн Виллямаас Айзик Фишер Свейнд, 1834 оны 6-р сарын 4, Сүмийн түүхийн номын сан, Солт Лейк хот.
2. Намтрын мэдээллийг дараах өгүүлүүдээс авчээ, *Meet Dr. Frederick Granger Williams . . . and His Wife Rebecca Swain Williams: Read Their True Story in the First Introduction—after 100 Years* (1951); and Frederick G. Williams, “Frederick Granger Williams of the First Presidency of the Church,” *BYU Studies*, боть 12, no. 3 (1972): 243–261.
3. Виллямс, *Meet Dr. Frederick Granger Williams*, 5.
4. Виллямс, *Meet Dr. Frederick Granger Williams*, 55.
5. *History of the Church*, 1:263.
6. Виллямс, *Meet Dr. Frederick Granger Williams*, 63.
7. Ребека Виллямсын 1834 оны 6-р сарын 4-ний өдрийн захидлыг үз.
8. Ребека Виллямсын захидал, 1834 оны 6-р сарын 4.
9. Ребека Виллямсын захидал, 1834 оны 6-р сарын 4.
10. Виллямс, *Meet Dr. Frederick Granger Williams*, 63.
11. Ребека Виллямсын захидал, 1834 оны 6-р сарын 4.
12. Жорж Свейний захидал, 1839 оны 3-р сарын 17, машиндсан хувь, Сүмийн түүхийн номын сан, Солт Лейк Хот
13. Ребека Виллямсын захидал, 1834 оны 6-р сарын 4



МАРШАЛЛЫН АРЛУУД УРУУ ДАЛАЙГААР ЗӨВ ЗАМААР ХӨВДӨГ БАЙСАН НЬ

Жошуа Ж.Перки

Сүмийн сэтгүүлүүд

Эрт үед далайчид тэнгис, далайгаар аялахдаа нар, сар, оддын байршлаар баримжаалан хөвдөг байжээ. Тэд шөнө болоход Алтан гадас одыг нүд салгахгүй хардаг байж. Энэ одны байршил өөрчлөгддөггүй нь далайчдад тэнгэр дэх зангуу болж, хүрэх газар уруугаа зөв замаар хөвөхөд тусалдаг байсан аж.

Номхон далайн Маршаллын арлуудад далайчид өөр нэг арга техникийг нээж олсон гэдэг. Тэнд далайн арлууд болон шүрэн арлуудын хооронд байнга давалгаа нэг янзын хэлбэртэй байдгийг мэджээ. Туршлагатай далайчин нэг арал буюу шүрэн арлаас нөгөө арал уруу араасаа гудамлан хөврөх далайн өндөр, нам давалгаануудыг даган хэдэн зуун километр аялж чаддаг байсан гэнэ. Далайн өндөр, нам давалгаа хаана байгааг болон хаашаа явж байгаагаа мэддэг хүмүүс бусад аялагчдыг хүрэх газар уруу нь аюулгүй удирдаж чаддаг байв.

Сүмийн гишүүд бидний хувьд Есүс Христ бол жинхэнэ гэрэл нь биднийг удирддаг бидний төгс үлгэр

жишээ мөн. Түүний хуулиуд болон ёслолууд нь биднийг тэнгэр дэх гэр орон уруу маань дээрх далайн давалгаа лугаа адил аюулгүй удирдаж чадна. Бидэнд үйлчилж, дэмжлэг үзүүлдэг Далайгаар Хөвөгч Эзэний үүргийг гүйцэтгэдэг хүмүүс байдаг. Дараах болсон явдлуудад Маршаллын гурван гишүүн хад чулуутай, гүехэн ус болон амьдралын шуурган дундуур Христ уруу удирдан бусад хүнд хэрхэн тусалсан тухайгаа хуваалцаж байна.

Зөв шударга эмэгтэйн нөлөө

Хиробо Обекетанг буйдандаа буцаж суугаад инээмсэглэв. Дөнгөж сая эхнэр Линда нь дөрвөн хүүхэд, номлогч эгч нартай хамт гэр бүлийн үдшээ хийгээд дуусчээ. Тэд Маршаллын арлуудын нийслэл Махурогийн хүмүүсийн заншлаар загасыг нүд, сүүлтэй нь шаран хоол хийж номлогчдыг дайлжээ. Хиробо амьдралынхаа тухай өгүүлэхдээ Сүмд, сайн мэдээнд болон гэр бүлдээ,



Хад чулуутай, амьдралын гүехэн усан дундуур аялах үед тэнгэр дэх гэр орондоо буцаж очиход минь бидэнд туслах итгэлтэй гишүүдийн удирдамжаас бид ашиг тусыг олдог.

ялангуяа гэргийдээ хэчнээн их баярлан талархаж явдгаа илэрхийллээ.

2009 оны зургадугаар сарын нэгэн өдөр Маршаллын арлуудын Махуро гадас байгуулагдахад Хиробо гадасны анхны гүйцэтгэх нарийн бичгийн даргаар дуудагджээ. Хиробо бол гадасны шинэ ерөнхийлөгч Арлингтон Тибоны дүрсэлснээр тус арлын “туйлын бат бөх итгэлтэй удирдагчдын” нэг юм.

Гэвч Хиробо саяхныг хүртэл тийм итгэлтэй байгаагүйгээ өөрөө хэллээ. Хэрэг дээрээ бол амьдралд нь гарсан өөрчлөлтийг тэрээр бат бөх итгэлтэй эхнэрийнхээ ач гавьяа хэмээн үздэг ажээ. Тэрээр, “Би наймтайдаа баптисм хүртсэн ч 16-тайдаа идэвх султай болсон” гэв.

Хэдэн жилийн дараа Линда тэр хоёр хамт амьдардаг болсон ч гэрлээгүй байлаа. Линда Сүмийн гишүүн биш байв. 2000 онд Линда Хиробог хүүхэд байхдаа баптисм хүртсэнийг олж мэдээд удалгүй Сүмийг сонирхож, номлогч эгч нартай уулздаг болов.

“Тэр сайн мэдээг хоёр жил судалсны дараа баптисм хийлгэхээр шийдсэн юм” хэмээн Хиробо өгүүлэв. “Бид хоёр эхлээд гэрлэх ёстой байсан ч би гэрлэхийг сонирхдоггүй байлаа. Би төөрөлдөж, дэлхийн уруу таталтуудад үнэхээр автагдсан байлаа. Би гэр бүлийн ач холбогдлыг ойлгодоггүй, өөр хэн нэгэнд анхаарал халамж тавьдаггүй, бас хэнийг ч сонсдоггүй байлаа.”

Линда баптисм хүртээгүй ч хүүхдүүдээ Сүмд өсгөн хүмүүжүүлсэн юм. Линда баптисм хүртэхийн тулд гэр бүл болъё гэж Хиробог жил бүр гуйдаг байсан ч тэр тухай бүр нь үгүй гэдэг байсан гэнэ. Хэдэн жил өнгөрөхөд охидоос хоёр нь баптисм хүртсэн ч Хиробо тэдний баптисм дээр очоогүй аж.

2006 онд тэдний найман настай хүү Такао цочмог халууран татаж нас барав. Махуро дүүргийн 300 орчим гишүүн энэ гэр бүлийн гашуудлыг хуваалцахаар хүүгийнх нь оршуулганд иржээ.



“Тэдний сэтгэл санааны дэмжлэг надад үнэхээр том зүйл байлаа.” “Бурхан надад ямар нэг зүйлийг хэлэх шиг санагдаж билээ” гэж Хиробо хэлэв.

Тэр өөрөө Сүмийн гишүүн ч, эхнэр нь яагаад баптисм хүртэж чадахгүй байгаагийн шалтгааны талаар бодож эхэлжээ. Түүний итгэл улам бэхжсээр байлаа. Эхнэр минь үнэхээр надад сүнслэг нөлөө үзүүлдэг байсан” гэж тэр яриу.

“Иймээс би суугаад амьдралынхаа өнгөрсөн замналыг эргээд нэг бодож үзэв. ‘Би ер нь зөв юм хийж



байна уу? Амьдралынхаа үлдсэн хугацаанд Бурханы төлөө ажиллах боломж надад байна уу? хэмээн өөрөөсөө асуулаа. Би залбирч, Сүмд эргэж очин Бурханы төлөө ажиллах тухай боддог боллоо.”

Хиробо номлогчидтой хамт сайн мэдээг судалж, сургаалаас дахин суралцаж эхлэв. Маршаллын арлуудын Махуро Номлолын ерөнхийлөгч Нелсон Блик болон



Патрици болон түүний дүү нарт шийдвэрлэгч үйл явдал болсон гэнэ.

“Аав минь өөрчлөгдсөнийг би харсан” гэж тэр хэллээ. Сайн мэдээ аавын зүрх сэтгэлд нөлөөлсөн юм чинь миний зүрх сэтгэлд нөлөөлж, амьдралыг минь өөрчилж чадна” гэдгийг би мэдэж байлаа. “Иймээс би сайн мэдээг номлогч эгч нартай хамт судлахаар шийдэхэд тэд намайг Мормоны Ном, Библи хоёрыг унш гэв. Түүнээс өмнө би эрэгтэй дүүтэйгээ сүрхий муудалцаад, түүнийг уучилж чаддаггүй байлаа. Тэгтэл хэрэв чи бусдыг уучилбал Бурхан чамайг уучилна гэдгийг би судруудаас

уншлаа.” (3 Нифай 13:14–15-ыг үз.)

Амьдралаа цэвэр ариун болгож өөрчлөн, амар амгалан байхын тулд дүүгээ уучлах ёстойг Патрици ойлгосон аж. Тэгээд дүүгээ уучилжээ.

“Муу зангаа орхиж, зарлигуудыг сахьдаг шинэ хүн болсондоо сэтгэл хэчнээн догдолсон гээч. Үнэн Сүмийн гишүүн болохын тулд баптисм хүртэх ёстойгоо би ойлгосон” гэж тэр ярилаа. “Сүм намайг зөв зам дээр гаргаж, муу нөлөөнөөс тусгаарласан юм. Эцэг эхээ хүндлэхийг, сургуульдаа явахыг, зөв зам дээрээ үргэлж байхыг Сүм надад заасан.

бусад гишүүн, түүний дотор дүүргийн ерөнхийлөгч Арлингтон Тибоны адилаар түүнтэй найз нөхөд болжээ. Эцэстээ, Хиробо сүмдээ буцаж очихоор шийдсэн аж. Тэр удалгүй зөвхөн ариун ёслолын цуглаанд төдийгүй Ням гарагийн хичээл, санваартны цуглаанд оролцдог боллоо. Эцэст нь Хиробо шийдвэрээ гаргав.

“Би сүмдээ эргэж ирээд, ‘Энэ бол миний шийдвэр’ гэж өөртөө хэлсэн. Энэ шийдвэр миний амьдралыг бүрмөсөн өөрчилсөн юм.”

Хиробо Линда хоёр 2008 оны наймдугаар сарын 30-нд гэрлэв. Тэр удалгүй Аароны санваар авч, эхнэртээ баптисм хүртээжээ. Хиробо хоёр сарын дараа Мелкизедек санваар авч, дүүргийн гүйцэтгэх нарийн бичгийн даргаар дуудагдав.

Хиробо эхнэрээ хараад инээмсэглэв. “Намайг өөрт нь баптисм хүртээнэ гэж эхнэр маань огт бодоогүй шүү” гэж хэллээ. “Тэр баптисм хийлгэхийн тулд 2000 оноос 2008 он хүртэл бүтэн найман жил хүлээснийг бод л доо. Миний хань гайхамшигтай хүн дээ.”

Зөв шударга эцгийн үлгэр жишээ

Зарим үед бидний хөтөч далайчин лугаа адил бидэнтэй нягт хамтран ажиллаж, амьдралаа өнгөтэй өөдтэй авч явахын тулд юу мэдэх хэрэгтэйг бидэнд заадаг. Далайчин олон тохиолдолд бидний дагах ёстой үлгэр дууриалыг үзүүлснээр энэ үүргээ биелүүлдэг. Ийм үлгэр дууриалын нэг жишээ нь Патрици Хориучигийн аав Франк юм.

Франк номлогчидтой уулзсаны дараа тэднийг хоолонд тогтмол урьдаг болж, удалгүй хичээл авч эхэлжээ. Гэвч гэрийнхнээс нь өөр хэн ч Сүмийг сонирхсонгүй. “Номлогчид ирэхийг хараад би дүү нарынхаа хамт бүгдээрээ гадагшаа гараад явчихдаг байсан” гэж Патрици хэллээ.

Тэгээд 2007 оны 7-р сард номлолын ерөнхийлөгч Нелсон Блик Франкад баптисм хүртээв. Энэ бол



Зөв шударга эр хүний нөлөө

Лидия Каминага, Хиробо Обекетанг шиг Сүмд төрсөн ч, өсвөр насандаа идэвх султай болсон гэнэ. Гэвч сүмд эргэж ирсэн түүний түүх нэн өвөрмөц юм.

Лидия, түүний нөхөр Каминага Каминага хоёул Сүмд өссөн аж. “Би Сүмийн сургаалуудад хэзээ ч, ямар нэг байдлаар эргэлзэж байгаагүй, тэдгээрт үргэлж итгэдэг байсан” гэж Каминага хэллээ.

Харин Лидиягийн хувьд амьдрал

Зүүн дээд талд: Хиробо Обекетанг (өмнөх хуудсан дээр гэр бүлийнхээ хамт байгаа) зочид буудлын менежерээр ажиллаж байна. Доод талд: 2009 оны зургадугаар сард болсон Маршаллын арлуудын ганц бие залуу насанд хүрэгчдийн анхны чуулганы удирдагч Патрици Хориучи (баруун доод талд).



БҮХ НИЙТЭД ТОХИОЛДДОГ СОРИЛТ БЭРХШЭЭЛҮҮД

Газарзүй, соёл заншил, холын зай нь Маршаллын арлуудын гишүүдийг Хожмын Үеийн бусад Гэгээнтнүүдээс тусгаарлаж болох ч Сүмийн бүх гишүүнд тохиолддог сорилт бэрхшээлүүд тэдэнд мөн тохиолддогийг тэд ярьж байна.

Гадасны ганц бие залуу насанд хүрэгчдийн удирдагч Гари Закиос (баруун талд), “хүмүүс өөр дээр чинь хүрч ирээд, ‘Өнөөдөр бидэнд бошиглогч хэрэггүй. Өөр судар ч бас хэрэггүй’ гэж мэднэ. Зарим гишүүд судруудыг үнэхээр уншдаггүй, ойлгодог ч үгүй, тиймээс хэн нэгэн нь тэдний итгэлийг сулруулах ямар нэг зүйлийг хэлэхэд тэд үнэн гэдгийг нь мэддэг зүйлээсээ ухардаг.”

Гаригийн хувьд шийдэл нь энгийн байжээ: “Мормоны Ном, Сэргээлт, Иосеф Смитийн талаар залбирч тэдгээр нь үнэн үү гэдгийг мэдэх даалгаврыг надад номлогчид өгсөн. Нэг орой би сөхөрч суугаад залбирч, Ариун Сүнсийг мэдэрсэн. Ийм мэдрэмжийг би өмнө нь хэзээ ч мэдэрч байсангүй. Номлогчдын надад заасан зүйлс үнэн гэдгийг би мэднэ. Мормоны Номыг уншсан нь залуу хөрвөгч миний гэрчлэлийг бэхжүүлсэн.” Баптизм хийлгэсэн үеэс өнөөдрийг хүртэл “Мормоны Номыг уншиж, судрууд болон бошиглогчдын үгсийг судалснаар миний гэрчлэл өсч хөгжсөн” гэж Гари ярилаа.

Маршаллын арлуудад Сүмийн орчуулагчаар Гари-тай хамт ажилладаг Эрнест Меа (баруун талд), олон залуус ёс суртахуунгүй байдалд автагдаж байна гэв. Тэрээр үзэл бодол нэгтэй найзуудтайгаа зохистой үйл ажиллагаануудад оролцсоноор нарийн бөгөөд шулуун зам дээр байнга үлдэж чаддаг. “Номлолынхоо өмнө бид ням, даваа гарагаас бусад бүх өдөр сүм дээр сагсан бөмбөг тоглодог байлаа” гэж тэр хэлэв.

Женрок тойргийн Майкл Ион (баруун талд) 2006 онд Сүмд нэгдсэнээрээ цаашид гэртээ амьдрах аргагүй болсон ажээ. Сүмд элссэнийхээ төлөө тэр ийм төлөөс төлсөн юм. Тэгсэн ч тэр итгэл үнэмшлээ харуулж, баптизм хүртжээ.

Яг нэг жилийн дараа тэр Маршаллын арлуудад номлолд дуудагдав. Бүр саяхан Майклын гэрийнхэн Сүмийг сонирхдог болж номлогчидтой хамт сайн мэдээг судлах болжээ.



өөрөөр эргэсэн ажээ. Тэр долдугаар ангид байхдаа, “Би сургуульдаа цорын ганц Мормон байсан болохоор ганцаархнаа шоовдорлогдсон юм шиг санагддаг” гэж ярьдаг байжээ. Найз нарынхаа хийдэг бүхнийг би хийдэг байсан. Миний эрхэмлэдэг юмс буруу байлаа.”

Лидиягийн эцэг эх нь түүнийг АНУ-ын Ютагийн Прово уруу гэр бүлтэйгээ хамт байлгахаар явуулахдаа тэд түүнд сайн мэдээгээр амьдрахад нь сүнслэг нөлөө үзүүлж магадгүй гэж боджээ. Лидия хожим амьдралд нь тусалсан зүйлсийг сурч мэдсэн ч тэр үедээ Сүмийг сонирхдоггүй байв.

Каминага Японд номлолд үйлчлэн эргэж ирээд ганцхан сар болж байхад Лидия 2002 оны 1-р сард Маршаллын арлуудад буцаж ирэв. Үүний дараахан тэр хоёр танилцжээ. Лидия Сүмийн жишгүүдээр амьдардаггүй байсан ч Каминага, Лидиягийн байшинд амьдардаг түүний ач дүү Гари Закиостой уулзахаар ирж байгаа юм шиг дүр үзүүлэн тэнд байнга очдог байлаа.

Сүүлдээ Каминага Лидиятай зохистой, үйл ажиллагаануудад явж, түүнтэй болзох хүсэлтэй байгаа тухайгаа эцэг эхтэй нь ярилцъя гэж шийджээ. Тэд эхлээд үүнийг хэрэггүй гэж түүнд ятгах гэж оролдсон ч, Каминага ‘Энэ нь түүнд өөрчлөгдөх боломж олгоно шүү дээ’ гэж “хэлжээ. Намайг ингэж хэлэхэд

Энэ зураг дээр нөхөр Каминага, охин Веллисатайга байгаа Лидия Каминага, “наманчлалын тухай хүчтэй гэрчлэл надад байдаг” гэв.



өрөөн дэх уур амьсгал бүхэлдээ өөрчлөгдөж билээ. Аав нь уйлж, ‘Би түүнийг Сүмдээ эргэж очоосой гэж өдрийн бодол, шөнийн зүүд болдог хүн.’ Та оролдоод үз’” гэжээ.

Лидия эхлээд Каминагаг нэг их тоосонгүй. Тэр цэвэрхэн хувцасласан нямбай, буцаж ирсэн номлогч байлаа. Харин Лидия идэвхгүй гишүүн байв.

“Гэвч миний хараагүй зүйлийг тэр харсан юм” гэж Лидия тайлбарлав. Лидия өөр хэн нэгэнтэй болздоггүй байсан болохоор түүнтэй хамт гадагшаа явахыг зөвшөөрөв. “Тэр намайг сүмд буцааж авчирсан юм. Түүний найз болсноор би жишгүүдээ сахих хэрэгтэй



болсон. Баптисмаар хийсэн гэрээнүүдийг минь тэр надад сануулав. Судар унших, гэр бүлийн үдэш хийх зэрэг миний орхисон олон зүйлийг тэр надад эргэн сануулсан. Каминага бид хоёр хамтран үйлчлэлийн төслүүдийг хэрэгжүүлдэг байлаа. Бид Мормоны Номыг уншиж, галын дэргэдэх ярилцлагуудад очдог байлаа. Амьдралаа хэрхэн өөрчлөхийг тэр надад харуулсан юм. Сүмд явах нь зөвхөн ариун ёслолд төдийгүй бас Ням гарагийн хичээл, Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаануудад оролцох явдал мөн.”

Тэд цэвэр ариун, сэтгэл санаа өргөсөн үйл ажиллагаануудад хамт цагийг өнгөрүүлэхийн хэрээр Лидиягийн амьдрал өөрчлөгдөж, гэрчлэл нь өсөн хөгжиж байлаа. Гэвч зарим нэг нүглийг шийдвэрлэх хэрэгтэй байлаа.

“Сүмд буцаж ирэх нь амаргүй байсан шүү” гэж тэр хэллээ. “Наманчлал амар байсангүй, гэвч надад наманчлалын хүчирхэг гэрчлэл үнэхээр байсан. Бид хоёрын болзоо олон талаар бие биеэ илүү сайн танин мэдэх, намайг сүмд эргүүлж авчрах болон юмсыг өөрөөр харах боломж олгосон юм.”

“Үүний үр дүнд бид хоёр ойр дотно харилцаатай болсон” гэж Каминага нэмж хэллээ.

Лидия, Каминага хоёр 2002 оны 11-р сарын 28-нд гэрлэжээ. Жилийн дараа тэр хоёр Хавайн Лайе Ариун сүмд гэрлэж, Хавайн Бригам Янгийн Их Сургуульд элсэн оржээ. Одоо тэд Маршаллын арлуудад гурван хүүхэдтэйгээ амьдарч байна. Лидия тойргийнхоо Ням гарагийн хичээлийн залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн багшаар, Каминага Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчөөр тус тус үйлчилж байна.

Бид шаргуу тэвчээр хатуужлыг өөрсдөдөө хөгжүүлж, Их Эзэний адислалуудыг эрэлхийлэх юм бол олон зүйл боломжтой бодогийг Хиробо, Патрици, Лидия нар гэрчилж байна. Аврагчийг дагаж, Ариун Сүнсний өдөөлтүүдийг сонсдог хүмүүс, аялагчдыг гэр уруу нь удирддаг байсан эртний далайчин шиг, өөр хүний амьдралд өөрчлөлт гаргаж чадна. ■

МАРШАЛЛЫН АРЛУУД ДАХЬ АНХНЫ ГАДАС

Маршаллын арлууд дахь Сүмийн гишүүд гадастай болохыг олон жилийн турш мөрөөдсөөр иржээ. 2009 оны 6-р сарын 14-нд тэдний хүсэл биелэгдэв. Тэдний гадсыг зохион байгуулсан Далын Ахлагч Давид С.Вахтер, “Сүүлийн хоёр жилд гишүүнчлэл гайхамшигтайгаар өслөө. Сүмийн хөгжилт зайлшгүй гадас байгуулагдах болгосон юм. Гэхдээ гадас байгуулагдтал урт удаан хугацаа шаардагдсан. Гишүүд олон сорилт бэрхшээлийг даван туулах шаардлагатай байлаа” гэж ярилаа.



Маршаллын арлууд дахь гадасны ерөнхийлөгч Арлингтон Тибон (дээд талд) дүүргийн ерөнхийлөгч байхдаа хэрэв тэд гадастай болохыг хүсч байгаа бол үүний төлөө ажиллах хэрэгтэй гэж гишүүдэд заадаг байжээ. Тэрээр дүүргийн удирдагчдыг Малахи 3, 3 Нифай 24 дэх аравны нэгийг төлснөөс ирдэг адислалуудыг гишүүдэд заа гэж зааварладаг байсан гэнэ. Удирдагчид бас Мормоны Номыг уншихад нь залуучууд, насанд хүрэгчдийг урамшуулан дэмждэг байлаа. Залуучууд 12 цагийн турш тасралтгүйгээр Мормоны Номыг унших үйл ажиллагааг амжилттай зохион байгуулжээ.

Ерөнхийлөгч Тибон “Ариун сүмд лацдан холбуулах нь хэчнээн чухал болохыг” гишүүдэд ойлгуулах зорилгыг тавьснаа “ариун



сүмийн хишгээ хүлээн авах нь олон зүйлийг даван туулж, өөрчлөлт гаргах, амьдралаа шинэчлэхэд тэдэнд тусалдаг” гэж тайлбарлалаа.

Маршаллын арлууд дахь гишүүд Ерөнхийлөгч Тибоны удирдлагаар Тонга болон Хавайн ариун сүмд үлэмж золиослол хийсний үр дүнд оржээ. Ерөнхийлөгч Тибоны гэргий Анжела Тибоны хэлснээр, ариун сүмийн аяллууд “Тэнгэрлэг Эцэг болон Сүмд туштай итгэлтэй байхад нь гишүүдэд агуу нөлөө үзүүлсэн” ажээ

Ерөнхийлөгч Тибон, “Тийм ээ, Махурогийн гишүүдийн амьдралд сүнслэг байдал их өссөн шүү” гэж нэмж хэллээ.

БИ СҮМИЙГ СОНИРХДОГГҮЙ БАЙЛАА

Номлогчдоор хөвгүүдээ заалгавал яасан юм бэ? гэж эхнэрийгээ асуухад би Сүмийг огт сонирхдоггүй байлаа. Гэвч би болохгүй гэж хэлээгүй. Учир нь эхнэр маань аль хэдийн Сүмийн гишүүн болсон байлаа.

Номлогчдыг долоо хоногт хоёр удаа манайд ирэхэд би зэргэлдээ хаалганд байдаг найзынх уруугаа очдог байлаа. Манай найз Христийн өөр сүмийн бат бөх итгэлтэй гишүүн байв. Намайг түүнтэй уулзах болгонд тэр Библийн тухай ярилцахыг хүсдэг байв. Би ийм зүйл сонирхдоггүй гэж түүнд хэлээд шашны талаар мэдэхийг хүсдэггүй байлаа. Гэвч тэр надад итгүүлэхийг үргэлж хичээдэг байсан учир эцэстээ би зөвшөөрөв. Ингээд номлогчид

манай хөвгүүдэд зааж байх үеэр би Библийг найзтайгаа удаан хугацаанд судлав.

Нэг өдөр номлогчдыг манайд ирэхэд, би найзынх уруугаа явсангүй, зэргэлдээ өрөөнд байхаар шийдэв. Номлогчид манай хөвгүүдэд зааж эхлэхэд бүр илүү их сонсмоор санагдлаа. Тэдний зааж байгааг бүр сайн сонсохын тулд хаалганд ойртсоор байв. Номлогчид манай хөвгүүдэд төлөөлөгчид, бошиглогчдын тухай зааж байв.

Хожуухан би бүр илүү ихийг мэдэхийг хүсч байгаагаа мэдэв. Тэгээд номлогчидтой ярилцаж,

ярилцлагыг ганцаараа нууцхан авахаар шийдэв. Ярилцлага дээр манай эхнэр үргэлж байдаг байв, харин өөр хэн ч энэ тухай мэдээгүй.

Номлогчдыг долоо хоногт хоёр удаа манайд ирэхэд би зэргэлдээ хаалганд байдаг найзындаа ордог байлаа.

Иймээс номлогчид манай хөвгүүдэд заахаар долоо хоногт хоёр удаа ирэхэд нь би найзынх уруугаа явдаг байв. Дараа нь тэд өөр өдөр надад заахаар ирнэ.

Нэг өдөр найз маань манай Сүмийн талаар нэг тусгүй зүйл хэлэхэд нь би сүмээ хамгаалав. Маршаллын арлуудын хүмүүсийн адил тэр манай Сүмийн тухай төдийлөн мэдэхгүй бас Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн итгэдэг зарим зүйлийг буруу ойлгосон байлаа. Түүнийг бусад сөрөг зүйлсийн тухай ярихад би Сүмээ дахин хамгааллаа.

Тиймэрхүү байдлаар долоон сар өнгөрөв. Номлогчдын заасан бүхэн үнэн гэдгийг Ариун Сүнс надад баталсныг би нэг өдөр мэдлээ. Би хэдийгээр сайн мэдээний талаар багахан мэдлэгтэй байсан ч баптисм хийлгэх хэрэгтэйгээ ойлголоо.

2007 онд би баптисмынхаа дараа үнэхээр аз жаргалтай болов. Бид Хавайн ариун сүмд явахаар мөнгө цуглуулж эхлэв. Ингээд 2008 оны арванхоёрдугаар сард эхнэр бид хоёр гурван хүүхдийнхээ хамт лацдан холбуулсан.

Сүмийн гишүүн болсон нь миний амьдралд асар их нөлөө үзүүлсэн юм. Шөнө орой болсон хойно гэртээ буцаж ирдэг болон хувцсанд минь тамхины утаа шингэдэг байнаас би зоогийн газарт үйлчлүүлэгчдийг цэнгүүлдэг байсан хоёр дахь ажлаасаа гарахаар шийдэв. Нэмэлт орлогоо алдсан ч Их эзэн бидний төлөө санаа тавьсан юм.

Надад мэдрэгдсэн Сүнсээр болон хүлээн авсан адислалуудынхаа ачаар би Сүм үнэнийг, Иосеф Смит бол Бурханы бошиглогч гэдгийг мэднэ. ■

Танитоа Секстон, Маршаллын арлууд



МИНИЙ УРЛАСАН ОДОЙ МОРЬД

Даавуун дээр утсаар чагт гарган хатгаж, жил орчим урласан алаг одой морьдын надад байдаг. Хатгамал бараг дуусдагийн даваан дээр одой морьдын нэгнийх нь өнгийг гаргахад алдаа гаргаснаа мэдлээ. Утасны өнгө нь адууны зүс ямар байдагтай адил байх ёстой атал одой морины зүс нь даавууны өнгөтэй адилхан болчихсоныг мэдсэнгүй.

Би ёстой л сүйрэх шиг болов. Би чагт гаргаж хатгасан энэ зурганд хамаг цаг заваа зарцуулсан болохоор буруу өнгөөр оёсон бүх оёдлыг ханзална гэдэг хэцүү ажил мэт санагдаж билээ. Нулимс асгаруулан уйлж, оёмол зургаа хогийн сав уруу шидчихэв.

Тэгээд оёдлын хэрэгслээ хадгалдаг ширээнд сууж, одой морьдын гоё хатгамалгүй болсондоо гашуудаж, өөр юм хийхээр шийдэв. Гэвч өөр юм хийе гэтэл чадсангүй. Учир нь маш шаргуу ажилласан нөгөөх хатгамалаа хаяад өөрийг эхэлж чадсангүй. Хогийн саваа онгойлгож, даавуун зургаа гаргаж ирлээ. Зурагны ар дээрх буруу өнгөөр хатгасан утасны зангилааг олж, болгоомжтойгоор хайчилж, хайчилсан утсыг сугалж эхэллээ.

Заримдаа утас хурдан сугарна. Заримдаа утсыг сугалж авах нь амаргүй байв. Хатгаж оёсон зургаа хэрхэн буцааж задлахыг сайн мэдэхгүй байлаа. Зарим үед нэг оёдлыг нэг удаа хайчлах хэрэгтэй байлаа. Буруу хийсэн зүйлээ залруулахын тулд би бүх ажлаа дахин хийх хэрэгтэй болсныг хүү минь харчихжээ. Эцсийн эцэст энэ чинь даавуун чагт гаргаж оёсон нэг зураг л шүү дээ.

Оёдлыг задалж, утсыг сугалж байхдаа би наманчлалын тухай бас гаргасан зарим алдаагаа

залруулах нь хэчнээн хэцүү болохыг бодлоо. Жинхэнэ наманчлал нь чин хүсэл, хөдөлмөр, сэтгэлийн зовлон шаарддаг ч, үр дүн нь үнэ цэнэтэй юм.

Би одой морьдыг дахин хатгаж байхдаа наманчлал нь миний амьдралаас нүглийн толбыг зайлуулж, амьдралаа шинээр эхлэх боломжийг Есүсийн Цагаатгал хэрхэн олгодгийг саналаа. Зөв зүйлийг хийх тухай чимээгүйхэн атлаа амьд сануулагч болсон миний “наманчлалын одой морьд” гэрт өлгөөтэй байдаг. Алдаа дутагдал гаргасан үедээ би хэзээ ч бууж өгдөггүй харин наманчлалаар дамжуулан Цагаатгал өөрчлөлт гаргах болно гэдгийг санадаг билээ. ■

Сандра Женнингс, Нью Мексик, АНУ

Б*и чагт гаргаж хатгасан энэ зурганд хамаг цаг заваа зарцуулсан болохоор буруу өнгөөр оёсон бүх оёдлыг ханзална гэдэг хэцүү ажил мэт санагдаж билээ.*



СҮМ ТЭНД БАЙСАНГҮЙ

Би Газрын Дундад Тэнгисийн бүст аялж явахдаа чадах л хэрээрээ Сүмийн цуглаануудад хичээнгүйлэн оролцож байлаа. Испанийн Севиллд би зочид буудлын хүлээн авагч, орон нутгийн утасны лавлахын тусламжтайгаар хотын газрын зураг ашиглан ХҮГ-ийн цуглааны байр хаана байдгийг олж, хаягийг нь тэмдэглэж, Сүмийн нэрийг испаниар бичиж авав. Бямба гарагийн орой цуглаан хэдэн цагт эхэлдгийг мэдэх гэж залбиртал өглөөний 10:00 гэхэд тэнд очсон байх хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж төрөв.

Ням гарагийн өглөө 9:30-д сүм уруу явахынхаа өмнөхөн цуглааны байрыг олохын төлөө дахин залбирав. Тэгээд газрын зургаа барьж, тахиралдсан нарийхан гудамжуудыг сүлжин явлаа. Тэр өглөө их сайхан байлаа. Олон кафе, шувууд жиргэн шулганаалдсан шувууны захын дэргэдүүр өнгөрөв.

Тэмдэглэж авсан хаягаар хүрч иртэл тэнд сүмтэй төстэй юу ч байсангүй. Гудамжийг өгсөн уруудан алхаж, сүмийг хайгаад олсонгүй. Би будилж төөрчээ, гэтэл бараг 10:00 цаг болж байв.

Тэгээд би Тэнгэр дэх Эцэгтээ хандан: “Та надад сүмд очихыг зарлиг болгосон, би энд ирээд байна, гэвч энд сүм байхгүй байна” гэж залбирлаа.

Тэгтэл сайхан хувцасласан нэг хүн булан тойрон гарч ирэв. Тэр хүн Сүмийн гишүүн юм шиг харагдсан учир түүнийг зогсоож асуумаар санагдлаа. Би сүм эрж яваагаа түүнд ойлгоход хэцүү байдлаар тайлбарлав. Түүнийг нэг юм хэлэхэд би ойлгосонгүй, тэгээд



Сайхан хувцасласан, костюмтай хүн булан тойрон гарч ирэв. Тэр хүн Сүмийн гишүүн шиг харагдсан болохоор би түүнийг зогсоож асууя гэж бодов.

ях ч учраа олсонгүй. Тэгтэл нөгөө хүн цүнхээ онгойлгоход савхин хавтастай хоёр ном гаргаж ирсэн нь судрууд бололтой харагдав. Би түүнд “La Iglesia de Jesucristo” (Есүс Христийн Сүм) гэж бичсэн зурвас цаасаа өглөө. Тэр инээмсэглэн миний хүрч ирсэн замаар буцаж бид хоёр сүм уруу алхав. Сүмийн барилгын хаяг өөр байсан бөгөөд хэдхэн минут явах газар байжээ. Гэвч байгаа газрыг нь яг мэдэхгүй бол төөрөхөд амархан ажээ. Сүм замаас нэлээд зайдуу, жижигхэн талбайд, том хаалгануудын ард байлаа.

Цуглааны байранд ирээд надад тусалсан мөнөөх хүн тойргийн бишоп бөгөөд цуглаан нь 10:30-аас эхэлдэг болохыг мэдэв. Би цагаасаа өмнө ирсэн байлаа.

Мацаг барилт болон гэрчлэлийн цуглаанд би гэрчлэлээ хуваалцмаар санагдлаа. Сүмийг олж ирэх замыг Их Эзэн хэрхэн хангаж өгсөн тухай намайг гэрчлэлээ хэлэхэд нэг номлогч миний үгийг англиас испани

хэлэнд орчуулж өглөө. Дараа нь бишоп гэрчлэлээ хуваалцахдаа тэр өглөө машинаа хол тавьсан болохоор ердийнхөөсөө арай хожигдож ирснээ тайлбарлав. Бишоп намайг хараад Сүмийн гишүүн байх гэж бодсон учир надад туслахаар зогссон аж. Тэгээд тэр сүнслэг байдлын хувьд алдагдсан гишүүдийн тухай яриад, Сүмдээ эргэж ирэхэд нь бид тэдэнд туслах ёстой гэв.

Он жилүүд өнгөрөх тусам Севиллын тухай миний дурсамж бүдгэрсэн ч сүмийг хэрхэн олсон нь санаанаас гардаггүй юм. Тэрхүү дурсамж бол биднийг хайрладаг Тэнгэр дэх Эцэгийн агуу хайрыг хийгээд хэрэв бүх юмс “[миний] сайны төлөө хамтдаа ажиллахыг” (Ром 8:28) би эрэлхийлэх юм бол Түүний мутар миний амьдралд харагдах болно гэдгийг надад гэрчилсэн юм. ■

Жюли Измайл, Баруун Австрали, Австрали

ТҮҮНИЙ ЗОВЛОН БИДНИЙ ЗОВЛОНГ ХӨНГӨВЧИЛСӨН ЮМ

Би нярай хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн сувилалгч учир заримдаа дөнгөж саяхан төрсөн өвчтэй хүүхдүүдийг асарч сувилдаг. Нэг орой төрөх хугацаанаасаа 17 долоо хоногийн өмнө төрсөн, ердөө 500-хан грамм жинтэй нэг бяцхан хүүг надад хариуцуулж өглөө. Гар нь өөдсийн чинээхэн, хөл нь миний хурууны дайтай, тавхай нь миний эрхий хуруунаас томгүй, амьсгалын замын ноцтой хүндрэлтэй хүүг эмч нар тэр шөнийг давахгүй байх гэж байсан юм.

Хуруун чинээ бяцхан хүү амьтэмцэж байсан тэр үед нярайн тасаг тэр чигээрээ амьсгаа даран намгүм болов. Хүн бүр, ялангуяа тэр шөнө бяцхан нялх хүүгийн сувилалгч байсан би сэтгэлийн хямралд автагдав. Аав, ээж хоёр нь түүнтэй хамт өдрийн ихэнхэд байсан болохоор туйлдталаа ядарсан байлаа. Ээж нь жаахан амрахаар өрөөндөө эргэж ирэв. Амрах нь түүнд маш чухал байлаа.

Хүүгийн өрөө түүнийг амьд байлгахад шаардлагатай торниулагч (инкубатор), хяналтын аппаратууд, агааржуулагч, амьсгалын аппаратаар өвч тоноглогдсон байлаа. Тэр хүү хүнд өвчтэй болохоор эрчимт эмчилгээ шаардлагатай байв. Тиймээс тэр шөнө надад өөр ажил хариуцуулж өгөөгүй юм. Би шөнөжингөө түүний дэргэд байж, эм өгөн, нүд цавчилгүй хяналт тавьж, асарч сувилан, шинжилгээ авч завгүй байлаа.

Шөнө орой болох тусам, хэрэв би түүний ээж байсан бол надад ямар байх байсан бол гэдгийг төсөөлөн бодохыг хичээлээ. Зүрх шимшрэн өвдөх нь тэсэхийн аргагүй байх байсан болов уу.

Би нүүрийг нь зөөлхөн угааж, өөдсийн чинээхэн гар, хөлийг нь

барьж үзэн, зөөлхөн шинэ хөнжил сольж өгөн, ихэд болгоомжтойгоор өлгийднө. Хөөрхий, алгын чинээхэн энэ өвчтөндөө би өөр юу хийж чадах билээ гэж бодлоо. Ээж нь байсан бол юу хийх бол? Тэнгэрлэг Эцэг надаар юу хийлгэхийг хүсэх бол?

Энэхүү хонгорхон, гэм зэмгүй бяцхан хүүхэд Тэнгэр дэх Эцэгтээ удахгүй эргэж очих ч юм бил үү. Тэр айж байгаа болов уу гэж бодсоноо би өөрийнхөө хүүхдүүдийг бодлоо. Хүүхдүүд ээ бага байхад мөн тайван биш байгаа үед нь би тэдэнд дуу дуулж өгдөг байж билээ. “Би Бурханы хүүхэд” дуу тэдний дуртай дуу байлаа. Би уйлахгүй байхыг хичээн, тэр жаахан хүүхдэд “Би Бурханы хүүхэд” дууг дуулж өгөв.

Би сувилалгчийн хувьд бяцхан хүүгийн цусны эргэлтийг тоолон, гуурсуудыг харж, зүрхнийх нь цохилтыг чагнан, хяналтын аппарат дээр тоонуудыг харж байсан бол Хожмын Үеийн Гэгээнтний хувьд селестиел сүнсийг харж, авралын төлөвлөгөөг гайхан биширч байлаа.

Би уйлахгүй байхыг хичээн, тэр жаахан хүүхдэд “Би Бурханы хүүхэд” дууг дуулж өгөв.

Шөнө орой болох тусам хүүгийн бие улам муудав. Эцэстээ уушгинаас нь цус алдаж байдал бүр дордов.

Маргааш өглөө нь бяцхан өвчтөн маань чимээгүйхэн нөгөө ертөнцөд одлоо. Тэр бяцхан хүү ээжийнхээ өврийг орхиж, “[түүнд] амьдралыг өгсөн Бурханд, гэртээ аваачигдав” (Алма 40:11).

Тэр шөнө би Аврагч, Тэнгэрлэг Эцэг хоёрт улам ойртсон билээ. Хүн төрөлхтнийг болон намайг хайрладаг Их Эзэний хайрыг би бүр илүү сайн ойлголоо. Их Эзэнийг хайрладаг миний хайр тийм гүн гүнзгий юм байна гэдгийг мэдэрч, бүр гайхаж билээ. Тэгээд би улам эелдэг уриалгахан, илүү уучламтгай, улам өрөвч зөөлөн сэтгэлтэй болж нэгэн өдөр, нэгэн сэтгэл догдлом үед Түүнтэй илүү адилхан болсон байхыг хүсэх хүслээ мэдрэв. ■

Барбара Винтер, Аризона, АНУ



ҮҮРДИЙН ГЭРЭЭ

*Хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэгтэйгээ байгуулсан
гэрээнийхээ хэсэг болгож шийдвэр гаргах болсон үед
дэлхий юу гэж хэлэх нь надад хамаагүй юм.*

Марта Валенсия Васквиез

Намайг арваад настай охин байхад манай Залуу Эмэгтэчүүдийн ерөнхийлөгч залуу эмэгтэй бүрд нэг бэлэг: ариун сүмийн зураг өгч билээ. Тэр бидэнд гэрээнүүдийн тухай, цэвэр ариун амьдрах тухай яриу. Тэгээд тэр биднийг нэгэн өдөр ариун сүмд явах зорилго тавиарай гэж уриалав.

Би тэр эгчийн зөвлөгөөг зүрх сэтгэлдээ нандигнан хүлээн авч, ариун сүмд явах бэлтгэлийг эн тэргүүнд тавихаар шийдэж билээ. Тэр

үед Коста Рикад ариун сүм байсангүй. Гэвч гэрээ гэж юу болохыг би саяхан болсон баптисмаасаа мэдсэн болохоор Их Эзэнтэй бусад гэрээнүүд хийх боломжтой болохыг тэсч ядан хүлээдэг боллоо.

Тэр үед манай гэрт надаас өөр Сүмийн гишүүн байсангүй. Тиймээс сайн мэдээ манай гэрт заагддаггүй байлаа. Гэсэн ч би сайн мэдээний жишгүүдийг өөрөө мэдэж авч, тэдгээрийг дагахаар шийдэв. Семинарт явах нь миний бэлтгэлд орсон юм.

Хэдийгээр семинар өглөө маш эрт хичээллэдэг байсан ч тэр шүү дээ. 16 нас хүртлээ болзоонд явахгүй байхыг бас бэлтгэлдээ оруулсан. Энэ нь миний үе тэнгийнхний дунд мэдээжийн хэрэг нийтээр дагаж мөрддөггүй байсан ариун явдлын хуулиар амьдарна гэсэн хэрэг байлаа. Энэ бол Их Эзэнтэй гэрээ байгуулсан учраас миний хийх ёстой зүйл гэдгийг би мэдэж байлаа.

Семинараар болон өөрөө бие дааж судруудыг судалсан нь цэвэр ариун амьдралаар амьдрах миний шийдвэр төгс байдлыг бэхжүүлсэн юм. Хиламаны 2000 залуу дайчин надад онцгой сүнслэг нөлөө үзүүлснийг би санадаг. Алма 53:20–21-д эдгээр залуу эрчүүд “зориг, мөн түүнчлэн хүч чадал хийгээд эрч

ЗАЛУУ НАСАНД ХҮРЭГЧДИЙН БАТ БӨХ БАЙДЛЫН ТӨЛӨӨ



“Би ердөө ганцхан асуулт асууя: Та үнэн бөгөөд амьд бошиглогчдыг дагах уу эсвэл үгүй юү? Энэ бол үнэхээр энгийн

зүйл. Ёс суртахууны талаар Сүмд баримталдаг жишгийг ‘Залуучуудын бат бөх байдлын төлөө’ товхимолд тодорхой томъёолсон байгаа. Та нараас олон нь цаашид насанд хүрээд Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн байгууллагад харьяалагдахаа больсон ч энэ

товхимол та нарт хамаагүй болно гэж байхгүй. Хэрэв та Сүмийн ёс суртахууны жишгүүдэд үл нийцэх материал агуулсан ямар нэг зүйлийг уншихаар сонговол өөрийгөө болон өөрийн мэргэн ухааныг Бурханы бошиглогчдын зөвлөгөөнөөс дээгүүрт тавьж байгаа хэрэг бөгөөд энэ нь чухамдаа ухаалаг бус үйлдэл юм. Хэрэв хүмүүс өөрсдийгөө Бурхан болон Түүний өмнөөс яригчдаас илүү сайн мэддэг гэж эсвэл өгч байгаа зөвлөгөө нь тэдэнд хүртээлгүй гэж боддог бол тэд ийм бодлынхоо улмаас хохирогч болсон

үй олон хүний адилаар аюултай байдалд хальтиран орж байгаа нь тэр. Бошиглогчдын зөвлөгөөг бүрэн ойлгохгүй ч түүнийг хоёргүй сэтгэлээр хүлээн авч, түүгээр амьдрахыг хичээн чармайх нь танаас итгэл, үнэнхүү итгэлийг шаарддаг. Ийм энгийн итгэл нь амьдралд тохиолдох аливаа сорилт бэрхшээлийн дундуур таныг аюулгүйгээр удирдан хөтлөх хүчтэй байдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Расселл Баллард, “When Shall These Things Be?” *Brigham Young University 1995–1996 Speeches* (1996), 189.



хүчээрээ үлэмж баатарлаг байв; гэвч болгоогтун, энэ нь бүгд бус— тэд итгэж даалгасан ямар ч зүйлд цаг ямагт үнэнч эрс байлаа. . . . Тэд үнэн мөн чанд байдлын эрс байв. Учир нь тэд Бурханы зарлигуудыг дагахыг мөн түүний өмнө зөв шударгаар алхахыг заалгасан байв.” Би ч гэсэн надад итгэж даалгасан зүйлүүдэд, түүний дотор баптисмын гэрээнүүдэд үнэнч итгэлтэй байхыг хүсдэг байсан.

Би Эл-Сальвадорын Сан Сальвадор Зүүн Номлолд үйлчлэхээр дуудагдсан үедээ гэрээнүүдийн талаар дэлгэрэнгүй ойлголттой болсон билээ. Намайг ариун сүмд хувийн хишгээ хүлээн авсан үеэр Сургаал ба Гэрээ 82:10-ын: “Миний хэлснийг та нар хийхэд Их Эзэн бибээр үүрэг хүлээдэг; гэвч миний хэлснийг та нар үл хийхэд та нарт амлаат байх нь үгүй” гэсэн үгс санаанд минь орж ирж билээ. Хэрэв бид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлбэл Их Эзэн хүлээсэн үүргээ биелүүлэх болно гэсэн гэрээний үзэл санаа миний номлолын бүх

Баптисмын үед байгуулсан гэрээ болон ариун сүмд хийсэн гэрээнүүд өнөөдөр ч анх хийсэн өдрийнх шигээ хүчин төгөлдөр хэвээр байна.

үеийн турш чадах бүхнээ хамгийн сайнаар хийхэд надад урам хайрласан билээ. Намайг ийнхүү үүргээ биелүүлснээр хамтрагч бид хоёр адислагдсан юм.

Миний номлол олон жилийн тэртээ өнгөрсөн ч би гэрээнүүдээсээ хүч чадлыг олсон хэвээр байгаа. Тэр цагаас хойш би Коста Рикагийн Сан Хосе Ариун сүмд долоон жил үйлчлэхээр адислагдсан. Ариун сүмийн ажилтнаар үйлчилсэн нь хийсэн гэрээнүүдэд байнга санах боломжийг надад олгосон юм. Залуу Эмэгтэйчүүдийн байгууллагад үйлчилсэн нь надад мөн дээрхтэй

адил сануулагч болсон юм. Тэнд удирдагчид маань надад заадаг байсан шиг гэрээнүүдийн ач холбогдлыг тийм байдлаар заахыг би хичээдэг байлаа.

Гэрээнүүдээ сахих нь үргэлж амар хялбар байдаггүй. Жишээ нь, олон хүн ариун явдлын хууль (эсвэл зарим тохиолдолд ерөнхийдөө шүтлэг бишрэлийн асуудал байхаа больсон гэдэг утгаар) хуучирсан гэж үздэг. Аз болоход миний итгэл бишрэлийг хуваалцадаггүй эсвэл ариун явдлын хууль хуучирсан гэж үздэг хүмүүсийн зүгээс надад аливаа дарамт шахалт үзүүлдэггүй. Манай удирдагч биднийг ариун сүмийн гэрээнүүд хийхэд бэлтгэж, эдгээр гэрээнүүдээр амьдрахыг урамшуулан дэмжсэн тэр үед залуу эмэгтэй байхад минь төрсөн мэдрэмжийг би эргэн санадаг. Тэр үед гаргасан шийдвэрээ би өнөөдрийг хүртэл дагаж ирсэн.

Тэр шийдвэрүүдийг би зөвхөн өөрөө, зөвхөн өөрийнхөө төлөө гаргаагүй учраас би тэдгээр шийдвэрээ чанд сахиж чаддаг. Харин би тэдгээр шийдвэрийг хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэгтэй байгуулсан гэрээнийхээ хэсэг болгон хийсэн билээ. Дэлхий юу гэж хэлэх надад хамаагүй. Би Түүний зарлигуудыг сахих болно гэж Их Эзэнд амласан билээ. Энэ бол нэр төрийн хэрэг. Баптисмын үед байгуулсан гэрээ болон ариун сүмд хийсэн гэрээнүүд өнөөдөр ч анх хийсэн өдрийнх шигээ хүчин төгөлдөр хэвээр байна. Бурхантай байгуулсан гэрээ үүрдийнх юм.

Бид Бурханы хүсэн хүлээдэг арга замаар амьдрах нь амар хялбар байдаггүй ч, энэ нь боломжтой гэдгийг би гэрчилж байна. Бид гэрээнүүдээ сахиж амьдарснаар өөртөө итгэх итгэл, хүч чадлыг олж чадна. Мөн Тэнгэрлэг Эцэг хэзээ ч биднийг ганцааранг нь орхихгүй гэдэгт бат итгэлтэй байж болно. Бид Түүний тусламж дэмжлэгтэйгээр бүхнийг хийж чадна (Моронай 7:33-ыг үз). ■

ЭЦЭСТ НЬ СОНССОН НЬ

Нэрийг нууцлав

Би коллежид сурч байхдаа гэрээсээ хол нэгэн хотод яггүй хэцүү дадлага хийхээр адислагдсан юм. Миний багын найз холгүй амьдардаг байлаа. Бид хоёр адил шүтлэг бишрэлгүй ч энэ ялгаа жирийн найз нөхөд байхад саад болдоггүй байлаа.

Би Маделинтай (нэрийг өөрчлөв) анх танилцахдаа Хожмын Үеийн Гэгээнтний агуу үлгэр жишээ болсон өөр нэг эмэгтэйтэй хамт ажилладаг байлаа. Хоёр залуу эмэгтэйн тодорхой ялгааг Сүнс надад мэдүүлж, өчүүхэн жижиг сонголтууд ч гэсэн хожим нь амьдралд зам зааж болдгийг анхааруулсныг би санаж байна. Сүнсний энэхүү өдөөлтийг би олон жилийн турш санаж явна.

Эдүгээ хэдэн жилийн дараа Маделин бид хоёр уулзаж, нэг удаа цагийг хамт өнгөрүүлэхээр тохирлоо. Орой болоход яагаад ч юм бүү мэд миний дотор цухалдаж эхлэв. Би түүний хот уруу явдаг галт тэргэнд суугаад хотод ойртох тусам “Чи зөвхөн өндөр жишигтэй хүмүүстэй болзох хэрэгтэй” хэмээн нэгэн дуу хоолой миний оюун ухаан, зүрх сэтгэлд шивнэх нь тэр.

“Энэ чинь болзоо биш.” “Би зүгээр л хуучин найзтайгаа уулзах гэж яваа шүү дээ” гэж бодлоо. Сүнс сэрэмжлүүлгээ давтсаар.

Тэгээд би энэ нь үнэхээр болзоо байсныг ухаарч найзынхаа одоогийн жишгүүд болон амьдралын хэв маягийн талаар эргэцүүлэн бодож үзлээ. “Намайг Хожмын Үеийн Гэгээнтэн гэдгийг тэр мэднэ шүү дээ” гэж өөрийгөө зөвтгөв. Тэр миний жишгүүдийг мэднэ, тэгэхээр ямар ч асуудал алга.”

Гэвч өмнө нь ажиглагдсан “тодорхой ялгаа” бид хоёрын замыг миний бодож байгаагаас бүр холдуулсан юм биш байгаа гэж би бодлоо. Тэгээд би Сүнсний өдөөлтийг дагаж, уулзалтаа цуцалья гэж найздаа утасдав. Түүнийг гомдоохоос би тун их айсан шүү. Ариун Сүнсний үүрэг зорилгыг үнэлдэггүй найздаа сүнсний өдөөлтийг би хэрхэн тайлбарлаж чадсан гээч?

Бидний төлөвлөсөн үйл ажиллагаануудын нэгнийх нь хувьд би сэтгэл хангалуун биш байна гэдгээ мөн энэ нь тэр оройн уулзалтаас татгалзах үндэслэлтэй шалтгаан болсныг тайлбарлав. Түүний урам хугарч бидний төлөвлөгөөг өөрчлөх санал тавилаа. “Тэр үйл ажиллагаанаас болж Сүнс намайг сэрэмжлүүлсэн байх” гэж бодсон учраас миний дотор онгойж, төлөвлөгөөг өөрчлөхийг зөвшөөрөв. Гэвч нөгөөх санаа зоволт алга болсонгүй.

Бид хоёр тэр орой цагийг хөгжилтэй өнгөрөөсөн ч Сүнс өмнө нь надад өгсөн сэрэмжлүүлгээ чухал шүү гэдгийг үе үе сануулсаар байлаа. Эхний үед энэ нь санаа төдийлөн зовоогоогүй ч, үдэш орой болох тусам бид хоёр ердийн танилаасаа огт өөр чиглэл уруу явж байгаа нь тодорхой болов. Бидний жишгүүд бүр өчүүхэн жижиг зүйлс





**ЗАМААСАА
ХАЗАЙДАГ УУ?**

“Сэтгэл догдлом аялал хэмээн бидний найдсан тэр зүйл ганц хоёрхон

алдаанаас болоод биднийг сүнслэг байдлын хувьд сүйрэлд хүргэдгийг хожимдсон хойноо мэдэх нь бидэнд . . . олон удаа тохиолддог.”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, “A Matter of a Few Degrees,” *Лиакхона*, 2008 оны 5-р сар, 58–59.

“Энэ эмэгтэй миний багын найз бөгөөд энэ бол болзоо биш шүү дээ” гэж би өөртөө хэллээ. Гэтэл Сүнс яагаад намайг тийшээ очих ёсгүй гэж сэ­рэмжлүүлсэн юм бол?

дээр ч урьдынх шигээ биш байлаа. Түүнийг дарс захиалахад би согтууруулах ундаанд мөнгө төлмөөргүй байна гэдгээ хэллээ. Тэр миний хүсэлтийг хүндэтгэж дарсны үнийг өөрөө төлөв.

Миний сүнсний санаа зоволт орой болох тусам өссөөр байлаа. Зоог дуусахад би гарахад дөхөж явлаа. Учир нь оройн сүүлчийн галт тэрэг удахгүй хөдлөх байв. Түүнээс гадна би таксигаар явахад хэтэрхий хол амьдардаг байлаа. Санаа зовж байгааг найз минь мэдээд байрандаа хонож болно шүү гэв. Харин Сүнс намайг ганцааранг нь орхисонгүй: Энд ирж болохгүй гэж батлан хэлснийг би аль хэдийнээ мэдэж байлаа.

Би тэднийд орсон хойноо тайван байгаа юм шиг харагдах гэж ихэд хичээв. “Чи энд хономооргүй байна уу?” гэж тэр асуулаа.

Тийм ээ, хономооргүй байлаа. Тэр намайг шахаж шалсангүй, уурлаж бухимдсангүй. Харин Сүнс

надад аянгийн дуунаас илүү тодоор чимээгүйхэн шивнэсэн юм. Би галт тэрэгнээс хоцорч болохгүй байлаа!

Би түүнийг дотогшоо ормогц галт тэрэгний буудал уруу хоцрохгүйн тулд харайлгав. Иосеф Египетэд уруу таталтаас хэрхэн мултарсан тухай би бодохгүй байж чадсангүй (Эхлэл 39:7–12-ыг үз).

Тэр орой болсон явдлыг эргээд бодоход би айдас, талархал хоёрыг хоёуланг нь мэдэрдэг. Болж мэдэх байсан уруу таталтаас айсан бол Ариун Сүнс надтай хамт байсны төлөө талархсан юм. Би Ариун Сүнсийг шивнэнгүүт сонсох ёстой байсан ч, эцэст нь сонссондоо баяртай байдаг.

Тэр орой болсон явдлын талаарх миний бодол Их Эзэнийх шиг тийм тодорхой байгаагүй нь мэдээж юм.

“Учир нь миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” гэж Эзэн айлдаж байна.

“Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ.” (Исаиа 55:8–9).

Амьдралд бид зарим сонголтыг түргэн хийгээд, дараа нь мартдаг. Бидний хийсэн зарим сонголтын сургамжийг хэзээ ч мартаж аргагүй байдаг. Бид Ариун Сүнсний өдөөлтүүдийг анхааралтай сонсож, тэр даруй дагасан үед Есүс Христ бидэнд зориулан бэлтгэсэн замаар илүү амархан замнаж чадна гэдгийг мэдсэндээ би баяртай байдаг. ■

“Бид сүмд явдаг, гэр бүлийн үдэш хийдэг, сайн мэдээгээр амьдрахыг хичээдэг ч, манай гэр бүлд яагаад олон асуудал байдаг юм бол? Бид өөр юу хийж болох вэ?”

Сайн мэдээгээр амьдрах нь адислалуудыг авчирдаг. Гэвч энэ нь танд сорилт бэрхшээл тохиолдохгүй гэсэн үг биш юм. Хүнд сорилт бэрхшээлүүд Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг эрэлхийлэхэд таныг өдөөдөг учир итгэлийг тань бэхжүүлнэ. Асуудлыг Түүний тусламжтайгаар шийдэх нь хэрхэн зөв шийдвэр гаргахыг танд заадаг.

Энэ тухай та гэрийнхэнтэйгээ зөвлөж ярилцсан уу? Хамтран зөвлөлдсөнөөр та ашиг тустай санаануудыг олох болно. Шийдлийг олохын төлөө та нар гэр бүлээрээ мацаг барьж, залбирсан уу? Судрууд болон ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг судалсан уу? Гэр бүл тань нөхцөл байдлыг сайжруулах зарим өөрчлөлт хийх шаардлагатай байж болно эсвэл уг хүнд сорилтын үед Их Эзэн өөрийг чинь хүчирхэгжүүлэхийг тэвчээртэйгээр хүлээх хэрэгтэй байж мэднэ (Мозая 24:15-ыг үз).

Хэрэв бусад хүн гэр бүлд тань асуудал бэрхшээл учруулсан бол тэднийг буруутгалгүйгээр уучлахыг хичээ. Уучлах нь асуудлыг тэр даруй шийдэхгүй ч зүрх сэтгэлд чинь амар амгаланг авчирч, асуудлын шийдлийг хөнгөвчилж өгнө.

Гэр бүлүүд бат бөх байх нь Сүмд болон нийгэмд туйлын чухал учраас Сатан гэр бүлүүдийг дайран давшилж байна. Тийм учраас үргэлж тэвчээртэй бай. Сүмд үргэлж яв, гэр бүлийн үдэш хийж, сайн мэдээгээр байнга амьдар. Дуулгавартай байдал нь Ариун Сүнснийг мэдрэх боломжийг танд олгодог. Түүний удирдамж өөрийн чинь эрж хайж байгаа асуултуудын хариуг олоход амин чухал юм. Бүр асуудлуудыг даван туулах шаардлагатай байгаа ч бат бөх гэр бүлд амьдрах нь чиний хувьд өмнөө тавьбал зохих хамгийн чухал зорилгуудын нэг юм.

Бидэнд өгсөн удирдамжийг ашигла



Аль нэг гэр бүл соригдох хүртлээ хүчирхэгжихгүй байж мэднэ. Аз болоход бид асуудлуудаа шийвэрлэхэд ганцаараа биш Тэнгэрлэг Эцэг хувь хүн болон гэр бүлүүдийг аз жаргалтай, амжилт бүтээлтэй, сайн сайхан яваасай гэж хүсдэг. Тэрээр бидэнд туслахын тулд судрууд, амьд бошиглогч болон Сүмийн бусад удирдагчид, Ариун Сүнс зэрэг чухал хөтчүүдийг өгсөн юм. Эдгээр нь бидэнд болон манай гэр бүлүүдэд баяр баяслыг авчирдаг сайн мэдээний зарчмуудыг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэхэд тусалж

чадна. Түүнээс гадна эцэг эхээ дээдлэн хүндэлж, хайрладгаа хэлэхээ хэзээ ч бүү март. Эв нэгдэлтэй, хүчтэй, санаа сэтгэл өөдрөг байх замаар Их Эзэн гэр бүлийг тань хангах болно гэдгийг би мэднэ. Гэр бүл Бурханаас томилогддогийг би мэднэ. *Жаред А., нас 18, Минданао, Филиппин*

Сорилтуудаасаа суралц



Хэчнээн ч хичээж чармайлаа гэсэн сорилт бэрхшээл заавал байх болно. Сорилт бэрхшээлүүд бидэнд өсч хөгжихөд тусалдаг. Өсөлт хөгжилт нь сорилт бэрхшээлүүдэд хэрхэн хариулснаас чинь хамааралтай байна. Хамгийн чухал нь сорилт бэрхшээлүүдээс суралцах явдал мөн. Эргэн тойрондоо болж байгаа үйл явдлуудыг анхааралтай ажиглаж, үнэлэлт дүгнэлт өгч бай. Тохиолдсон сорилт бэрхшээлүүдийн талаар залбирч, тэдгэрийг даван туулахад Их Эзэн өөрт чинь тусална гэсэн итгэлтэй бай. Тэгвэл сорилт бэрхшээл чинь хүч чадал болж хувиран, чи бусдад хүчтэй болоход нь тусалж чадна. *Макензи К., нас 18, Чихуахуа, Мексик*

Гэр бүлийн Тунхгийг унш

Бид залбирал хэлсэн ч хэлээгүй ч асуудал бэрхшээл тохиолдох болно. Сорилт бэрхшээл биднийг шийтгэдэг биш харин хүчирхэгжүүлдэг юм. Амьдралд бидэнд тулгардаг асуудлууд гэр бүлүүдийг хамтран ажиллах боломжоор хангадаг. Манай гэр бүл бухимдал, мөнгөний асуудлыг даван туулахдаа бүгдээрээ хамт байж, бие биедээ болон Тэнгэрлэг Эцэгтээ улам ойр дотно байхыг хичээдэг. Цаг үе хүнд хэцүү байгаа үед бидний хийх нэг зүйл бол “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх Тунхаг” ийг унших явдал мөн. Энэ тунхаг бидний хоорондох ариун хэлхээ

болон гэрээнүүдээ сахих нь хэчнээн чухал болохыг бидэнд сануулдаг.

Анна Ж., нас 15, Жоржиа, АНУ

Тэнгэрлэг Эцэгийн хүслийг хүлээн ав

Тэнгэрлэг Эцэг асуудлуудаар дамжуулан биднийг сорьдог гэж би боддог. Тэр бол бидний Эцэг бөгөөд биднийг маш их хайрладаг учраас бидэнд хамгийн сайн сайхныг хүсдэг гэдгийг мартаж болохгүй. Асуудлуудыг даван туулж чадах бидний цорын ганц зам бол тэвчээр хагуужил болон Эцэгийн хүслийг хүлээн авч биелүүлэх явдал мөн гэдгийг би мэднэ.

Хосе К., нас 18, Анкаш, Перу

Их Эзэнд итгэлтэй бай



Манай гэр бүлд, тэр бүү хэл биднийг чадах бүхнээ хийсээр байтал яагаад асуудлууд тулгардаг юм бол гэсэн асуулт гарч

ирсэн үед надад тусалдаг зүйл бол Иовын тухай түүх, түүний туулсан олон зовлон зүдгүүр юм. Иов 19:25–26-д: “Миний Гэтэлгэгч амьд гэдгийг болон эцсийн өдрүүдэд Тэрээр дэлхий дээр байр сууриа эзэлнэ гэдгийг би мэднэ. Арьс минь устгагдсан хойно ч, би махан биеэрээ Бурханыг харах болой” гэсэн байдаг. Иовд хамгийн хүнд сорилтууд тулгарсан ч Гэтэлгэгч амьд гэдгийг мэдэж байсан шүү дээ! Бид Иовын адил бодож, амьдарвал, асуудлуудаа түргэн олж харан, эдгээр сорилт бэрхшээлүүдээр дамжуулан туслах Гэтэлгэгч бидэнд байгааг мэднэ.

Меган Б., нас 17, Юта, АНУ

Асуудлыг итгэл найдвараар угт

Асуудалд зөв хандвал энэ нь биднийг улам хүчирхэгжүүлдэг. Чи

асуудлыг итгэл найдвар, зоригоор угтах хэрэгтэй. Сүмд явж, сайн мэдээгээр амьдрахын төлөө чадах бүхнээ хийх хэрэгтэй. Ингэвэл асуудлууд өөрийг чинь хатуужуулж, эцэстээ илүү сайн хүн болгодгийг ч мэдэх болно. Мөн хийдэг ямар нэг зүйл чинь зөв үү гэдгийг тогтоож, хэрэв буруу байвал залруулахыг хичээ. Бусдад туслахыг байнга хичээ, тэгвэл асуудлууд чинь хөнгөн юм шиг санагдах болно. Юуны түрүүнд Их Эзэнтэй үргэлж зөвлөж бай. Асуудлынхаа талаар залбирч, өөрийгөө удирдахыг Тэнгэрлэг Эцэгээс гуй.

Раймонд А., нас 18, Ганын Акфра

Эцсийг хүртэл тэвч

Бүтээгчийн төлөвлөгөөнд гэр бүл гол байрыг эзэлдэг учраас сайн мэдсэн дээр төвлөрсөн гэр бүл болох бидний аз жаргалтай амьдралыг бусниулах гэж Сатан чадах бүхнээ хийх болно. Амьдрал бэрхшээл зовлонгүй амар хялбар байна гэх юм уу эсвэл нэг удаа сүмд очиж, гэр бүлийн үдшээ нэг удаа хийснээр амьдрал уруу таталтаас чөлөөтэй болчих юм шиг бодож болохгүйг

бид мэднэ. Байдал төвөгтэй байгаа үед судруудаа унш, залбир, асуудлыг гэр бүлээрээ ярилц.

Ахлагч Дадли, нас 21, Индонезийн Жакартын Номлол



БОШИГЛОГЧДЫН ЗӨВЛӨГӨӨГ ДАГА

“Их Эзэн болон Түүний сургаалын тусламжтайгаар гэр бүл нь сорилт

бэрхшээлээс үүдэлтэй бүхий л хор уршигтай үр дагавруудыг ойлгож, даван туулж чадна. Гэр бүлийн гишүүдийн хэрэгцээ ямар ч байсан бид бошиглогчдын зөвлөгөөг дагавал гэр бүлээ бэхжүүлж чадна.

“Манай гэр бүлүүдийг бэхжүүлэх түлхүүр нь Их Эзэний Сүнсийг гэр орондоо байлгах явдал мөн.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс, “Strengthening Families: Our Sacred Duty,” Ensign, 1999 оны 5-р сар, 32.

ДАРААГИЙН АСУУЛТ

“Үнэхээр уур чинь хүрсэн үед чи уураа хэрхэн хянадаг вэ?”

Хариултаа 2011 оны 5-р сарын 15-ны дотор дараах хаягаар ирүүлнэ үү:

Liahona, Questions & Answers 5/11
50 E. North Temple St., Rm. 2420
Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар шуудангаар явуулж болно.
Эсвэл и-мэйл: liahona@ldschurch.org

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

И-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (и-мэйл байж болно).

ТҮҮНИЙГ ҮРГЭЛЖ САНА



БИД БҮГД АМЛАСАН.
(ЛУК 22:19–20; С БА Г 20:77, 79-ИЙГ ҮЗ.)


Сургаал ба Гэрээ 76:22-24

Доорх шүлгүүд Есүс Христийн тухай орчин үеийн гэрчлэлийг тунхаглаж байна: Тэр амьд!

Гэрчлэлүүд

Энэ илчлэлтээс өмнө амилсан Христийн тухай олон гэрчлэл өгөгджээ. Зарим жишээг дор өгөв:

- Магдалын Мариа (Иохан 20:11–18-ыг үз)
- Есүсийн үеийн Төлөөлөгчид (Матай 28:9–20; Марк 16:14–20; Лук 24:36–53; Иохан 20:19–29; 21-ийг үз)
- Хоёр дагалдагч нь Еммаугийн зам дээр (Лук 24:13–35-ыг үз)
- Стефен (Үйлс 7:55–56-г үз)
- Паул (Үйлс 9:1–6-г үз)
- Нифайчууд (3 Нифай 11–28-ыг үз)
- Моронай (Ифер 12:39-ийг үз)
- Иосеф Смит (Иосеф Смит — Түүх 1:16–20-ийг үз)



22 Мөн эдүгээ, түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх, хамгийн сүүлчийн “гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө!

23 Учир нь бид түүнийг бүр “Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн “Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ —

24 Ийнхүү “түүгээр, мөн түүнээр дамжин, мөн түүнээс, дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн “хөвгүүд хийгээд охид нь бөлгөө.



Тэр амьд!

“Христийн Цовдлолын уй гашуу болон Түүний Амилалтын баяр хөөрийг биеэр үзсэн хүмүүсийн гэрчлэлийг би уншсан

бөгөөд тэдгээрт итгэдэг. Амилсан Их Эзэн тэдэн дээр айлчлан очсон Шинэ Нутагт амьдарч байсан хүмүүсийн гэрчлэлийг би уншсан, тэдгээрт би итгэдэг.

“Энэ эрин үед Эцэг, Хүү хоёртой эдүгээ ариун хэмээн нэрлэгддэг ойн цоорхойд ярилцсан тэр хүний гэрчлэлд би итгэдэг. Тэр хүн энэхүү гэрчлэлээ цусаараа лацдан амиа өгсөн юм.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Тэр амилсан!” *Лиакхона* 2010 оны 5-р сар, 89.



Бурханы төрсөн хөвгүүд, охид

Дэлхий даяарх миний хайрт залуу найз нараа

“Та нар жирийн нэг хүмүүс биш шүү.” Та нар бол

мөнхөд орших, алдар суут хүмүүс. . .

“Та нар өөрсдийгөө хараад төгс биш байдал болон эргэлзээгээ орхиж, өөрсдийгөө үнэхээр Бүхнийг Чадагч Бурханы алдар суут хөвгүүд, охид гэдгээ харах чадвартай байхын төлөө би залбирч, та нарыг адисалж байна.”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, “The Reflection in the Water” (Залуу насанд хүрэгчдэд зориулсан Сүмийн Боловсролын Системийн гарын дэргэдэх ярилцлага, 2009 оны 11-р сарын 1)-ыг CESfiresides.lds.org-аас үзэж болно.



Олон дэлхий бүтээгдсэн бөгөөд одоо ч бүтээгдсээр байна

“Христ Эцэгийн удирдлагаар өөрийн бүтээсэн тоо томшгүй олон ертөнцийн Их Эзэн бөгөөд манай дэлхий бол тэдгээрийн зөвхөн ганцхан нь юм (Ефес 3:9; Еврей 1:2-ыг үз).

“Ертөнцөд хүн амьдардаг хэчнээн гараг байдаг вэ? Бид мэдэхгүй, гэвч бид ертөнцөд ганцаархнаа биш билээ! Бурхан бол зөвхөн ганц гарагийн Бурхан биш!”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл, “Special Witnesses of Christ,” *Лиакхона*, 2001 оны 4-р сар, 5.

Редакторын тэмдэглэл: Энэ хуудас бол сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш, зөвхөн өөрийн тань судалгааны эхлэх цэг юм.

Сэргээн босгоход оролцсоны БАЯР

*Газар хөдлөлтөөс үлдсэн балгасуудыг хараад миний сэтгэл өвдлөө.
Гэвч Бурхан эндсэн хүмүүсийг ч эсэн мэнд үлдэгсдийг ч адилхан
хайрладгийг би ойлгосон.*

Ашли Дайер

Би Хятадын Шанхайд амьдардаг учраас хэдэн жилийн өмнө Хятадын баруун өмнөд хэсэгт оршдог Сычуан мужид болсон газар хөдлөлтийн золиос болсон хүмүүст орон гэрээ барихад нь туслах сургуулийн бүлэгтэй хамт явах боломж надад олдсон юм. Бид тоосго өрж, шавар зууран, тоосго зөөдөг тэрэг түрэн, “цуваа болон” зогссон хүмүүст тоосго дамжуулан шаргуу ажилладаг байлаа. Хоёр дахь өдөр нь миний нуруу өвдөж, бээлий цоорчихлоо. Гэсэн ч, туслахаар тэнд очсон нь миний хувьд мартагдашгүй туршлага болж, миний гэрчлэлийг болон Залуу Эмэгтэйчүүдийн эрхэмлэх зүйлсийн нэг-хувь хүний үнэ цэнийг бэхжүүлсэн юм.

Би өдөр бүр шаргуу ажилласнаар өөрийнхөө үнэ цэнэд итгэх итгэл өсөн нэмэгдэж байгааг ажиглав. Хувь заяа нь минийхээс доогуур байгаа хүмүүсийн амьдралын нөхцөлийг сайжруулахаар ажиллаж байсан учраас би өөрийнхөө талаар сэтгэл өөдрөг байлаа.

Бас тэндхийн нэг сургууль дээр очих боломж олдсон юм. Биднийг очиход олон хөөрхөн бяцхан хүүхэд бидний өөдөөс тосон гүйж ирлээ. Би тэдгээр хөөрхөн хүүхдүүдийг хараад тэд ч бас үнэ цэнэтэй хувь хүмүүс болохыг ухаарч билээ. Тэд бол бүгдээрээ Бурханы сайхан хүүхдүүд. Тэр тэднийг бүгдийг нь нэг бүрчлэн таньдаг бас бүгдэд нь хайртай гэсэн бодол намайг эзэмдэв.

Аяллын төгсгөлд бид нэг амралтын газарт үдийн хоол идэхээр очлоо. Гэвч биднийг тэнд очиход тэр амралтын газар газар хөдлөлтөөр нурж, балгас болсон байв. Ингэтлээ сүйрсэн барилгыг би өмнө нь огт хараагүй. Бүр уймаар санагдсан гээд бодлоо. Барилгын хана,

таазанд том том цоорхой гарч, ойролцоох модод булга татагдаж унаснаас гадна газар сайгүй нэл нуранги болжээ. Уулнаас өнхөрч ирсэн том үхэр чулуу барилгын хажуу талыг цөм цохиж, тааз, ханыг нураажээ. Довжоон дээр нь өрөөсөн гутал байж байх юм.

Би энэ тухай бас байгалийн гамшгаар хүмүүс эрсдэснийг бодоод ийм гамшиг болохыг Тэнгэрлэг Эцэг хэрхэн зөвшөөрдгийг ойлгох гэж толгойгоо гашилгав. Тэр эдгээр хүмүүст хайргүй байсан юм гэж үү? Тэгээд би Залуу Эмэгтэйчүүдийн хичээл дээр ярилцсан зүйлээ эргэн санаад, тийм ээ, Тэр тэдэнд хайртай байсан шүү дээ хэмээн бодлоо. Тэнгэрлэг Эцэг тэднийг нэг бүрчлэн таньдаг бас хайрладаг байсан. Гамшиг болдог өдөр эрсэдсэн хүмүүс бүгдээрээ Бурханы хүүхдүүд шүү дээ. Эхлээд энэ тухай бодоход надад гуниг төрлөө. Гэвч дараа нь, амь эрсэдсэн хүмүүс одоо сүнсний дэлхийд байгаа, тэд Тэнгэрлэг Эцэгтээ дахин эргэн очих болно гэдгийг санаж билээ. Энэ бодол намайг тайтгаруулж, амар амгалангийн мэдрэмж төрлөө.

Би Бурханы агуу үнэ цэнэтэй хүүхэд гэдгээ мэднэ. Бид бүгдээрээ Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд. Тэр биднийг нэг бүрчлэн таньдаг. Бидний хэн нь ч төсөөлж чадахааргүй тийм агуу, гүнзгий хайраар Тэр биднийг хайрладаг билээ. Сычуан дахь газар хөдлөлтөд ийнхүү аймшигтайгаар нэрвэгдсэн хүмүүстэй хамт ажиллаж, тэдэнд үйлчилж байх үед ийм бодол зүрх сэтгэлд минь гүнзгий шингэсэн юм. ■

Ашли Дайер (баруун талд) Хятадын Сычуанд 2008 онд болсон газар хөдлөлтийн дараа орон нутгийн иргэдэд гэр орноо сэргээн барихад тусалжээ.



СУДРЫН ХҮЧ



TE
BUKA
A
MOROMONA

hi Faahou Ite
Mesia

*Тахитийн идэр насны
хоёр залуу нэг үйл явдлыг
тохиолдуулан судруудыг
судалснаар амьдрал нь
өөрчлөгджээ.*

Адам К.Өүлсон
Сүмийн сэтгүүлүүд

Рума судар судлахыг хүсдэггүй, Вей-тиаре семинарт явахыг хүсдэггүй байж. Судар судлах хэрэг ч тэдэнд байсангүй гэнэ. Гэвч тэд судар судлахаар сонгосон үед амьдрал нь өөрчлөгджээ.

Яагаад үгүй гэж?

Яагаад идэр насны залуу дөрөв дэх өдрийн орой бүр ээжтэйгээ судар судлахад хоёр цаг зориулж болохгүй гэж? Жилийн өмнө Тахитийн Рума Тероатеа ийм зүйл хийх хэрэгтэй гэвэл гайхах байсан биз.

Харин одоо бол идэр насны хөвгүүн яагаад үүнийг *сонгохгүй* байх билээ хэмээн асууж мэднэ.

Семинарын гурван жилд Рума багш нар нь дараагийн хичээлд бэлтгэж судрууд

унших даалгавар өгөхөд огт анхаардаггүй байсан гэнэ. “Би судар уншихыг хүсдэггүй байсан” гэж тэр хэллээ. “Судрууд үнэхээр миний сонирхлыг татдаггүй байсан.”

Гэтэл тойрог, гадасных нь удирдагчид хэлэх үг, хичээлүүддээ яагаад судруудыг үргэлж хэрэглэдэг юм бол гэж тэр гайхдаг байлаа. Гадасны ерөнхийлөгч нь судруудаас маш амархан эш татаж байгааг ажиглажээ.

Тэгээд семинарынх нь сүүлчийн жилийн турш Тахитийн Фаа гадас семинарын суралцагчдыг төгс эзэмших судрын тэмцээнд оролцох баг болгон хуваахад Рума энэ далимаар судруудыг судлаад үзэхээр шийдсэн гэнэ.

Иймд тэр долоо хоног бүр ээжтэйгээ судар судалж эхэлсэн аж. Тэд пүрэв гарагийн орой бүр маргааш нь болох ангийн тэмцээнд бэлтгэн хамт судар судалж, чухал шүлгүүд хаана байгааг мэдэж, тэдгээрээс олныг нь цээжилдэг байлаа.

Үүний улмаас Румад өөрчлөлтүүд гарч эхэлсэн гэнэ. Судар судалсан нь ээжтэйгээ харилцах харилцааг нь бэхжүүлжээ. Тэрээр судруудын заадаг зүйлс, дэлхийд өнөө үед болж байгаа үйл явдлуудтай давхцаж байгааг олж харжээ. Уншиж байгаа зүйлийнхээ талаар залбирахад тэр нь Бурханаас ирдгийг мэдсэн гэнэ.

Рума Тераотеа (доод талд) түүний семинарын ангийнхан зэргэлдээх Мурea (зүүн талд) уруу судрын мэдлэгээ сорихоор явахад үр дүн ямар байсан нь хамаагүй харин Рума ялагч болжээ.



ХИЧЭЭН-ГҮЙЛЭН СУДАЛ

Судруудыг хааяа нэг алдаг оног унших нь өдөр

бүр уншиж, амьдралдаа хэрэгжүүлэхээс хамаагүй бага үр нөлөөтэй байдаг. Судруудын заадаг хичээлүүдийг сайн үз. . . . Тэдгээр хичээлүүдийг өөртөө хандан ярьж байгаа юм шигээр судал. Учир нь тэдгээр нь үнэн юм” гэжээ. . . .

“ . . . Хэрэв та судруудыг анхааралтай хичээнгүй судалбал, хийдэг юм бүхэндээ уруу таталтаас зайлсхийж, Ариун Сүнсний удирдамж хүлээж авах чинь нэмэгдэх болно.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Be Your Best Self,” *Лиакхона*, 2009 оны 5-р сар, 68.

Энэ нь гадасны төгс эзэмших судрын аварга шалгаруулах тэмцээнд тэргүүлэгч байж багаа ялахад тусалжээ.

Рума судар судалснаас хүлээж авсан адислалууд дотор өөрийнх нь сурч мэдсэн хичээл байгааг мэдэжээ. “Бид Их Эзэний хүссэн зүйлийг хийхээр сонгосон үед тэр даруй адислагддаг” гэж Мозая 2:24-т Бенжамин хаан сургасан байдаг” гэж Рума ярилаа. Түүний хүлээн авсан агуу адислалуудын нэг нь “энэ жил судрууд судалсны дараа Мормоны Ном үнэнийг мэдсэн явдал мөн.”

Юу хийхийг надад бүү хэл

Хичээлийн жилийн эхэнд Вейтиаре Пито бүр Сүмийн гишүүн ч болоогүй байжээ. Өмнө нь семинарт огт явж үзээгүй шинэ гишүүн Фаа гадасны төгс эзэмших судрын аварга шалгаруулах тэмцээнд багтаа хэрхэн тусалж чадсан юм бол?





Тахитийн Вейтиаре Пито судруудыг судлахаар шийдсэнээр адислалуудыг нь таньж мэддэг болжээ.

“Би туршлагагүйдээ санаа зовоогүй шүү” гэж тэр хэлэв. “Би тэдгээр судрын шүлгүүдээс олныг нь номлогчийн хичээлүүдийн үеэр сурсан юм.”

Вейтиарегийн гэр бүлийн ихэнх гишүүд аав нь зуурдаар нас барсны дараа тойргийн номлолын удирдагч тэдний гэрт номлогчдыг дагуулан ирэхэд Сүмд нэгдсэн гэнэ. Номлогчид гэр бүлийн эв нэгдлийн тухай гэр бүл үүрд хамт байх боломжтой тухай ярьжээ. “Энэ нь манай гэр бүлд үнэхээр өөрчлөлт авчирсан шүү” гэж тэр ярилаа.

Гэвч 17 настай биеэ даасан

түүнийг тийм ч өөрчлөөгүй аж. “Баптисм хүртсэний дараа хүн болгон л намайг семинарт яв гэдэг байлаа, би хийх ёстой юмаа хүнээр хэлүүлэх дургүй. Иймээс семинарт явахаас хэсэг хугацаанд зайлсхийсэн.”

Эцэстээ тэр семинарт явахаар өөрөө шийдэж, энэ нь түүнд таалагдсан байна. Түүнийг Румагийн адилаар төгс эзэмших судрын багийн гишүүн болгосон аж.

Эхлээд тэр даалгаварт өгсөн судруудыг унших гэж чармайдаггүй байв. Гэвч судруудыг судлах хэрэгтэй гэж шийдсэнээр үүнээс олон адислал ирдгийг мэджээ.

“Судрууд бол агуу ашиг тустай зүйл” гэж тэр хэллээ. “Би судруудаас олон зүйл, түүний дотор залбирлын ач холбогдол болон Тэнгэрлэг Эцэг залбиралд минь хариулах болно гэдгийг сурсан.”

Тэр ямар нэг юм хийхээр, тухайлбал семинарт явахаар эсвэл судар уншихаар шийдсэн л бол, үүнийг хийх ёстой учраас эсвэл “хийх ёстой юм байх” гэж бодохын оронд ямагт тууштай байхыг сурсан гэнэ.

Одоо хичээлийн жил дуусч байна. Вейтиаре семинарт явахаар, судруудыг судлахаар сонгосондоо баяртай байна: “Судруудыг уншсанаар бид адислагддагийг би мэднэ.” ■

Миний адислалын ХӨТӨЧ

Скотт Талбот

Би Техасын Хьюстоны Өмнөд Номлолд үйлчилсэн испани хэлээр ярьдаг ахлагч. Нэг өдөр хамтрагч бид хоёр заах хүн олохоор хаалга тогшин явж байлаа. Бид хоёр элэгдсэн модон довжоондоо том нүхтэй нэг байшинд ирлээ.

Хижээл насны нэг эмэгтэй хаалга онгойлгож биднийг орохыг урив. Тэр эмэгтэй биднийг ямар улс болохыг, юу хийдгийг мэддэг байсан гэж би бодохгүй байна, харин тэр бидэнд нэн эелдэг уриалгахан байлаа. Бид түүнд эхний хичээлээ зааж эхлэхэд юм бүхэн тун аятайхан байх шиг санагдав. Удалгүй Иосеф Смит болон Анхны Үзэгдлийн тухай миний заах ээлж болов. Эмэгтэйн царайны төрхөнд эргэлзэх нь улам ихсэж байгааг би харлаа. Тэр эмэгтэй өөрт нь миний тайлбарлахыг хичээж байсан зүйлийг огт сонирхохгүй байгаа нь илт байв.

Заасан зүйлийнхээ талаар мөн үүнээс хэдий хэрийг нь ойлгосныг нь мэдэх гэж хэдэн асуулт асуусны дараа тэр эмэгтэй Анхны Үзэгдлийн үзэл санааг ойлгоогүйг мэдээд миний урам хугарлаа. Тэр өдөр урт байсныг яана. Номлогчийн ганц хүсдэггүй зүйл бол өөрийн үнэн гэж мэддэг, хүмүүсийг мэдээсэй хэмээн чин сэтгэлээсээ хүсдэг тэрхүү зүйлийг нь хэн нэгэн нь хүлээж авч ойлгохгүй байх явдал юм.

Хэсэгхэн зуур миний сэтгэл хөдлөл уцаар болж хувирмаар байсныг мэдэрсэн үед миний патриархын адислалаас нэг хэсэг санаанд орж ирлээ. Энэ бол миний ирээдүйн гэр бүлийн тухай хэсэг бөгөөд сайн мэдээний үзэл санааг ирээдүйн хүүхдүүдээ заахыг зөвлөсөн байлаа. Тэр хэсэг миний санаанд орж ирэх үед даруухан энэ эмэгтэйд бага насны хүүхдэд зааж байгаа юм

шиг заа гэж Сүнс надад хэлснийг би мэдэрч билээ.

Би түүнд бүр энгийнээр хайраар дүүрэн арга барилаар зааж эхэллээ.

ҮЙЛЧЛЭЛД БЭЛТГЭ

Залуу эрэгтэйчүүд ээ, та нарыг номлолд үйлчлэхээр бэлтгээсэй хэмээн би зөвлөж байна. Их Эзэнийг төлөөлж чадахуйцаар өөрсдийгөө цэвэр ариун, зохистой байлга. Эрүүл мэнд болон хүч чадалдаа анхаарлаа хандуул. Судруудыг судал. Семинар, институтийн анги байдаг бол түүнд хамрагд. *"Миний сайн мэдээг номло"* номлогчийн гарын авлагыг сайн уншиж, судал.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, "As We Meet Together Again," *Лиакона, 2010 оны 11-р сар, 6*

Миний өөрийн хүүхдүүд зочны өрөөнд миний өөдөөс хараад сууж байна, тэдний эцэг миний бие Бошиглогч Иосеф Смитийн тухай тэдэнд зааж байна гэж би төсөөлөн бодлоо. Эмэгтэйн нүүрний төрх гэнэт өөрчлөгдөхийг харахад гайхалтай байв. Удалгүй хөмсгөө өргөж, нүд нь гэрэлтэж эхлэв. Эргэлзсэн байдал нь сонирхол, бишрэлээр солигдов. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Иосеф Смит дээр хүрч ирсэн тухай түүхийг ярьтал нүд нь нулимсаар дүүрч, хацрыг нь даган урслаа. Ариун Сүнс өрөөг дүүргэж, миний урам хугаралт агуу баяр баясал болж хувирав.

Би энэ явдлыг хэзээ ч мартахгүй. Би хэзээ нэгэн цагт эдгээр зарчмуудыг хүүхдүүддээ заахыг мөн үүнээс ирэх агуу баяр баясыг ч бас тэсэн ядан хүлээж байна. ■





Ерөнхийлөгч
Бойд К.Пакер

Арванхоёр
төлөөлөгчийн чуулгын
ерөнхийлөгч



ЕСҮС ХРИСТ ЗУУЧ

Би та нарт нэгэн сургаалт зүйрлэл ярьж өгье. Ямар нэгэн зүйлийг маш ихээр хүссэн нэгэн эр байжээ. Энэ нь түүний амьдралын хамгийн чухал зүйл мэт санагдаж байв. Хүслээ биелүүлэхийн тулд тэр асар их өрөнд оржээ.

Тийм их өр тавьж болохгүйг мөн мөнгө зээлдүүлэгчийн тухай түүнд сэрэмжлүүлсээр байжээ. Гэвч хүссэн зүйлээ тэр даруй олж авах нь хамгаас чухал юм шиг түүнд санагдсан аж. Өрийг дараа нь төлж болно гэж тэр найдаж байв.

Тэр дараа нь яаж ийгээд төлөх болно гэсэн гэрээнд гарын үсгээ зурлаа. Үүний талаар төдийлөн санаа зовсонгүй. Хэзээ нэгэн цагт гэдэг нь түүнд нэлээд урт хугацаа юм шиг санагдаж байлаа. Хүссэн юмаа олж авлаа. Энэ нь л түүнд чухал юм шиг санагдаж байв.

Зээлдүүлэгч нь түүний санаанд үргэлж байсаар. Тиймээс тэр бага сага төлбөр хааяа хийхдээ өрөө буцааж төлөх өдөр [зээлсэн бүх мөнгөө эргүүлж төлөх өдөр] яагаад ч юм үнэхээр ирэхгүй ч юм шиг санагдах болов.

Шударга ёс уу, нигүүлсэл үү?

Гэвч мэдээж хэрэг үргэлж ийм байдагчлан гэрээгээ зохих ёсоор тооцох тэр өдөр ирлээ. Өр бүрэн төлөгдөөгүй байв. Зээлдүүлэгч нь хүрч ирээд өрөө бүрэн төлөхийг шаардав.

Зөвхөн тэгэхэд л зээлдүүлэгч нь түүний эзэмшиж байсан бүхнийг авах төдийгүй түүнийг шоронд хорих хүчтэй байсныг ойлгов.

“Надад төлөх ямар ч боломж алга, би танд төлж чадахгүй нь” хэмээн тэр буруугаа хүлээв.

Тэгэхэд зээлдүүлэгч түүнд “бид гэрээний дагуу чиний эзэмшил эд хөрөнгийг авч, чи шоронд явах болно. Чи ингэхийг зөвшөөрсөн шүү дээ. Энэ бол чиний сонголт байсан. Чи гэрээнд гарын үсгээ зурсан. Одоо хуулиа мөрдөх ёстой” гэв.

“Та хугацааг сунгах юм уу эсвэл өрийг минь өршөөж болох уу?” гэж өрөнд унасан хүн гуйв. ‘Намайг шоронд оруулахгүй өөр ямар нэгэн арга замыг бодооч. Мэдээж та нигүүсэлд итгэдэг биз дээ? Та нигүүлсэнгүй хандахгүй гэж үү?’

Зээлдүүлэгч түүнд “Нигүүлсэл үргэлж ганц талтай байдаг. Энэ нь зөвхөн танд л үйлчлэх болно. Хэрэв би чамд нигүүлслийг үзүүлбэл, чи өрөө төлөхгүй үлдэнэ гэсэн үг. Шударга ёс. Үүнийг л би шаардаж байна. Та шударга ёсонд итгэдэг үү?”

“Би гэрээнд гарын үсэг зурах үедээ шударга ёсонд итгэж байсан” хэмээн өртэй хүн хэлэв. “Тэр үед шударга ёс миний талд байсан ба энэ нь намайг хамгаалах болно гэж би бодсон. Тэр үед надад нигүүлсэл хэрэггүй байсан. Надад нигүүлсэл хэрэггүй болно гэж ч би бодсонгүй.”

“Шударга ёс чамаас гэрээнийхээ дагуу

*Тэнгэрлэг
Эцэгтэйгээ
хамт амьд-
рахаар эргэж
очихын тулд
бид өөрсдөө
төлж чадах-
гүй төлөө-
сийг бидний
Зууч, Есүс
Христ төл-
сөн юм.*

Энэ сэдвийн талаар илүү ихийг мэдэхийн тулд Алма 42, шударга ёс, нигүүлсэл болон Цагаатгалын тухай бошиглогч Алмагийн тайлбарыг унш.



Бидний өрийг өөр дээрээ авч төлөх хүсэлтэй хэн нэгэн байхгүй бол мөнхийн хуулиар нигүүлслийг хангаж чадахгүй.

төлбөрөө төлөх эсвэл шийтгэлийнхээ төлөө зовохыг шаардаж байна гэж зээлдүүлэгч хариулав. Энэ бол хууль. Та үүнийг зөвшөөрсөн болохоор ийм л байх ёстой. Нигүүлсэл шударга ёсыг дээрэмдэж чадахгүй.”

“Тэдгээр нь: Нэг нь шударга ёсоор хэмжиж, нөгөө нь нигүүлслийг гуйдаг. Нэг нь нөгөөгийнхөө юмаар хүүдэгнэдэг ёс хаана ч байхгүй.

“Хэрэв та өрийг уучлахгүй бол нигүүлсэл гэж үгүй болно” хэмээн өрөнд унасан хүн аргадангүй гуйв.

“Хэрэв би таны өрийг уучилбал шударга ёс гэж үгүй болно” гэж зээлдүүлэгч хариулав.

“Хоёр хууль хоёул нэг зэрэг биелэгдэж чадахгүй нь харагдаж байна. Энэ хоёр хууль мөнхөд хоорондоо зөрчилддөг. Шударга ёс, нигүүлсэл хоёул нэгэн зэрэг үйлчилдэг арга зам байхгүй гэж үү?

Тийм зам бий! Шударга ёсны хууль бүрэн хэрэгжиж *чадах* мөн нигүүлсэл бүрэн өгөгдөж *чадах* зам бий. Гэвч үүнд өөр хэн нэгний оролцоо шаардлагатай. Иймээс энэ нь энд өгүүлж байгаа хэрэг явдалд тохиолдсон юм.

Түүний зууч

Өрөнд унасан хүнд нэг найз байжээ. Тэр туслахаар ирэв. Өрөнд унасан хүнийг тэр сайн таньдаг байв. Түүнийг өөрийгөө ийм гарцаагүй мухардалтанд оруулж байдаг тэнэг юм даа гэж тэр бодсон гэнэ. Тэгсэн ч тэр түүнд хайртай учраас туслахыг хүсчээ. Тэр найз нь тэдний хооронд зогсож, зээлдүүлэгч өөд эгцлэн хараад: “Өртэй хүн өмч хөрөнгөтэйгөө үлдэж, шоронд орохгүйн тулд та түүнийг гэрээний үүргээс нь чөлөөлбөл би өрийг нь төлье” гэж саналаа хэлжээ.

Зээлдүүлэгчийг энэ талаар бодож байтал, зууч мөн нэмж, “Та шударга ёсыг шаардсан. Тэр танд өрөө төлж чадахгүй болсон. Харин би өрийг нь төлье. Ингэвэл шударга ёсны шаардлага хангагдаж, өрөө төлөхийг та түүнээс дахин шаардахгүй болно. Өрөө төлөхийг дахин шаардах нь шударга бус хэрэг болно” гэв.

Тэгээд зээлдүүлэгч зөвшөөрөв.

“Зууч өрөнд унасан хүн уруу хараад Хэрэв би чиний өрийг төлөх юм бол чи намайг зээлдүүлэгчээ хэмээн хүлээн зөвшөөрөх үү?

“Тэгэлгүй яахав’ хэмээн өрөнд унасан хүн дуу алдав. Та намайг шоронд орохоос аварч, нигүүлсийг үзүүлээч.”

Тэгээд өглөгийн эзэн “чи надад өрийг төлөх болно, би нөхцөлийг нь тогтоож өгнө. Энэ нь амар хялбар биш л дээ, гэхдээ боломжтой юм. Би замыг нь бэлдэх болно. Чи шоронд явахгүй.”

Ингээд өр зээл бүрэн төлөгдөв. Зээлдэгчид төлбөрийг бүрэн төлжээ. Гэрээ зөрчигдсөнгүй. Өрөнд унасан хүнд бас нигүүлслийг үзүүлсэн юм. Хоёр хуулийг хоёуланг нь биелүүлэв. Зуучлагч байсан учраас шударга ёсны шаардлага болон нигүүлсэл аль аль нь бүрэн хэрэгжсэн юм.

Бидний Зууч

Бид бүгд сүнсэлэг байдлын хувьд өр зээлтэй байдаг. Нэг л өдөр данс хаагдаж, өр зээлээ төлөхийг шаардах болно. Одоо бид үүнийг хайхрахгүй байж болох ч, цаг нь ирэхэд барьцаат төлбөр нэхэгдэж, туслах хэн нэгнийг, хэнийг ч хамаагүй царайчлан хайх болно.

Иймээс бидний өрийг өөр дээрээ авч төлөх хүсэлтэй, хэн нэгэн байхгүй бол мөнхийн хуулиар нигүүлслийг хангаж чадахгүй.

Хэрэв зуучлагч олдохгүй бол, хэрэв бидэнд анд найз байхгүй бол, шударга ёсны шаардлага яах ч аргагүй бидэн дээр буух болно. Өчүүхэн ч байна уу, ноцтой ч байна уу ялгаагүй гэм нүгэл бүрийн төлөөс биднээс бүрмөсөн авагдах болно.

Харин үнэн алдар суут үнэн нь ийм Зууч байдгийг тунхагладаг. “Учир нь ганц Бурхан байна. Мөн Бурхан ба хүмүүсийн хооронд ганц зууч байна. Тэр нь хүн болох Христ Есүс билээ” (1 Тимот 2:5). Түүгээр дамжин шударга ёсны мөнхийн хуулийг зөрчихгүйгээр бидний хүн нэг бүрд нигүүлсэл бүрэн хангагдаж чадна.

Нигүүлслийг үзүүлэх нь аяндаа хэрэгждэггүй. Нигүүлсэл нь Түүнтэй хийсэн гэрээгээр дамжин хэрэгждэг. Энэ нь Түүний тогтоосон нөхцөл, Түүний өгөөмөр сэтгэлийн нөхцөлүүдээр хэрэгжих болно. Туйлын чухал энэхүү нөхцөлд нүглийн уучлалын төлөө усанд умбуулах баптисм ордог.

Бүх хүн төрөлхтөн шударга ёсны хуулиар хамгаалагдаж болно. Мөн бидний хүн нэг бүрд нигүүлслийн гэтэлгэгч болон эдгээгч адислал шууд өгөгдөж болно. ■

“The Mediator,” өгүүлээс Ensign, 1977 оны 5-р сар, 54–56.

Нияагийн сонголт

Марсел Ниюнжи

Бодит түүхээс сэдэвлэв.

Авга эгч нь түүнийг гэрээс дуудахад Нияа үүдэн дээрээ тоглож байв. “Нияа, хүнсний дэлгүүр уруу яваад оройн хоолонд хэрэглэх хэдэн лууван аваад ирэхгүй юү? гэж авга эгч нь хүсчээ.

“За!” гэж Нияа баяртай хариулав. Тэр дэлгүүр уруу явах дуртай бас авга эгчдээ туслах дуртай аж.

Нияа авга эгчийнхээ өгсөн мөнгийг аваад ойролцоох дэлгүүр уруу гудамж уруудан алхлаа.

“Би лууван авъя” гэж Нияа дэлгүүрийн эзэнд хэллээ.

Дэлгүүрийн эзэн лууванг

Нияагийн торонд хийж өгөөд үнэ нь хэд болохыг түүнд хэлжээ. Нияа мөнгөө түүнд өгөв.

“Хариултаа аваарай” гэж дэлгүүрийн эзэн хэлээд түүнд мөнгө өглөө.

Нияа түүнд талархал илэрхийлээд гэр өөдөө явлаа. Тэр явж байхдаа дэлгүүрийн эзний өгсөн мөнгийг харав. “Тэр надад илүү мөнгө өгсөн байна шүү дээ” гэж Нияа бодлоо. “Одоо би энэ мөнгийг өөрөө авч болно шүү дээ!”

Гэвч Нияа зогслоо. “Хэрэв би энэ мөнгийг авбал Тэнгэрлэг Эцэг баярлахгүй шүү дээ” гэж бодлоо. “Би үг хэлээрээ ч үйлдлээрээ ч



“**Б**и Тэнгэрлэг Эцэгтээ, бусад хүмүүст бас өөртөө шударга хандаж байх болно.”

Миний сайн мэдээний жишгүүд

шударга байх ёстой.”

Нияа эргэж, дэлгүүр уруу явлаа. “Та надад илүү мөнгө хариулж өгсөн байна” гээд дэлгүүрийн эзэнд илүү мөнгийг өглөө.

Дэлгүүрийн эзэн мөнгийг аваад, “Чи сайн охин байна” гээд Нияагийн торонд хэдэн алим хийж өгөхдөө “Шударга байсны чинь төлөө баярлалаа. Энэ алимыг аваад яв. Гэрийхэнтэйгээ хувааж идээрэй” гэв.

Нияагийн сэтгэл сайхан болж, гэр уруугаа явлаа. Шударга байхаар сонгосонд нь Тэнгэрлэг Эцэг баярлах болно гэдгийг тэр мэдэж байлаа. ■





БЯМБА ГАРАГ

Улаан Өндөгний Баяр хэмээн нэрлэдэг байсан чухал баяр болоход ердөө зургаан хоног үлдээд байлаа. Олон хүн тэр өдөр сүмд өргөл өргөхөөр Иерусалимд ирж байлаа. Есүс Иерусалимын ойролцоох Бетани тосгонд явган явж ирэв. Тэр Өөрийн найз Лазар, Мариа, Марта нартай тэнд тав хоног. Мариа Түүний хөлийг тослов.

(Иохан 12:1-3-ыг үз.)



НЯМ ГАРАГ

Есүс Бетанигаас Иерусалимд явган явж ирэв. Тэрээр Хуучин Гэрээнд өгүүлсэнчлэн, илжиг унан хотод орж иржээ. Ард түмэн Түүнийг хаанаа гэж үзэн, “Хозанна,” “Хозанна” хэмээн уухайлж, Аврагчийг тоос булахаас хамгаалан илжигнийх нь өмнө далдуу модны навч дэвсэж байлаа. Есүс сүм дээр очоод тэндээсээ Бетанид буцаж ирэв.

Зехариа 9:9; Матай 21:1-11; Марк 11:1-11-ийг үз.



ДАВАА ГАРАГ

Сүм дотор хүмүүс наймаа хийж байхыг Есүс харжээ. Тэрээр сүмийг “залбирлын өргөө” байлгахыг хүсдэг учир тэднийг тэндээс хөөж гаргажээ. Дараа нь Тэр хазгар доголон, хараагүй хүмүүсийг эдгээв. Атаархуу тахилчид Түүнд уурлан хилэгнэж байв.

Матай 21:12-17; Марк 11:15-19-ийг үз.



МЯГМАР ГАРАГ

Есүс ариун сүмд бас Чидуний Уул хэмээх толгой дээр хүмүүст зааж байлаа. Тахилчид Есүсийг алахаар хуйвалдав. Дагалдагчдынх нь нэг Искариотын Иудас Есүсийг гучин мөнгөн зоосоор тахилчдад барьж өгөхөөр зөвшөөрчээ.

Матай 25:31-46; 26:14-16-г үз.

УЛААН ӨНДӨГНИЙ БАЯРЫН ДОЛОО ХОНОГ

Та нар Улаан Өндөгний баярт бэлтгэхдээ Исүс Христийн Цовдлолт ба Амилалтын өмнөх долоо хоногийн тухай судалж болно. Улаан Өндөгний баяр эхлэхээс найм хоногийн өмнөөс эхлэн өдөр бүрд зориулан жагсаасан үйл явдлууд болон судрын шүлгүүдийг унш.



5

ЛХАГВА ГАРАГ

Есүс энэ өдөр юу хийсэн тухай судруудад байдаггүй. Тэр дагалдагчидтайгаа энэ өдрийг өнгөрүүлсэн байж магадгүй. Та арван онгон охины тухай сургаалт зүйрлэл, Түүний Хоёр дахь Ирэлтэнд бэлтгэхэд нь тэдэнд туслахын тулд дагалдагчдаа Есүс хэрхэн заасан тухай түүхийг уншиж болно.

Матай 25:1–13-ыг үз.



6

ПҮРЭВ ГАРАГ

Есүсийн дагалдагчид Дээгүүр Өнгөрөх Баярын зоогийг бэлдсэн байлаа. Есүс зоогийн үеэр дагалдагчдаа тэдний нэг нь Өөрөөс нь урвах болно гэдгийг хэлжээ. Тэгээд Өөрийгөө санахад тэдэнд туслахын тулд Тэрээр ариун ёслолыг анх удаа тэдэнд өгөв. Есүс бидний нүглийн төлөө зовж, Бурханд хандан залбирахаар Гетсеманий Цэцэрлэг уруу явав. Хүмүүс илд зэвсэгтэй ирж, Түүнийг баривчлав. Дагалдагчид нь айж зугтав. **Матай 26:17–29, 36–56-г үз.**



7

БААСАН ГАРАГ

Есүсийг тэргүүн тахилч Каиаф дээр аваачив. Есүсийн дагалдагч Петр Түүнийг таньдгаа үгүйсгэв. Захирагч Пилат, Херод нар Есүсийг байцаав. Түүнийг загалмай дээр үхэх ёстой гэж ял тулгав. Есүс цовдлогдов. Иосеф гэдэг баян хүн өөрийн булшийг Есүст өгчээ. Есүсийн ээж Мариа, Магдалын Мариа хоёр булшин дээр хүрч ирэв. **Матай 26:57–72; 27:1–2, 27–37; Лук 23:44–46, 50–56-г үз.**



8

БЯМБА ГАРАГ

Есүсийн цогцсыг булшинд тавив. Хаалгыг нь том чулуугаар таглав. Булш уруу хэн ч орж чадахгүйн тулд гадаа нь харуул тавихыг хорон санаат тахилчид Пилатаас хүсчээ.

Матай 27:57–66-г үз.



УЛААН ӨНДӨГНИЙ БАЯРЫН НЯМ ГАРАГ

Христ амилжээ! Тэр булшнаас амилан боссон юм. Тэнгэр элч тэнгэрээс бууж ирэн чулууг өнхрүүлэн зайлуулсан байв.

Есүс дагалдагчдаа бусад хүмүүст зааж, тэдэнд баптисм хүртээ гэж захиад, тэдэнтэй үргэлж хамт байх болно гэж амлажээ.

(Матай 28-ыг үз.)

Дэлхий дахины хүүхдийн уран зургийн үзэсгэлэн

*“Сайн мэдээ миний амьдралыг адисалдаг”
сэдэвт Олон улсын хүүхдийн уран зургийн
тухай мэдээлэл*

Зургийн үзэсгэлэнгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг манай ирээдүйн дугааруудын Бидний хуудас хэсгээс үзнэ үү. Бусад мэдээллийг www.liahona.lds.org-аас үзнэ үү



Андреа А., нас 10, Бразил



Даша К., нас 11, Украин



Зенифф., нас 9, Мексик



Чунг-чи, нас 6, Тайвань



Бет В., нас 5, Канад



Даниел С., нас 5, Франц



Карен Л., нас 6, Болив



Натали С., нас 9, Гватемал

Каролина А., нас 7, Перу



Леонардо Т., нас 8, Чили



Сара Р. нас 9, Аргентин



Фатима Б., нас 5, Перу



Лий В., нас 9, Польш



Аддисон О., нас 10, Вьетнам




Алина С., нас 8, Украин



Ванесса Г., нас 11, Мексик



Гуен Р., нас 12, Филиппин



Лий Ж., нас 11, Тахити



Эрдэнэжаргал О., нас 8, Монгол



Аманда Ж., нас 12, Эквадор



Мартина Ф., нас 11, Аргентин



Адриана Б., нас 10, Эквадор



Хосе В., нас 5, Перу

Тусгай гэрч



Энэ сэдвээр Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Ричард Г. Скотт
бодлоо хуваалцаж
байна.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАЙН БИЙЧ

Би дэлхийн муу зүйлсээс хэрхэн ангижирч чадах вэ?

"How to Live Well amid Increasing Evil" өгүүлмээс Лиахона,
2004 оны 5-р сар, 100–102.

Танд Ариун сүнсээр дам-
жин ирэх тэрхүү хувийн
удирдамжийг эрэлхийлж
соргог байх хэрэгтэй.

Тэнгэрлэг Эцэг маань биднийг
судруудаар болон үргэлжлэн
ирэх тэнгэрлэг удирдамжуудаа-
раа дэмжин бэлддэг. Эдгээр тус-
ламжууд нь таныг өсөж буй нүгэл
хилэнцийн дунд амгалан тайван,
аз жаргалтай амьдарч чадна гэд-
гийг нотолж өгдөг юм.

Та өөрийн бодол болон зүрх
сэтгэлээ Их Эзэнд төвлө-
рүүлснээр Тэр таны эргэн
тойрон дэлхийд юу ч тохиол-
дож бай, таны амьдралыг
хангалуун дүүрэн байлгаж
өгөх болно.

Тэнгэрлэг Эцэг биднийг хамгаала-
хын төлөө бүтээсэн аз жаргалын
төлөвлөгөөг дагаснаар бид цэвэр
ариун, үр бүтээлтэй, шударгаар
амьдарч чадна.

Заримдаа амьдрал хэдий-
гээр хэцүү мэт санагдах
боловч үнэний төмөр
баруулаас зуурснаар та
өөрийн төсөөлснөөс ч
илүүтэйгээр өсөж хөгжиж
чадна.

Чи Хүүхдийн Хэсгийн энэ сарын
сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн
тулд энэ хичээл болон үйл
ажиллагааг ашиглаж болно.

Есүс Христ

бол миний Аврагч бөгөөд Гэтэлгэгч

Ана Мариа Кобурн, Кристина Франко нар

*“Христийн Цагаатгалаар дам-
жин Сайн мэдээний хуулиуд
хийгээд ёслолудад дуулгавар-
тай байснаар бүх хүн төрөлх-
төн аврагдана гэдэгт бид
итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:3).*

Чи маш их хайртай хүн-
дээ юу өгөхийг хүсэх вэ?
Аврагч Есүс Христ бидний
төлөө амиа өгөхөөр бидэнд тийм
их хайртай.

Хэрэв бид нүгэл үйлдэж, алдаа
гаргавал Түүнтэй дахин амь-
дарч чадахгүй болно гэдгийг
Тэнгэрлэг Эцэг мэдсэн юм.
Тиймээс Тэр Өөрийн Хүү
Есүс Христэд бидний
Аврагч болохыг санал
болгосон. Тэр бол нү-
гэлгүйгээр амьдарсан
цорын ганц хүн бай-
сан учраас Тэнгэрлэг
Эцэг биднийг авра-
хын тулд Түүнийг
сонгожээ.

Есүс биднийг үхэл,
нүглээс аврахын тө-
лөө зовж, үхлийг үзсэн
юм. Хайрын энэхүү
үйлдлийг Цагаатгал гэдэг.
Цагаатгалын улмаас бид
нүглээ наманчилж, уучлаг-
даж, Есүсийн адил цэвэр ариун
болж чадна.

Есүс цовдлогдож алуулсан ч
гурав хоногийн дараа амилсан.
Тэр дахин амьдарсан юм! Тэр
амилсан учраас бид бас амилуу-
лагдах болно. Энэ нь бидний бие,
сүнс хоёр үүрд дахин нэгдэнэ
гэсэн үг юм.

Есүс Христ үнэхээр бидний
Аврагч бөгөөд Гэтэлгэгч мөн. Тэр


бол бид бүгдийн хувьд төгс үлгэр
жишээ юм. Тэр бидэнд хэрхэн бие
биетэйгээ еелдэг найрсаг харьца-
хыг заасан. Тэр бидэнд бие биедээ
хэрхэн үйлчлэхийг заасан. Мөн
бидэнд хэрхэн улам сайн болохыг
заасан юм. Бид Түүнийх шиг төгс
амьдралаар амьдарч чадахгүй.
Гэвч бид зарлигуудыг дуулгавар-
тай дагаж, чадах бүхнээ хийвэл
Есүс болон Тэнгэрлэг Эцэгтэй хамт
амьдрахаар эргэж очиж чадна.

Бид Есүс Христийг өдөр бүр
дагах хэрэгтэй. ■



ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хоосон булшны дэргэд байгаа
Мариагийн зургийг бүтээхийн тулд
цэгүүдийг холбоод, зургийг буд.
Зургийг харсан үедээ Есүс Христ
бол бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч
гэдгийг чи санах болно.



Гэртээ аз жаргалтай байдаг

Чад Э.Фарез

Сүмийн сэтгүүлүүд

Бунта, Неат нар Камбожийн Сием Реапэд амьдардаг ах, дүү хоёр юм.

Бунта найман нас хүрээд баптисм хүртэхээр шийдсэн гэнэ. Неат найм хүрээд баптисм хүртэх болно. “Би Ариун Сүнс хүлээн авахыг хүсдэг” гэж тэр охин хэллээ.

Бусдад үйлчлэх нь Бунта, Неат хоёрт туйлын чухал. Бунта том болоод номлогч болохыг хүсдэг гэнэ. Неат “эмээ номлогч” буюу ахмад номлогч болохыг тэсэн ядан хүлээдэг ажээ. ■

Бунта, Неат хоёр олон цагийг хамт өнгөрүүлдэг. Тэр хоёр бие биетэйгээ болон гэрийнхэнтэйгээ эелдэг сайхан харьцахыг хичээдэг.



Тэдний хотын эртний барилгуудыг үзэхээр дэлхийн өнцөг булан бүрээс хүмүүс ирдэг. Гэвч **Бунта, Неат** хоёр гэртээ байж, гэрийнхэнтэйгээ хамт цагийг өнгөрүүлэхдээ хамгийн аз жаргалтай байдаг.



Бунта, Неат хоёр гадаа сууж, судар судлах, гэрийн даалгавраа хийж, *Лиэхона сэтгүүлийг уншдаг тусгай суралцах газартай гэнэ.* Бунта, Неат хоёр судар унших дуртай бөгөөд өдөр бүр уншихыг хичээдэг. Неат Лихайн зүүдний тухай унших дуртай, харин Бунта Нифайн тухай унших дуртай гэнэ.



Неат шилэн бөмбөгөөр тоглох дуртай, харин **Бунта** олдсон ямар ч бөмбөгөөр хамаагүй хөл бөмбөг тоглох дуртай аж.

Сайхан хувцаслаад

Кааре Ревилл

Бодит түүхээс сэдэвлэв.

“Та нар бол өөрсдийнхөө
Бурхан Эзэний хөвгүүд юм”
(Дэд Хууль 14:1).



1. Элиз гоёхыг их хүсдэг байж. Тэр аавынхаа гутлыг өмсөж, хуурамч улаан хамар зүүлээ.

2. Элиз өрөө уруугаа буцаж гүйв. Тэр шар өнгөтэй барилгачны дуулган малгай өмсөж, хуванцар алх шүүрэн авлаа.



3. Элиз өрөө уруугаа буцаж гүйхээс өмнө шалыг алхаараа нүдэв.

Би одоо мундаг барилгачин болмоо.



4. Элиз гялалзсан саатай ягаан, мөнгөлөг цайвар өнгийн гоёлын даашинз өмсөж аваад эргэлдсээр өрөөнөөсөө гарлаа.

6. Элиз унтахынхаа өмнө өөрийн дуртай ногоон унтлагын хувцсаа сольж өмсөөд, ээжийнхээ өвөр дээр суух гэж өрөөнөөсөө гарч явлаа.



5. Элизад гүнж байх нь таалагддаг ажээ. Өдрийн үлдсэн хугацаанд тэр гоёлын даашинзаа тайлсангүй.

Одоо би үзэсгэлэнт гүнж болмоо.

7.

Би Элиз байна. Би Бурханы хүүхэд.



БИД БҮГДЭЭРЭЭ БУРХАНЫ ХҮҮХЭД

Бид хаана амьдардаг, ямар-хуу харагддаг нь хамаагүй, бүгдээрээ Бурханы хүүхэд. Дээд талын дуран доторх газрын зураг дээрх хүүхдүүдийг ол. Олсон хүүхэд бүрийг дугуйлан зур.

ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Хүүхдийнхээ бие бялдрын онцлог, хувь хүний зан чанарын тухай ярилц. Хүүхдийн чинь бусдаас ялгарах өвөрмөц онцлог юу вэ? Тэнгэрлэг Эцэг биднийг хүн бүр өөр байхаар бүтээсэн боловч бид бүгдээрээ Түүний хүүхдүүд гэдгийг тайлбарла. Газрын зураг дээрх хүүхэд бүрийн өвөрмөц онцлогийг тэмдэглэхэд нь хүүхдэдээ тусал.





Гарын авлагын талаарх сургалт авралын ажилд онцгой анхаарал хандуулав

Адам К.Өүлсон

Сүмийн сэтгүүлүүд

2011 оны 2-р сарын дэлхий дахины удирдагчдын сургалтанд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд шинэ гарын авлагуудыг хэрхэн үр дүнтэйгээр ашиглах талаар оролцогчдод заварчилгаа өгсөн билээ. Уг сургалт нь гарын авлагуудыг танилцуулсан 2010 оны 11-р сарын дэлхий дахины удирдагчдын сургалтын үргэлжлэл юм.

Уг сургалтанд үг хэлэгчид гарын авлагуудыг хэрхэн ашиглах, шинэ гарын авлагууд дахь сургаалын үндсүүдийг ойлгохын чухлыг, өөрчилсөн зарчмуудыг Сүмийн хөтөлбөрүүдэд хэрхэн зохицуулах, гарын авлагуудад оруулсан өөрчлөлт нь авралын ажлыг гүйцэтгэхэд мөн зөвлөлдүүдэд эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо зэргийг онцлон тэмдэглэжээ.

Шууд нэвтрүүлэгт Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч нар Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс, Ричард Ж.Скотт, Роберт Д.Хейлс, Жеффри А.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук, Д.Тодд Кристофферсон, Нийл А.Андерсен, Далын Ахлагч Креиг К.Крисченсен, Брюс Д.Портер, В.Креиг Звик болон Туслах бүлгийн ерөнхий ерөнхийлөгчид оролцсон билээ.

Гарын авлагуудыг илүү сүнслэг нөлөөтэйгөөр хэрэглэх нь

Ерөнхийлөгч Айринг уг сургалтыг “гарын авлагыг хэрхэн үр дүнтэйгээр ашиглах талаар нээлт хийх хоёрдахь боломж” хэмээн нэрлээд, удирдагчдыг илчлэлт хүлээн авах чадвараа дээшлүүлэхийг уриалжээ.

“Та нар гарын авлагаас уншсан

зүйлсээ хэрхэн хэрэгжүүлэхийг зөвхөн Сүнсээр мэдэх болно. . . .Өдөр тутмын үйлчлэлдээ олон илчлэлт авахыг хүсч, найдах нь танд боломжгүй мэт санагдаж болно. Энэхүү олон илчлэлт нь итгэл болон шаргуу ажил хөдөлмөргүйгээр ирэхгүй боловч боломжгүй зүйл бас биш юм” хэмээн тэрбээр хэлжээ.

Ерөнхийлөгч Айринг: удирдагчид өөрсдөд нь өгөгдсөн “амьдралын үгсийг ойлгож, дагахыг” хичээн ажиллаж, залбирваас Их Эзэн тэдэнд улам илүү хүч чадлаар үйлчилж, удирдахад нь туслах болно гэж амлажээ.

Гарын авлагуудын сургаалын үндэс суурь

“Шинэ гарын авлага нь сургаалын талд голлон анхаарсан бөгөөд олон сэдвээр дүрэм журам тогтоож, удирдамж өгөхөөс зайлхийсэн учир өмнөх гарын авлагаас богинохон болсон байгаа. Үүний оронд орон нутгийнхаа нөхцөл байдалд тохируулан хэрэглэхэд. . . удирдагчдад сүнслэгээр нөлөөлөх зарчмууд гарын авлагад орсон байгаа” хэмээн ахлагч Өүкс хэлжээ.

Ахлагч Беднар, Ахлагч Кристофферсон нар удирдагчдад *Гарын авлага 2*-ын бодлого дүрэм, журмуудыг дараагийн бүлгүүдээс уншина гээд эхний бүлгүүдийг алгасаж болохгүйг анхааруулсан. Эхний бүлгүүд нь дагаж мөрдөх зарчмуудыг ойлгож, хэрэгжүүлэх сургаалын үндэс суурийг агуулж байгаа билээ.

Ахлагч Беднар “гуйвшгүй, зарчимч байх нь бидний хувьд илүү хүчтэй, гуйвшгүй сүнслэг байхад зайлшгүй тавигдах шаардлага юм гэжээ.

Өөрчлөх зарчмууд

“Бид гарын авлагад буй Тэргүүн Зөвлөл болон Арванхоёроос гаргасан сургаал, зарчим, бодлогын чанартай асуудлуудаас ангид байдаггүй.” “Орон нутгийн нөхцөл байдалд тохируулан зарим үйл ажиллагааг өөрчлөхийг зөвшөөрдөг” гэж Ахлагч Нелсон хэлжээ.



“Гарын авлагыг ашиглан бусдыг мөнхийн амьдрал өөд удирдан хөтөлж, тэдэнд туслахад тань энэхүү гарын авлага мэдээллийн үнэ цэнэтэй эх сурвалж болно. Энэ бол гарын авлагын зорилго юм” гэж Ахлагч Хейлс үгээ төгсгөжээ.

Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Ахлагч Портерын хэлсэнчлэн “Нэгдмэл бөгөөд хялбар дөхөм байх” гэсэн 17-р бүлэгт орон нутгийн удирдагч ямар үед зарим хөтөлбөрт өөрчлөлт хэрэгтэйг Сүнсээр удирдуулж шийдвэрлэх хэрэгтэй. Уг бүлэгт юуг өөрчилж болохгүй болон өөрчлөлт хийж болох таван нөхцөлийг өгсөн байгаа. Энэ таван нөхцөлд: гэр бүлийн нөхцөл байдал, тээвэр холбоон хүрэлцээ дутмаг байх, цөөн гишүүдтэй чуулга ба ангиуд, удирдагчдын тоо хангалтгүй байх болон аюулгүй ажиллагаан зэрэг нь орно.

Далын Ахлагч В.Креиг Звигийн хэлсэн үгэнд, “Тохиромжтой өөрчлөлтүүд нь Сүмийг сул дорой болгохгүй харин хүчирхэгжүүлдэг” хэмээн заасныг Ахлагч Портер эш татан тэмдэглэсэн юм. Орон нутгийн удирдагчид сүнсээр нөлөөлөгдөж, өөрчлөлтүүдийг хийхдээ уг ажил, үйл ажиллагаа төгс биш байна гэж санаа зовох хэрэггүй. “Сүмийн нэгж бүрд аврал, өргөмжлөлд хүрэхэд Бурханы хүүхдүүдэд зайлшгүй хэрэгтэй сургаал, гэрээнүүд, санваарын хүч болон Сүнсний бэлэг байдаг” гэж Ахлагч Портер бичжээ.

Авралын ажил

Гарын авлага 2-д орсон бүх өөрчлөлт нь авралын ажлыг улам гүнзгийрүүлэн тусгасан болно. Ерөнхийлөгч Айринг хэлэхдээ, “гарын авлагыг ашиглан бусдыг мөнхийн амьдрал уруу удирдан хөтөлж, тэдэнд туслахад тань энэхүү гарын авлага үнэт мэдээллийн эх сурвалж болно. Энэ бол уг гарын авлагын зорилго юм” гэжээ.

5-р бүлэгт гишүүдийн номлолын ажил, хөрвөгчийн идэвх, гишүүдийг идэвхжүүлэх, ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажил, сайн мэдээг заах зэрэг урьд нь тус тусад нь авч үздэг байсан сэдвүүдийг “Тойрог болон гадас дахь авралын ажиллагаа” гэсэн нэг гарчигт багтаасан.

“Энэ эрин үед, энэ нь цагийн дүүрнийг гүйцэлдүүлэхийн тулд, бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ” (Ефес1:10-г үз.) “Нэгдмэл нэг л ажил байдаг” хэмээн Паул хэлсэн юм” гэж Ахлагч Беднар дурджээ.

Жишээлбэл урьд нь хүмүүс Сүмийн “бие даасан ажил үүрэг гэж үздэг байсан зарим ажил нь өөр талбар дахь мөн л тэр ажил юм”



ГЭРЭГ ЗУЛГИЙГ КРЕЙГ ДАЙМОНД © ИИ

гэж тэр хэлжээ. Номлолын ажил гэдэг нь сайн мэдээг тунхаглаж, ариун ёслолуудыг хүлээн авч, гэрээнүүд байгуулахад бусдыг урих явдал юм. Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх гэдэгт Сүмд гишүүдийг идэвхтэй байлгаж, идэвхгүй гишүүдийг идэвхжүүлэн, заах зэрэг нь орох бөгөөд энэ нь хүмүүсийг ёслолууд болон гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандахад урих ажил мөн. Гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажлаар дамжуулан нас барагсдыг гэтэлгэх нь нас барагсдад ёслолуудыг хүлээн авч, гэрээнүүд хийх боломжийг олгож байгаа явдал мөн.

Ер нь бол гарын авлагад орсон өөрчлөлтүүд Туслах бүлэг болон чуулгын удирдагчид тойргийн зөвлөлд зөвхөн өөрсдийн чуулга, туслах бүлгийн гишүүдийг анхаарах төдийгүй бүх гишүүдийн сүнслэг, сайн сайхан байдлын төлөө үүрэг хариуцлага хүлээдэг гэдгээ ойлгоход нь туслах болно гэж Ахлагч Холланд хэлжээ.

Ахлагч Кук *Гарын авлага 2*-ын зарим өөрчлөлтүүд нь авралын ажилд хэрхэн түлхэц үзүүлэх талаар тодруулахад тусалсан билээ.

Тусад нь хийдэг байсан халамжийн хурал байхгүй болсон тул бишоп болон тойргийн зөвлөлийн халамжийн хурал их чухал болсныг тэрбээр онцлон тэмдэглэсэн юм. Мөн Мелкизедек санваартны удирдагчид чуулгын гишүүдтэй зөвлөлдөх үүрэг нь өсөн нэмэгдсэнийг тэр тайлбарласан. Цааш нь тэрбээр зарим нөхцөлд ариун сүмд орохоор бүрэн зохистой биш эцгүүд гэр бүлийнхээ гишүүний ёслол болон адислалуудад оролцож болох тухай өөрчлөлтүүдийг тодруулж тайлбарласан билээ.

Авралын ажилд, санваарын удирдагчид тухайн хүн одоо ямар ёслол хүлээж авах шаардлагатай байгаа, тэр ёслолыг хүлээн авах бэлтгэлд нь хэрхэн туслах талаар бодох хэрэгтэй.

ТУСЛАХ БҮЛГИЙН ДУУДЛАГАТАЙ ХҮМҮҮС СУРГАЛТЫН ШИНЭ НОМЫН САНГ АШИГЛАНА

2011 оны 2-р сарын дэлхий дахины удирдагчдын сургалтын үеэр Сүмийн туслах бүлгүүдийн ерөнхий ерөнхийлөгчид сургалт явуулсан хүмүүсийн сүүлчийн хамтарсан ярилцлагуудад оролцсон. Эдгээр ярилцлагуудыг онлайн сургалтын жишээ болгон тавьсан байгаа.

Удирдагчдын сургалтын номын сан нь дэлхий даяар үйлчилж байгаа удирдагчдад зориулсан *Гарын авлага 2* дахь жишээ зарчмуудын бодит амьдрал дахь жишээний цуглууллага юм. Энэ бичлэгийг Бразил, Англи, Гватемал болон Солонгост хийсэн бөгөөд 2011 оны сүүлч гэхэд онлайн тавигдана.

Туслах бүлгийн ерөнхий ерөнхийлөгчид энэхүү бичлэгийг ашиглан Арванхоёр Төлөөлөгчийн Чуулганы Ахлагч Роберт Д.Хейлс, Нийл Л.Андерсен, Далын Ахлагч Крейг К.Крисченсен нарын удирдлага дор *Гарын авлага 2* дахь гурван чухал зарчмыг авч хэлэлцсэн билээ.

1. Сүнслэгээр бэлтгэ

Өмнөд Солонгосын Нийгмийн Халамжийн Бүлгийн нэг удирдагч хурлаа төлөвлөх үедээ чин сэтгэлээсээ сүнслэг удирдамж хүсч, үүнийгээ хүлээж авсан тухай жишээг үзээд Хүүхдийн Хэсгийн ерөнхий ерөнхийлөгч Розмари Виксом “Их Эзэн бидэнд туслахаар харж, хүлээж байдаг нь үнэхээр гайхалтай” гэжээ.

Виксом эгч болон Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Жули Б.Бектэй ярилцаж байхдаа, “Энэ бол сүнслэг ажил хэрэг, Их Эзэний тусламжгүйгээр бид энэ ажлыг гүйцэтгэж чадахгүй” гэж хэлсэн байна. Ярилцлага хийсэн бүх гишүүд сүнслэгээр бэлдсэнээр хувь хүмүүс дээр анхаарал төвлөрүүлж, үйл ажиллагаа, хичээл, үүрэг даалгавруудыг тэдний хэрэгцээг шийдвэрлэхэд чиглүүлэх боломж олгосон юм. “Бидний хэн нь ч илчлэлт хүлээн авч чадна” гэж Ахлагч Андерсен гэрчилжээ.

2. Зөвлөлүүдэд оролц

Гватемалын нэг тойргийн зөвлөлийн гишүүд нэгэн гэр бүлийг Сүмд идэвхтэй болгохоор амжилттай хамтран ажилласан тухай түүх нь Ахлагч Крисченсенд “зөвлөлийн гишүүд хэрхэн хамтран ажиллах” тухай ярилцлага хийхэд тусалжээ. Энэхүү ярилцлагад Бэк эгч, Виксом эгч, ням гарагийн хичээлийн ерөнхий ерөнхийлөгч Рассел Т.Осгурф, Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Элейн С.Далтон болон Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Давид Л.Бэк нарын Туслах бүлгийн таван ерөнхийлөгч оролцжээ.

Сүүлчийн хамтарсан ярилцлагад оролцогчид зөвлөлийн гишүүдийн нэгдмэл хүч чармайлт нь тойргийн гишүүдийн өсөлт хөгжилтөд хэрхэн тусалдаг тухай, идэвхтэй зөвлөлийн гишүүд бишопын ачаанаас хэрхэн хөнгөвчлөх, гишүүд, удирдагчид хэрхэн нэг нэгнээ сонсож, бие биетэйгээ хуваалцан тойргийн гишүүдийн талаарх Их Эзэн хүслийг хэрхэн эрэлхийлэх зэрэг асуудлуудыг хэлэлцсэн юм.

3. Бусдад үйлчил

Гуравдахь бичлэг нь Англид нэгэн залуу эр Сүмд бүрэн идэвхтэй байхын тулд хэрхэн хичээж байгаад анхаарал хандуулдаг. Ахлагч Хейлсээр удирдуулсан сүүлчийн хамтарсан хэлэлцүүлэгт Осгурф ах, Бек ах, Далтон эгч нар орсон бөгөөд удирдагчид эцэг эхчүүдтэй, Сүмийн зөвлөлд залуучуудтай хамтран ажиллахын чухлыг тэд хэлэлцсэн.

“Хэрэв та өнөөдрийн үзсэн бичлэгүүдийн тухай харилцан ярилцаж, үүний дагуу ажиллаж, Их Эзэнд хандваас. . .та бусдад тусалж, тэднийг хүчирхэгжүүлэн, дуудлагаа гүйцэтгэхэд удирдан чиглүүлэгдэх болно. ■

“Бид бол янз бүрийн хөтөлбөрүүд зохион байгуулж, байгууллагаа удирддаг бизнесийн байгууллага” гэж Ахлагч Беднар хэлжээ. “Хөтөлбөрүүд зохион байгуулж, байгууллагыг удирдах нь шаардлагатай зүйл, гэхдээ энэ нь хамгийн чухал ажил биш. Бидний хийдэг ажил бол авралын ажил. Бид ёслол болон гэрээнүүдийн тухай бодох үед, санваарын удирдагчид энэ хүн, эсвэл энэ гэр бүлд одоо ямар ёслол хүлээж авах шаардлагатай байгаа, тэр ёслолыг хүлээн авах бэлтгэлд нь бид хэрхэн дэмжиж туслах вэ? гэдэг асуултыг өөрсдөөсөө асуух хэрэгтэй”.

Зөвлөл дэх эмэгтэйчүүд

Зарим газарт удирдагчид хамтран зөвлөлдөх үед эмэгтэйчүүдийг оролцуулагдаггүй талаар санаа зовниж

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ОНЛАЙНААС ҮЗЭЖ БОЛНО

Дэлхийн удирдагчдын сургалтын нэвтрүүлгийн дуу бичлэг, дүрс бичлэг болон бичвэрийг [lds.org/menu/service/serving-in-the-church](https://www.lds.org/menu/service/serving-in-the-church) гэсэн хаягаар орж үзэж болно.

Гарын авлага 2-ыг [lds.org/handbook/handbook-2-administering-the-church](https://www.lds.org/handbook/handbook-2-administering-the-church) гэсэн хаягаар, шинэ Удирдагчдын сургалтын номын сан [lds.org](https://www.lds.org) хаягийн *Serving in the Church* хэсэгт 2011 оны дунд үе гэхэд бэлэн болж тавигдана.



Эрэгтэй эмэгтэй хэн ч бай удирдагчдын хуралд санал бодлоо чөлөөтэйгөөр илэрхийлэх ёстой гэж Сүмийн удирдагчид хэлжээ.

байгаагаа Ахлагч Скотт илэрхийлсэн. “Тойргийн зөвлөлийн хуралд [эмэгтэйчүүд] чөлөөтэй оролцох боломжтой үед тэдний санал бодол үргэлж хэрэгтэй бас урам дэм өгдөг” гэж тэр хэлжээ.

Удирдагчид эгч нарыг нэрээр нь дуудан, тэдний бодол санаа, зөвлөгөөнд талархлаа илэрхийлж, тэдний оролцоог урамшуулж байх хэрэгтэйг Ахлагч Скотт тайлбарласан.

Тэрээр цааш нь нэмж хэлэхдээ: “Эдгээр удирдамжуудыг дагадаг бөгөөд гэр орондоо гүйцэтгэдэг эхнэрийнхээ ариун үүрэгт илүү их хүндэтгэлтэй хандаж, өндөр үнэлдэг санваартны удирдагчдын гэр оронд нэмэлт адислалууд ирдэг” гэжээ.

Тэрбээр зөвлөлийн гишүүд хоорондоо эв нэгдэлтэй байхын чухлыг заажээ. Удирдагч шаардлагатай гэж үзвэл санал хураах аргыг хэрэглэж болно. Жишээлбэл гишүүд санал зөрөлдөх үед удирдагч тойргийн зөвлөлийн гишүүн бүрээс санал асууж, тэдэнд санал бодлоо хуваалцсанд нь талархаад, шийдвэрээ гарган зөвлөлийн гишүүдээс шийдвэрийг бүгд дэмжиж байгаа эсэхийг нь асууна. Ахлагч Скотт тойргийн зөвлөлөөр асуудлуудыг хэлэлцэх үед нууц хадгалж байхын чухлыг мөн онцлон тэмдэглэсэн билээ.

Хүлээгдэж буй үр дүн

Ахлагч Нелсон сургалтыг хааж хэлсэн үгэндээ: Өөрчлөн тохируулж хэрэглэх нь гишүүдийн цаг зав, хүч чадлыг илүү үр дүнтэй ашиглах боломж олгодог, санваартнууд Сүмд гэр бүл болон хүн нэг бүрийг адисалснаар санваартны хүч чадал өсөн нэмэгдэж, гишүүн бүр сахилга баттай, сүсэг бишрэлтэй байх болно гэсэн гурван санааг илэрхийлсэн юм. ■

МЭДЭЭГЭЭР

Ахлагч Перри Гуамын анхны гадсыг зохион байгуулав

Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л.Том Перри 2010 оны 12-р сард Гуамд айлчлан, Гуамын нутаг дэвсгэр дэх анхны гадас— Гуамын Баригада гадсыг зохион байгуулжээ. Дэлхийн II дайнд Нэгдсэн Улсын тэнгисийн цэргт алба хашиж байсан Ахлагч Перри тэнд айлчлах үеэрээ хөрш Сайпан аралд оршдог Номхон далайн бүсийн Дайны Музейг үзжээ. Гуамд эдүгээ Сүмийн 1971 гишүүн амьдардаг байна. Гуамын нутаг дэвсгэр нь Сүмийн Хойд Азийн Бүсд хамрагддаг.

ХҮГ эмч нар Папуа Шинэ Гвинейд булчин задрах тахал өвчнийг эмчлэв

2010 оны сүүлчээр Австралаас цөөн тооны ХҮГ эмч нар Папуа Шинэ Гвинейн баруун хойд хэсэгт орших алслагдсан тосгонуудад булчин задрах тахал өвчтэй хүмүүсийг эмчилжээ.

Эмч нар олон зуун өвчтөнтэй ажилласан бөгөөд нэг эрэгтэй эмнэлэгт ирэхдээ маш их дордсон хэзээ хэзээгүй амьсгал хураах болчихоод байсныг эмчилж эдгээсэн байна. Мөн өөр олон өвчтөн тэднээр эмчлүүлээгүй бол хоног хүрэлгүй хорвоог орхих болчихоод байсныг эмчлэн эдгээсэн аж.

Өвчтөнүүд газраар болон завиар эмч нар дээр ирж байлаа. Брисбанаас ирсэн Давид

Виллямс, Кайрнаас ирсэн Антони Мехлер нар, Согер гэдэг тосгонд очсон өдрөө л булчин задрах тахлаар өвчилсөн 200 гаруй өвчтөнийг эмчилсэн гэнэ. Энэ тухай Мехлер эмч, хэдийгээр маш хэцүү, бүр ядарч сөхөртлөө ажиллаж байсан ч “[Энэ] бол эмч хүний хувьд амьдралын минь хамгийн сайхан мөч байлаа” гэжээ.

Сүм эдгээр эмч нараас гадна бас эм тариа, ус цэвэршүүлэгч зэрэг тусламжийн барааг илгээсэн билээ. Хямрал тохиолдсон нутгуудад Порт Моресби хотын Сүмээс хүнс, саван зэргийг мөн Брисбан, Порт Моресби хотоос ариун цэврийн иж бүрдэл бүхий цүнхнүүдийг тус тус илгээжээ. Усаар эмчилгээ хийх туршлагатай гэр бүлийн ахмад номлогчид Папуа Шинэ Гвиней уруу аврах ажилд туслахаар явав.

Энэ DVD 2011 оны Мючел сэдвийг танилцуулж байна

Сүмээс Залуучуудыг хүчирхэгжүүлэх талаар *Бид итгэдэг* 2011 DVD-ийг 2011 оны Мючел сэдвийг дэмжих зорилгоор нэгдүгээр сард дэлхий даяар Сүмийн бүх нэгжүүдэд хувиарлан хүргүүлэх болно.

Уг DVD-ийг залуучууд Итгэлийн Тунхаг 1:13-г амьдралынхаа чухал хэсэг болгоход туслахаар зориулж хийсэн юм. Үүнд Ерөнхийлөгч Томас С.Монсон, Залуу Эрэгтэйчүүд ба Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчдийн хэлсэн үг, дуу

ДЭЛХИЙ ДАХИНД

Олон улсын уран зургийн 9 дэх уралдааны бүтээлүүдийг Сүм хүлээн авч байна

Сүмийн Олон улсын уран зургийн 9 дэх уралдаанд оролцох бүртгэлийн маягтыг Сүмийн Түүхийн Музей 2011 оны 4-р сарын 4-нд онлайнд тавих болно. Уралдаанд оролцох бүтээлүүдийг 2011 оны 10-р сарын 7 гэхэд онлайнаар буюу шуудангаар ирүүлсэн байх ёстой. Энэ уралдаан “Түүний гайхамшигт ажлуудыг хүмүүсийн дунд мэдүүлэгтүн” (С ба Г 65:4) сэдэвтэй байна. Нэмэлт мэдээллийг англи хэл дээр авах буюу өмнөх уралдаанд байр эзэлсэн бүтээлүүдийг lds.org/churchhistory/museum/competition хаягаар орж үзээрэй.

Шинэ Гэрээний түүхүүд амьдралд хэрэгжиж байна

2011 оны Шинэ Гэрээний сургалтын хөтөлбөрийг дэмжихээр *Шинэ Гэрээний түүхүүд* номын дүрс бичлэгүүдийг паралакс гэдэг аргаар өөрчлөөд байна. 65 дүрс

бичлэг англи хэл дээр гарсан бөгөөд LDS.org хаягаас MP3 дээр 11 хэлээр хуулбарлаж авах боломжтой. Паралакс дүрс бичлэгүүдийг 2011 онд дээрх хэл бүр дээр үзэх боломжтой болно. Дүрс бичлэгүүдийг scripturestories.lds.org хаягаар орж **New Testament Stories**. хэсгийг сонгож авах боломжтой.

Бангалорын Залуу эрэгтэйчүүд Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх шийдвэр төгс байна

Энэтхэгийн Бангалор дүүргийн 30 гаруй залуу эрэгтэйчүүд Бурханы өмнө хүлээсэн үүрэг болон биеийн хүч шаардагдах үйл ажиллагааны сүнс-лэг туршлагаас суралцахаар Канакапура толгойн энгэрт цуглажээ. Залуу эрэгтэйчүүд дугуйт өргүүр болон олс ашиглаж, нуурыг гаталсан аж. Тэд өглөө гүйж, ууланд авирч, уулын уруу гулсан бууж сурчээ. Тэд үйл ажиллагаагаа гэрчлэл хуваалцах цуглаанаар өндөрлөв. ■

хөгжим, залуучуудын гэрчлэл болон бусад зүйлс орсон байгаа.

DVD-ны ихээхэн хэсэг нь залуучуудын гэрчлэл болон урам хайрласан туршлагауд юм.

Дуу хөгжим, захиас болон гэрчлэлүүдийг залуучуудын анги, цуглаан, үйл ажиллагаануудыг баяжуулах зорилгоор жилийн турш ашиглаж болно.

Бүх материалыг youth.lds.org гэсэн хаягаар орж хуулбарлан авах боломжтой.

DVD-ийг хятад, англи, франц, герман, итали, япон, солонгос, португаль, орос, испани хэлээр үзэх боломжтой. ■

ШИНЭЧИЛ

2011 оны 1-р сарын *Лиакхона*-д Айвори Костаг үйлчилж байгаа гадаадын номлогч нарын тухай өгүүлдэг (Самуел Гоулд, “Тэнгэр элчүүдийн оршихуйд,” хуудас 50-г үз). Энэ дугаар хэвлэгдэн гарсны дараахан Айвори Костын байдал өөрчлөгдөж, гадаадын номлогчдыг өөр газар уруу томилжээ. Сүм номлогчид үйлчилж байгаа орнуудын улс төрийн байдлыг үргэлж анхааралтай ажиглаж байдаг бөгөөд шаардлагатай гэж үзвэл номлогчдыг шилжүүлдэг юм. Байдал сайжирсан гэж үзсэн үед л номлогчид буцаж очдог юм.



Шинэ Гэрээний сонгодог түүхүүдийн дүрс бичлэгүүдийг scripturestories.lds.org. гэсэн хаягаар орж үзэх буюу сонсох боломжтой.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Тэр бидний ачааг үүрдэг

Би энэ сэтгүүлд их дуртай. Би Тэргүүн Зөвлөлөөс гаргадаг нийтлэлүүд ялангуяа чуулган дээр тэдний хэлсэн үгсийг унших их дуртай. Тэд бидэнд бэрхшээлээсээ шантралгүй, үргэлж урагш тэмүүлэхийг зааварлаж, урамшуулан дэмждэг юм.

Би 26 жил Сүмийн гишүүн байгаа бөгөөд энэ хугацаандаа *Лиахона* сэтгүүлийн бүх дугаарыг нь уншсан. Би сэтгүүлийн хуучин дугааруудыг байнга уншдаг. Надад хамгийн эрхэм дотно санагдсан нийтлэл бол ахлагч Давид А.Беднарын “Их Эзэний энэрэнгүй нигүүлсэл” (2005 оны 5-р сар, 99) билээ. Энэ нийтлэл надад Тэнгэрлэг Эцэг бидэнд хэр зэрэг их нигүүлсэл үзүүлж, бидний хүнд ачаанаас үүрэлцдэг болохыг санахад минь тусалдаг юм.

Ёоланда Валенти, Итали

Сургаал үргэлж Их Эзэнээс ирдэг

Би сар болгон амьд бошиглогчдын үгийг сонсох боломжтой байдагтаа талархдаг. Тэдний заадаг зүйлс Их Эзэнээс ирдэг бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлбэл амьдрал маань адислагдах болно гэдгийг би мэддэг. Дэлхий даяарх Гэгээнтнүүдийн туршлагыг уншсанаар миний итгэл, гэрчлэл нэмэгддэг, яагаад гэвэл тэд бэрхшээлүүдээ хэрхэн даван туулдгийг би мэдсэн юм.

Бейрон Давид Калдерон Москва, Эквадор

Санал хүсэлтээ liahona@ldschurch.org хаягаар илгээнэ үү. Ирүүлсэн материалуудыг хэмжээ, тодорхой байдлын хувьд хянан засварлаж болно. ■

ГЭР БҮЛИЙН ҮДШИЙН САНААНУУД

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглаж болох өгүүлмүүд, үйл ажиллагаанууд багтсан. Зарим жишээг доор харуулав.

“Түүнийг үргэлж санахын тулд” 20-р хуудас:

Ахлагч Кристофферсоны өгсөн “Бид хийдэг бүх зүйлээ эргэн харж, цэгнэн, Аврагчийг амьдралынхаа гол төвд тавьж, хамгийн чухал зүйлсийг эн тэргүүнд анхаардаг болж, амьдралаа шинээр төлөвшүүлэхээс эхэлж болно” гэсэн зөвлөгөөг гэр бүлээрээ харилцан ярилцаарай. Ахлагч Кристофферсоны өгүүлсэн “Аврагчаа үргэлж санаснаар” ирэх адислалуудыг мөн харилцан ярихаар бодож үзээрэй.

“Судрын хүч” 52-р хуудас: Энэ нийтлэлийг уншаад, гэр бүлийн гишүүдээс судраас унших болон семинарт явах талаарх санаа бодлоо хуваалцахыг хүс. Судрын хүчний тухай өөрсдийн гэрчлэлийг өдрийн тэмдэглэлдээ бичихийг тэднээс хүс. Хүүхдүүдээ төгс эзэмших судруудыг судалж, тэдгээрийг цээжлэхэд нь урамшуулан дэмж.

“Есүс Христ Зууч” 56-р хуудас: Өгүүллийг унших явцаа Зуучийн тухай анхааралтай сонсохыг гэр бүлийн гишүүдээсээ хүс. Хүн төрөлхтний өрийг Зууч төлж туслаагүй бол юу тохиолдох байсан бол гэж тэднээс асуу. Аврагч бол Зууч гэсэн судруудыг уншиж, харилцан ярилцаж болно. Холбогдох судрууд: 2 Нефай 2:27–28 ба Алма 42:24–25-ыг уншихыг бод.

“Сайхан хувцаслаад,” 70-р хуудас: Гэр бүлийн гишүүдийг ямар нэг дүрийн хувцас өмсөх эсвэл хэн нэг хүн болон хувирахыг хүс. Хүн

болгоныг тэд хэний дүрд тоглосноо хэлэхийг хүс. Түүхийг уншсаны дараа, бид хэний ч дүрд хувирсан бай бүгдээрээ Бурханы хүүхдүүд хэвээрээ байдгийг тайлбарла.



Аз жаргалтай мөчүүд ба мөнхийн холбоо

Манай хүүхдүүд бага байхдаа гэр бүлийн цуглааны дараа тоглох дуртай байлаа. Тэдний тоглох дуртай нэг тоглоом нь “Бүдүүн хошуут заан” гэдэг нэртэй бөгөөд Жоселен охиныхоо сургууль дээрээ сурсан дууны нэрээр нэрлэсэн байлаа. Бид дууг дуулсны дараагаар би заан болж хүүхдүүдээ нуруун дээрээ суулган явдаг байв. Хамгийн түрүүнд хоёр настай Хорге хүүгээ, дараа нь дөрвөн настай Жоселеныгаа, хамгийн сүүлд нь эхнэр Элизабетаа суулган тоглодог байлаа. Тэгээд гурвууланг нь хамт суулгачихаад зочны өрөөгөө тойрон явна даа. Бид маш хөгжилтэй байдаг байсан.

Олон жилийн дараа манай хоёр хүүхэд насанд хүрч, хоёул номлолын дуудлагаа хүлээж байв. Нэг гэр бүлийн үдшийн үеэр хүүхдүүд маань “Бүдүүн хошуут заан” тоглоомоо дурсаж билээ. Бид нөгөө дуугаа дуулж, олон жил завсарласны дараа би дахиад л заан болон хувирлаа. Эхлээд хүү маань, дараагаар нь охин, эцэст нь эхнэр маань миний нуруун дээр гарлаа. Би тэднийг даалгүй шалан дээр хэвтээд өглөө. Бид бүгдээрээ элгээ хөштөл инээлдэж билээ.

Үүнтэй төстэй дурсамжууд маань, гэр бүлийн үдшээ хийж байхыг сургасан бошиглогчдод талархах сэтгэлийг бидэнд төрүүлдэг юм. Бид гэр бүлийн үдшээ хэчнээн энгийн хийдэг ч, мөнхийн холбоогоо бэхжүүлэхэд тусалдаг гэр бүлийн аз жаргалтай мөчүүдийг хамтдаа өнгөрөөх боломжтой байх нь хамгийн чухал юм гэдгийг ойлгосон билээ. ■

Виктор Ж. Чауса Ревера

ҮҮРГЭНЭН ТИТЭМ, ЯЛАЛТЫН ТИТЭМ

Ларри Хиллер

Сүмийн сэтгүүлүүд

Ариун нутаг дахь наймдугаар сар. Бидний эргэн тойронд Капернаумын балгас үдээс хойшийн бүгчим халуунд зэрэглээтэн сүүмэлзэнэ. Энэ хот үзэсгэлэнтэй сайхан байсан бололтой, гэвч бидний хөтөч, дэргэдэх царцаа хоёр дүнгэнэлдсээр миний бодол санаа хол бэлчиж байлаа.

Тэгтэл хөтөч биднийг сүүдрээрээ халхалж байсан модыг гэнэт зааж, “Хүмүүс энэ модыг ‘үүргэнэн титмийн’ мод гэдэг юм” гэж хайхрамжгүйхэн хэлэхэд би давхийн цочоод, дээшээ тэр модны саглагар навчтай мөчрүүдийг харлаа. Өргөс нь хаанаа байдаг юм бол? Модонд хүрээд хамгийн наад талын нэг жижигхэн мөчрийг болгоомжтой татлаа.

Нарийхан навчнуудын голд өргөс байхыг харлаа. Туяхан, ногоон, ер бусын хурц, уртаараа миний эрхий хуруун дайтай өргөсүүд хэдэн алхмын цаанаас харагдахааргүй ажээ. Гэвч нарийхан навч шиг харагдах мөчирт хүрсэн хүн өргөсөнд хатгуулж өвдөхийг мэдэрнэ.

Доромжлон тохуурхагч шүүх хурал дээр ягаан нөмрөгтэй, Аврагч хатсан үүргэнэн титэм өмсөн зогсож байгаа олон зураг харснаа саналаа. Нэг боол эсвэл цэрэг хатсан хуурай мөчрөөр биш, харин миний дээр харагдаж байсан зөөлхөн ногоон мөчрүүдээр титэм хийж эхлэх шиг надад гэнэт санагдав. Өргөст титэм сүлжсэн нь зүгээр нэг өвтгөх биш харин доог тохуу болгох зорилготой байсан нь тодорхой юм.

Эрт үед анхилуун үнэртэй лаврын ногоон саглагар мөчрөөр хэлхээ сүлжиж, тулалдаанд ялагчдад өгдөг байжээ. Лаврын




*Миний хувьд
үүргэнэн титэм нь бидний бүх нууц зовлонг Аврагч мэддэгийн болон биднийг тайвшруулах Түүний чадварын бэлгэдэл болсон юм.*

хэлхсэн ногоон мөчрөөр хаад, эзэн хаадын дүрийг чимэглэдэг байв. Аврагчийн духан дээрээс дарж байсан өргөст титмийн хэсэг нь эрт үеийн хаадад үзүүддэг байсан хүндэтгэлийг егөөдөн саглагар ногоон навчтай байсан болов уу. Энэ бол ердөө таамаглал болохоос сургаалын асуудал биш. Гэвч миний хувьд тийнхүү төсөөлөн бодох нь, Аврагч бидний зовлонг мэддэг, биднийг эдгээх чадвартай гэсэн Цагаатгалын энэ талыг илүү тодорхой ойлгож, үүн дээр анхаарал төвлөрүүлэх боломжийг олгодог билээ.

Түүнд нөмрөг өмсгөсөн нь хаан язгуурын бэлгэдлийг дооглон тохуурхсан явдал мөн. Түүнийг ташуурдахад нөмрөг ташуурын сурнаас биеийг нь халхалж байжээ. Үүнчлэн, өргөст титмийн өтгөн ногоон навч нь тулалдаанд ялагчийн цэцгийн хэлхээ болж, өргөс хатгаж өвтгөхийг халхалж байсан болов уу.

Бидний олонх нь үл харагдах сэтгэлийн шаналгаатай байдаг. “Хүн бүрийн зүрх сэтгэлд үл харагдах зовлон байдаг” хэмээн нэг дуулалд өгүүлдэг билээ (“Lord, I Would Follow Thee,” *Hymns*, no. 220). Гэвч Их Эзэн хардаг. Тэр хүн нэг бүрийн зовлонг сайн мэддэг. Түүний үйлчлэл бүхэлдээ Цагаатгал болон Амилалтад бэлтгэхэд чиглэгдсэн юм. Гэвч Түүний зааж, эдгээж байсан хүмүүс үүнийг мэдээгүй юм. Тэр байтугай Түүний дагалдагчид ч үүнийг мэдээгүй үлдсэн юм.

Аврагч бидний зовлон зүдгүүрийг бусдын нүднээс далдлан нуудаг “халхавч,” “өргөсүүдийг” урьдаас хардаг. “Бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг” (Алма 7:11–12-ыг үз) хүлцэн тэвчсэн Тэрээр нигүүлслээр дүүрэн бөгөөд ачаа дарамтаа Түүнд үүрүүлвэл бидэнд хэрхэн тусалдгийг мэддэг билээ. Гүнзгий бөгөөд нуугдмал шархыг эдгээдэг гавар Түүнийх юм. Бидэнд Түүний санал болгодог титэм үнэхээр ялалтын титэм. ■



Амилалтын өглөө Стийвен Эдвардс

Христ мөнх бус үйлчлэлийнхээ үед “Хүний Хүү . . . алуулаад гурав дахь өдрөө амилна” гэж дагалдагчдадаа хэлжээ (Лук 9:22).

Түүнийг цовдлуулсны дараа, “Магдалын Мариа болон нөгөө Мариа нар булшийг үзэхээр ирэв.

“Харагтун, маш хүчтэй газар хөдлөлт болжээ.

Учир нь Эзэний тэнгэр элч тэнгэрээс бууж ирэн чулууг зайлуулаад дээр нь суужээ. . . .

Тэгтэл тэнгэр элч эмэгтэйчүүдэд, Бүү ай. Загалмайд цовдлогдсон Есүсийг хайж байгааг чинь би мэдэж байна.

Тэр энд байхгүй. Учир нь хэлж байснаараа Тэр амилсан” (Матай 28:1–2, 5–6).



“**А**врагчийг санана гэдэг нь Түүний Цагаатгалыг санахыг өөртөө агуулдаг ба Цагаатгал нь Түүний зовлон болон үхлийг талх, усны бэлгэдлээр төлөөлүүлдэг. Тэр бидний төлөө юу хийснийг бид хэзээ ч мартаж өсгүй. Учир нь Түүний Цагаатгал болон Амилалтгүйгээр амьдрал утга учиргүй байсан. Харин Түүний Цагаатгал болон Амилалтын ачаар бидний амьдрал мөнхийн хэтийн төлөв, бурханлиг олон боломжтой юм” гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Д.Тодд Кристофферсон бичжээ. “Түүнийг үргэлж санахын тулд” хуудас 20-ийг үз.